



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАНАРЫН СУДАЛГАА





Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Европын Холбоо
санхүүжүүлэв

“Энэхүү судалгааны тайлан нь Европын Холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Судалгаа нь Европын Холбоо болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй болно.”



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАНАРЫН СУДАЛГАА

Улаанбаатар хот
2022 он

ХЯНАСАН:

Д.Сүнжид	<i>ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор</i>
З.Өнөржаргал	<i>ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга</i>
О.Тодбулаг	<i>ХЭҮК-ын Хүний эрхийн боловсрол хариуцсан референт</i>

БОЛОВСРУУЛСАН:

Б.Нямжав	<i>Ахлах судлаач, “Амьдрал өгөх” сангийн тэргүүн</i>
Г.Түвшинжаргал	<i>Хуульч, Судлаач</i>

ТУСЛАХ СУДЛААЧИД:

Д.Эрдэнэцогт	<i>Судлаач, Эрчүүд, гэр бүл, хүүхэд хөгжлийн нийгэмлэгийн тэргүүн</i>
Э.Уянга	<i>Судлаач, Эрчүүд, гэр бүл, хүүхэд хөгжлийн нийгэмлэгийн ажилтан</i>
Б.Зоригт	<i>Судлаач, “Амьдрал өгөх” сангийн ажилтан</i>

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийн хөдөлмөр нь ядуурлаас их хэмжээгээр шалтгаалдаг бөгөөд хүүхдийн сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах эрхийг ноцтой зөрчдөг хүний эрхийн зөрчил юм.

Монгол Улс Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцод 2001 онд, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцод 2002 онд тус тус нэгдэн орж, хүүхэд хамгааллын талаар холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч байгаа хэдий ч хууль тогтоомжийн хэрэгжилт дутмагаас хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, тэдний эрхийг зөрчих байдлаар ажил, хөдөлмөр эрхлүүлж буй явдал гарч байна.

Монгол Улсад 2020 оны байдлаар 0-18 насны хүүхдүүдийн 10 орчим хувийг эзлэх 56,000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн дийлэнх нь хөдөө аж ахуй, барилга, уул уурхай, худалдаа үйлчилгээний салбарт ажиллаж байна. Ажил, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн талаас илүү нь аюултай, хортой нөхцөлд ажилладаг байгаад анхаарах шаардлагатай юм. Хүүхэд ажил, хөдөлмөр эрхэлж буй байдал нь хот, суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт илүү их, өрх гэр ядуу байхын хэрээр хүүхэд ажил, хөдөлмөр эрхэлж байна.

Иймд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, бодлогын баримт бичгийг батлахын зэрэгцээ хүүхдийг тэвчишгүй хөдөлмөр эрхлэлтийг илрүүлэх, талсан зогсоох, үүнээс урьдчилан сэргийлэх тодорхой үйл ажиллагааг үүрэг хүлээгчдээс хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх, хүний эрхийн асуудлаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг, судалгаа, нөлөөлөл, хяналт шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн. Энэ ажлын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс Европын Холбооны санхүүжилттэй Олон улсын хөдөлмөрийн байгууллагын «Зохистой хөдөлмөр ба худалдаа» төсөлтэй хамтран Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгааны тайланг боловсруулан гаргасныг Та бүхэнд хүргэж байна.

Энэ судалгааг 2021 онд гүйцэтгэж дууссаны дараа уг судалгааны дүгнэлт, зөвлөмжийг харгалзан ХНХЯ нь ОУХБ-ын техникийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/122 дугаар тушаалаар Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг шинэчлэн баталж, мөн өдрийн А/123 дугаар тушаалаар 13 насанд хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг шинэчлэн тогтоосон.

Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа нь хүүхэд хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, хөдөлмөр эрхлэх явцад гарах сөрөг үр дагаврыг тодорхойлж, холбогдох байгууллагад санал, зөвлөмж хүргүүлэхийн зэрэгцээ хүүхдийн эрхийг хангаж, хамгаалах ажилд зохих хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Энэхүү судалгааг санхүүжүүлсэн Европын Холбоо болон тайланг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан Олон улсын хөдөлмөрийн байгууллага, эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

ХЭҮК-ЫН ГИШҮҮН, ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР,

ДЭД ПРОФЕССОР



Д.СҮНЖИД

АГУУЛГА

Өмнөх үг	iii
Товчилсон үгийн жагсаалт	vi

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА 7

1.1 Судалгааны үндэслэл	8
1.2. Монгол Улсын хүүхдийн эрхийг хангах нийгэм, эдийн засгийн орчин	9
1.3. Судлагдсан байдлын тойм	11
1.4. Судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээ	12
1.5. Судалгааны арга зүй	13

БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТЭЙ ХОЛБООТОЙ ТӨРИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ 21

2.1. ОУХБ-ын 182 дугаар конвенц болон үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээ	22
2.2. ОУХБ-ын 138 дугаар конвенц болон үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээ	33
2.3 Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, дүрэм журамд өөрчлөлт оруулах талаар:	35

БҮЛЭГ 3. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ 37

3.1 Тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй эрсдэлтэй хүүхдийн талаар	39
3.2 Монгол Улс дахь хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн хэлбэрүүд	43
3.2.1 Хүүхдийг боолчлох, албадан хөдөлмөрлүүлэх хэлбэр	43
3.2.2 Хүүхдийг биеэ үнэлэлт, садар самуунд ашиглах, худалдах хэлбэр	48
3.2.3 Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх хэлбэр	52
3.3 Хүүхэд гэрийн ажил болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүйгээр оролцож байгаа байдал	63
3.3.1 Гэрийн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн нөхцөл байдал	64
3.3.2 Хүүхэд гэр бүлийнхээ өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд	

цалин хөлсгүй оролцож байгаа байдал	66
3.4 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа хүүхдийн нөхцөл байдал	68
БҮЛЭГ 4. ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ	71
4.1 Хурдан морины уралдаан ба унаач хүүхдийн эрхийн талаарх эрх зүйн дүн шинжилгээ	72
4.2 Хурдан морь унаач хүүхдийн статистик мэдээлэл	74
4.3 Хурдан морь унаач хүүхдийн гүйцэтгэдэг ажил нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн шинжийг агуулж буй байдал	79
СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ	88
Судалгааны ерөнхий дүгнэлт	88
Судалгааны санал, зөвлөмж	91
Хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар:	92
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй, аюултай хэлбэрийг хориглох, устгах талаар:	94
Хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй, аюултай хэлбэрийг хориглох, устгах талаар:	95
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт батлах тухай” 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/122 дугаар тушаал.	97
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “13 нас нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тогтоох тухай” 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/123 дугаар тушаал.	98
Эх сурвалжийн жагсаалт	110

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АОЭЗНХ	Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГССҮТ	Гэмтэл, согог судлалын үндэсний төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МҮЭХ	Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо
МХХ	Монголын Хуульчдын холбоо
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УДШ	Улсын Дээд Шүүх
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХМТК	Хөдөлмөрийн маргаан таслах комисс
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭХМК	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс

БҮЛЭГ 1.

СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА



1.1 Судалгааны үндэслэл

Монгол Улс 1990 оны эхэн үед зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотойгоор нийгмийн бүхий л салбарыг хамарсан хямрал, өөрчлөлтөөс шалтгаалан хүүхдийн нас, биеийн онцлогт үл тохирох ажил, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хурцаар тавигдаж эхэлсэн.

2020 оны байдлаар 0-18 насны хүүхдүүдийн 10 орчим хувийг эзлэх 56,000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн дийлэнх нь хөдөө аж ахуй, барилга, уул уурхай, худалдаа үйлчилгээний салбарт байна. Хот, суурин газартай харьцуулахад аймаг, орон нутагт амьжиргааны түвшин доогуур өрх олон байхын хэрээр хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь илүү байгааг статистик тоо баримт харуулдаг.

Монгол Улс Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцод 2001 онд, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцод 2002 онд тус тус нэгдэн орж, Хөдөлмөрийн тухай (1999) хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тухайн бүр хийсээр иржээ. Мөн Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр” (2008-2012)-ийг баталсан нь хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн хэлбэрүүдийг устгахад чиглэсэн анхны бодлогын баримт бичиг байжээ. Эрх зүйн эдгээр зохицуулалтад үндэслэн насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар 1999 онд баталсан бөгөөд үүнийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд 2008 онд, Хөдөлмөрийн сайд 2016 онд тус тус шинэчлэн баталжээ. Мөн Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйлд 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулж, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцсон нь хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн томоохон алхам болсон.

Өнгөрсөн хугацаанд ОУХБ-ын зүгээс уг асуудлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хүүхдийн хөдөлмөртэй холбоотой үндэсний хэмжээний судалгаа, шинжилгээг дэмжиж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хувь нэмрээ оруулж иржээ.

Гэсэн хэдий ч хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, тэдний эрхийг зөрчин ажил, хөдөлмөр эрхлүүлэх байдал цөөнгүй гарч байна. Энэ нь ажил олгогчид болон гэр бүл, насанд хүрэгчдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, эсхүл тэдэнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сайн биш байгаатай холбоотой гэж үзэн судлаачид таамаглан дэвшүүлэн нотлох зорилгоор уг судалгааг хийлээ.

1.2. Монгол Улсын хүүхдийн эрхийг хангах нийгэм, эдийн засгийн орчин

Монгол Улс 2020 оны байдлаар 3,3 сая хүн амтай, 1,56 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай, хүн амын нягтралаараа дэлхийн хамгийн багад тооцогддог, байгалийн баялагт түшиглэсэн үйл ажиллагаа явуулахад харьцангуй давуу талтай байх боломжтой¹ гэжээ.

ҮСХ-ны Ажиллах хүчний судалгааны 2020 оны 03 дугаар улирлын дүнгээр Монгол Улсын нийт ажиллагчдын 24,6 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 4,6 хувь нь уул уурхайн салбарт, 17,2 хувь нь аж үйлдвэр, барилгын салбарт, 53,6 хувь худалдаа, үйлчилгээний салбарт ногдож байна. Эндээс үзэхэд эдийн засгийн хямралын үед хамгийн анхаарал хандуулах ёстой салбар бол худалдаа, үйлчилгээний салбар гэдэг нь харагдаж байна. Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 7,0 хувиар буурсан байна. ДНБ-ий 7,3 хувийн бууралтын (-1.5) пункт нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, (-1.5) пункт нь тээвэр, мэдээлэл, холбооны салбарт ногдож байна.²

Сүүлийн жилүүдэд манай орны ядуурал дорвитой буураагүй, орлогын тэгш бус байдал ч анхаарал татах боллоо. Ядуурлын түвшинг цаашид үргэлжлүүлэн бууруулах нь чухал байна. Асуудлыг шийдвэрлэхийн тулд эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлт гол үүрэгтэй. Хүртээмжтэй өсөлт нь дан ганц эдийн засгийн хэмжээг тэлэх бус, мөн нийгмийн эмзэг бүлгийн амьжиргааг сайжруулах тухай асуудал юм.³

Өрх гэр, хувь хүний онцлог, шинж чанарууд ядууралд хүргэх магадлалд ихээхэн нөлөөлдөг. Өрхийн тэргүүлэгч нь бүрэн дундаас доогуур боловсролтой, ажилгүй, эсвэл хөдөө аж ахуйн салбарт ажилладаг, ялангуяа малчин бол ядуурлын түвшин хамгийн өндөр харагдаж байна. Түүнчлэн албан бус эдийн засаг дахь хөдөлмөр эрхлэлт болон бүтээмж багатай хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүд өргөн тархсан. Улирлын чанартай хөдөлмөр эрхлэгчид, хөдөөгөөс хот руу шилжин ирэгсэд, ялангуяа залуучууд гэх мэт тодорхой бүлгүүдийн ажилгүйдэл, албан бус хөдөлмөр эрхлэлт өссөн байна. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн дийлэнх хувийг үйл ажиллагаа нь улирлын чанартай байдаг малчид болон барилгын ажиллагчид бүрдүүлж байна.

¹ Азийн хөгжлийн банк, “Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв” УБ, 2020 он, 4 дүгээр хуудас.

² ҮСХ, “Кроновирус ба эдийн засаг”, 2021 оны 10 дугаар сар, 4 дүгээр хуудас.

³ Монгол банк, Судалгааны тайлан №5, 2020 он.

Гэвч ажлын байр, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хайсан иргэдийн хот руу чиглэсэн хөдөлгөөн буурахгүй байна. Мөн жил ирэх тусам Улаанбаатар хотод оршин суух иргэдийн тоо өсөн нэмэгдэж 2018 онтой харьцуулахад 2020 оны байдлаар 5 хувиар өссөн нь доорх хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 1. Монгол Улсын хүн амын тоо, байршлаар

Д/д	Байршлаар	2018	2019	2020
1	Бүгд	3,238,479	3,296,866	3,357,542
2	Хот	2,197,970	2,258,981	2,316,499
3	Аймаг, орон нутаг	1,040,509	1,037,885	1,041,043

Монгол Улсад 2018 онд 894,496 өрх албан ёсоор бүртгэгдсэн бол 2020 оны байдлаар 908,712 өрх бүртгэгдэн, 2 хувиар өсжээ.

Хүснэгт 2. Монгол Улсын өрхийн тоо, оноор

Д/д	Улсын хэмжээнд	2018	2019	2020
1	Нэгдсэн дүн	894,496	897,427	908,712

Улсын хэмжээнд 0-18 насны хүүхдийн тоо 2018 оны байдлаар 1,133,945 байсан нь 2020 онд 1,200,531 болж өсжээ. Харин 2020 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд бүтэн өнчин 3,036 хүүхэд, хагас өнчин 35,000 хүүхэд бүртгэгдсэн байна.⁴

Өрх толгойлсон 86,535 эцэг, эсвэл эх ганцаараа хүүхэдтэйгээ амьдардгаас 81,3 хувь нь эх, 18,7 хувь нь эцэг байна. Шүүхийн шийдвэрээр 2019 онд нийт 2,167 хүүхэд тэтгэлэг тогтоолгосон бол тэтгэлэг тогтоолгосон нийт хүүхдийн 49.1 хувь нь тэтгэлгээ тогтмол авч чадахгүй байна. Нийслэлийн хэмжээнд 2018 онд явуулсан судалгаагаар орцны жижүүр ажилтай гэр бүлд 526 хүүхэд, нийтийн байр түрээслэгч гэр бүлд 1,036 хүүхэд, орон гэргүй тэнэмэл гэр бүлд 363 хүүхэд амьдарч байв.⁵

Боловсролын суурь үйлчилгээний чанарын жигд бус байдал, хүртээмжийн ялгааг

⁴ ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, дэлгэрэнгүйг дараах холбоосоор үзнэ үү:

http://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_008V1&fbclid=IwAR2vGtR4_ID9ff9qfEsnuLIP0sJWRH7z1C639XPHXjrFW-5z3S_LHje_QjM_

http://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_071V3&fbclid=IwAR1EdFOVii2O5k5sem_I8375oqPtDs6s1eV92Xwkgb93JFua1sDD22kvw8I

⁵ Дэлхийн зөн Монгол ОУБ, Тогтвортой хөгжлийн санаачилга ТББ, “Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал” судалгааны тайлан, 2021 он, 16 дугаар тал.

улам хурцатган бичиг үсэгт суралцах, тоолж сурах зэрэг суурь танин мэдэхүйн ур чадварыг бууруулж байна. Сургуулийн өмнөх боловсролын чанартай үйлчилгээнд хамрагдах боломж, ялангуяа эмзэг бүлэгт хязгаарлагдмал байгаа нь хүүхдүүд сургуульд бэлтгэгдэхэд ихээхэн ялгаатай байдалд хүргэж байна.⁶

КОВИД-19 цар тахлын үр дагавар дэлхийн улс орон болон Монгол Улсын эдийн засагт ч тодорхой нөлөөлөл үзүүлж байна.

1.3 Судлагдсан байдлын тойм

Монгол Улс дахь хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр судлагдсан байдлыг авч үзвэл 2001 оноос хойш хүүхэд, гэр бүлийн чиглэлээр 230 гаруй судалгаа, хэвлэмэл бүтээл байгаагаас хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр 100 орчим байна. Үүнээс хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тодорхой сэдвүүдээр хийгдсэн 50 орчим судалгааны бүтээл байна. Үүнд:

ХЭҮК-оос 2006 онд “Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгаа”, мөн ХЭҮК, Эрх зүйн судалгааны төв, ОУХБ, НҮБХС-тай хамтран 2015 онд “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх судалгаа”-г тус тус гүйцэтгэжээ.

Хүүхэд хамгааллын чиглэлээр хийгдсэн 30 гаруй судалгааны бүтээл байгаагаас хөдөлмөр эрхлэгч хүүхэд хамгааллын асуудлаар Хүүхдийн төлөө үндэсний хороо, Нийслэлийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран 2002 онд “Хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл мэдээллийн сан”-гийн, Төв аймгийн Хүүхдийн төлөө төвөөс 2006 онд “Хурдан морь унаач хүүхдийн судалгаа”-г, Монголын хүүхдийн эрхийн үндэсний төвөөс 2006 онд “Гэр бүл, эцэг эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн нийгэмшил”-ийн судалгааг тус тус хийжээ. Боловсролын талаар Нийслэлийн Хүүхэд гэр бүл, хөгжлийн газраас 2014 онд “Сургууль завсардсан хүүхдийн судалгаа”-г хийсэн байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн чиглэлээр 2000 оноос хойш хийгдсэн 60 гаруй судалгааны 50 гаруй хувь нь олон улсын хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн, үлдсэн 50 хувийг хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хийжээ. Түүнчлэн хүүхдийн бэлгийн мөлжлөгийн чиглэлээр хийгдсэн 10, гэмт хэрэгт холбогдох, эсхүл хохирогч болох асуудлаар 15, хүүхдийн

⁶ Дэлхийн зөн Монгол ОУБ, Тогтвортой хөгжлийн санаачилга ТББ, “Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал” судалгааны тайлан, 54 дүгээр тал.

асрамж халамжийн талаар 10, хүүхдийн аж байдлын талаар 14 судалгааны хэвлэмэл бүтээл байна.

1.4 Судалгааны зорилго, зорилт, хамрах хүрээ

Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох замаар эрх зүйн орчин, бодлогын хэрэгжилтийг сайжруулах, Засгийн газарт хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах цаашдын бодлого, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэхүйц мэдээлэл хүргэхэд судалгааны зорилго оршино.

Тухайлбал насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг хориглосон ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах, хөнгөн хөдөлмөрийн жагсаалтыг боловсруулахад энэ судалгааг эх сурвалж болгохыг зорилоо.

Судалгааны зорилт:

- Зорилт 1.* Үндэсний хууль тогтоомж, дүрэм, журам, бодлого, үйл ажиллагаанд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцод нийцэж байгаа эсэх, нийцэхгүй байгаа зүйл, заалтыг илрүүлэх, санал, зөвлөмж боловсруулах;
- Зорилт 2.* Хөдөө аж ахуй, үүний дотор малаж ахуй, уул уурхай, аялал жуулчлал, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон бусад салбарт хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн нөхцөл байдлыг тодорхойлох, санал, зөвлөмж боловсруулах;
- Зорилт 3.* Эдийн засгийн салбар тус бүрд эрсдэл, аюултай нөхцөл байдал болон байршлын мэдээллийг цуглуулах, насанд хүрээгүй хүн эрхлэхийг хориглосон ажлын байрны жагсаалт болон хүүхэд эрхэлж болох хөнгөн ажлын нөхцөлийг тодорхойлох санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлэх;

Судалгааны хамрах хүрээ:

Дээрх зорилго, зорилтын хүрээнд эдийн засгийн нийт 18 салбарыг сонгож, судалгааны байршлын хамрах хүрээг Улаанбаатар хот, Өмнөговь, Сэлэнгэ, Өвөрхангай, Сүхбаатар аймгаар хязгаарлан, түүврийн хэмжээг ОУХБ, ХЭҮК, ГБХЗХГ болон бусад холбогдох байгууллагатай зөвлөлдөж тодорхойлсон болно.

1.5 Судалгааны арга зүй

Өгөгдөл цуглуулах үйл явц

Өгөгдлийн анхдагч эх сурвалж нь төрийн захиргааны алба хаагчдаас ярилцлага, ажил, хөдөлмөр эрхэлж буй насанд хүрээгүй хүнээс ярилцлага, санал асуулга авсан болно. Хоёрдогч эх сурвалжаар баримт бичгийн судалгаа хийсэн.

Судалгааны баг судалгааны ёс зүйг чанд баримтлан энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн. Ялангуяа хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй хийх ганцаарчилсан ярилцлагад “судлаачийн тусгайлан баримтлах ёс зүйн удирдамж”-ийг боловсруулж, хүүхдээс ярилцлагын судалгаа авах судлаачдад 1 цаг 30 минутын тусгайлан зааварчилгаа өгч ажилласан.

Өгөгдлийг боловсруулах арга

Баримт бичгийн судалгаа. Баримт бичгийн шинжилгээний хүрээнд олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, үндэсний хууль тогтоомжид хэрхэн туссаныг судалж, хүүхдийн хөдөлмөрийн талаар өмнө хийгдсэн судалгаа, шинжилгээний ажилд дүн шинжилгээ хийв.

Хүүхдийн хөдөлмөрийн тухай олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, холбогдох заавар, зөвлөмж, гарын авлага, ном, товхимол зэрэг бусад эх сурвалжийг судалж, энэхүү судалгааны тайлангийн холбогдох хэсгүүдэд тусган орууллаа.

Түүнчлэн сонгон авсан аймгийн удирдлага, боловсролын байгууллага, хүүхэдтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, хориглох чиглэлээр байгууллагын үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөртөө тусгасан хийгээд, тухайн жилийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлсэн байдал, хэрэгжилтийн үр дүнгийн тайланг хэвлэмэл хэлбэрээр авч судалгаанд ашигласан. Ялангуяа судалгааны тайлангийн “Хүүхдийн ажил, хөдөлмөртэй холбоотой төрийн бодлого, хууль тогтоомжид дүн шинжилгээ” гэсэн хоёрдугаар бүлгийг баримт бичгийн судалгаанд тулгуурлан гүйцэтгэсэн болно.

Судалгааны эх олонлог түүврийг тодорхойлох

Ганцаарчилсан ярилцлагын арга ба түүврийн хэмжээ. Судалгааны эх олонлогт судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд, багш, Насан туршийн боловсролын газрын ажилтан, асуудал хариуцсан захиргааны алба хаагчдыг хамруулсан. Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын судалгааны төлөвлөсөн түүвэр болон бодитоор хийсэн судалгааны зөрүүг доорх хүснэгтэд харуулсан.

**Хүснэгт 3. Ганцаарчилсан, фокус бүлгийн ярилцлагын болон тоон судалгааны
төлөвлөсөн түүвэр, бодит гүйцэтгэл**

№	Судалгааны төрөл	Түүврийн нэгж	Судалгааны арга	Хамрах хүрээ	Түүврийн хэмжээ
1	Тоон судалгаа, оролцогч 2,175	Насанд хүрээгүй хүн	Цахим асуулга	21 аймаг, 9 дүүрэг	1,658
2		Насанд хүрэгч			517
3	Чанарын судалгаа, оролцогч 77	Хүүхэд	Ганцаарчилсан ярилцлага	Улаанбаатар хот	52
4		Төрийн байгууллагын төлөөлөл			17
5		Ажил олгогчийн төлөөлөл			11
6		Мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл			4
7		Цагдаагийн байгууллагын төлөөлөл	Фокус бүлгийн ярилцлага	Улаанбаатар хот, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг	14
8		ГБХЗХГ болон ТББ			40
9		Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл			2
10		АОЭНХ, ажил олгогчдын төлөөлөл			2
11		Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл			3
12		Орон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл			16

“Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой талууд”-ын ойлголт, хандлага, тодорхой асуудлаар баримталж буй үзэл бодол, байр суурийг илрүүлэх зорилгоор ганцаарчилсан ярилцлага хийн, нөхцөл байдлыг тодорхойллоо.

Ганцаарчилсан ярилцлагад хамруулахаар төлөвлөсөн оролцогчийн бүлэг бүрд ярилцлагын асуултуудыг тусгайлан бэлтгэж, үүндээ ХЭҮК, ОУХБ - ын саналыг тусгасан болно.

Ганцаарчилсан ярилцлагад судалгааны зорилго, зорилтыг хангахын тулд хүүхдүүдийг хамруулах нь илүү чухал гэж үзсэн.

Судалгааны хүрээнд 15 тодорхой салбарыг сонгон авч ажил, хөдөлмөр эрхэлж байгаа 94 хүүхдийг судалгаанд хамруулахаар түүврийг төлөвлөсөн. Үүнээс дараах байдлаар хүүхдүүдтэй ярилцлага хийж, 55 хувийн гүйцэтгэлтэйгээр үр дүнг судалгааны тайланд тусгав.

Хүснэгт 4. Хүүхэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын судалгааны тоо, салбараар

№	Салбар, илрүүлэлт	Хүүхдийн тоо
1	Мал аж ахуй	2
2	Газар тариалан	3
3	Үйлчилгээ	9
4	Бөөний худалдаа	2
5	Жижиглэнгийн худалдаа	11
6	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	0
7	Барилга	5
8	Уул уурхай	0
9	Бичил уурхай	0
10	Боловсруулах үйлдвэр	1
11	Өөрийн болон бусдын өрх, гэрт ажил, хөдөлмөр эрхэлж байгаа	4
12	Урлаг	1
13	Спорт	3
14	Хурдан морь	9
15	Гэмт хэрэгт холбогдсон болон гэрч, хохирогч болсон хүүхэд	2
Нийт		52

Хүүхдээр ажил, хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчтой ярилцах нь чухал гэж үзсэн тул 14 салбараас тус бүр нэг ажил олгогчидтой ганцаарчилсан ярилцлага хийхээр төлөвлөсөн. Гэвч ажил олгогчид ярилцлага өгөхийг хүсэхгүй байх нь нийтлэг байлаа. Учир нь хүүхдээр ажил, хөдөлмөр хийлгэж болохгүй гэсэн мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллага, тухайн аймаг, орон нутгийн ГБХЗХГ-аас өгдөг нь хүүхэд ажиллуулдаггүй, ажиллуулах ёсгүй гэж ярилцлагад оролцохоос татгалзах үндэслэл болсон. Хэдий ийм асуудалтай тулгарсан ч 12 ажил олгогчийг судалгаанд хамруулан ярилцлага хийв.

Хүснэгт 5. Ажил олгогчтой хийсэн ганцаарчилсан ярилцлага, салбараар

№	Салбар, илрүүлэлт	Ажил олгогч
1	Үйлчилгээ	3
2	Жижиглэнгийн худалдаа	3
3	Урлаг	2
4	Спорт	1
5	Хурдан морь	2
6	Гэмт хэрэгт холбогдсон болон гэрч, хохирогч болсон хүүхэд	1
	Нийт	12

Хүүхэд нь бие даан шийдвэр гаргах, хөдөлмөрийн харилцаанд өөрийгөө бүрэн төлөөлөх болон иргэний хэлцэлд эрх зүйн бүрэн чадамжтай этгээд байж чадахгүй тул ажил эрхэлж байгаа хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчийн байр суурийг тодруулах нь мөн чухал гэж үзээд 11 эцэг, эх, асран хамгаалагчийг судалгаанд хамруулахыг хичээсэн боловч зөвхөн 2 эцэг, эхийг бодитоор хамруулж үзэл, бодлыг нь сонслоо. Эцэг, эхчүүд хүүхдээрээ ажил, хөдөлмөр эрхлүүлж байгаагаа нуун дарагдуулах, ямар нэгэн хариуцлага тооцуулах байх гэж бодсоны улмаас ярилцлага өгөхөөс татгалзаж байсан.

Улсын хэмжээнд аймаг тус бүр нэг хөдөлмөрийн улсын байцаагч ажилладаг тул судалгааны түүвэрт багтсан 2 дүүрэг, 4 аймгийн хөдөлмөрийн байцаагчидтай ганцаарчилсан ярилцлага хийхээр, аймаг, орон нутгийн захиргааны байгууллагаас хүүхдийн асуудал хариуцсан, эсхүл нийгмийн бодлого хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийхээр төлөвлөсөн. Ярилцлагын явцад нэг нэгнээсээ хамааралтай, нэмж тодруулах зайлшгүй хэрэгцээ гарснаас үүдэн нэмэлт ярилцлагуудыг хийсэн.

Хүснэгт 6. Нутгийн өөрөө удирдах байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын алба хаагчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын судалгааны тоо, талбараар

№	Аймаг, орон нутаг	Мэргэжлийн хяналтын байгууллага		Аймаг, орон нутгийн захиргааны байгууллага	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Улаанбаатар хот	1	1	1	4
2	Өвөрхангай аймаг	1	1	1	1
3	Өмнөговь аймаг	1	1	1	7
4	Сэлэнгэ аймаг	1	1	1	2
5	Сүхбаатар аймаг	1	0	1	3
Нийт		5	4	5	17

УИХ-аас 2021 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 142 дугаар зүйлийн 142.5 дахь хэсэг “15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаар хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн бичгээр гаргасан зөвшөөрөл, ажиллах цаг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг үндэслэн хүүхдийн эрхийн улсын байцаагч тухай бүр зөвшөөрөл олгосон бол хөдөлмөр эрхлүүлж болно”, 143 дугаар зүйлийн 143.3 дахь хэсэг “Урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг албан томилолтоор ажиллуулахыг хориглоно” гэж тус тус заасны дагуу урлаг, соёлын салбарт хүүхэд бэлтгэн уралдаан, тэмцээн, үзүүлбэрт оролцуулж байгаа 4 төлөөллөөс ярилцлага авахаар төлөвлөснөөс 3 төлөөллийг хамруулж санал бодол, байр суурийг нь судалгаанд тусгалаа.

Ганцаарчилсан ярилцлагыг анх төлөвлөснөөс 82 хувийн гүйцэтгэлтэйгээр хийгдсэн үр дүнг нэгтгэн судалгааны тайланд тусгав.

Фокус бүлгийн ярилцлагын арга ба түүврийн хэмжээ

Энэхүү судалгааны хүрээнд тодорхой байгууллагын хүүхдийн хөдөлмөртэй холбоотой асуудал хариуцдаг 3-6 ажилтан, албан хаагчдыг нэг бүлэг болгон тэдний хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, чиг үүрэг, хэрэгжилтийн нөхцөл байдал, өөрчлөгдөж байгаа чиг хандлагууд болон анхаарал татсан бусад асуудлыг тодруулах байдлаар тухайн байгууллагын хүүхдийн ажил эрхлэлтийг зохицуулах, хүүхдийн хөдөлмөрийг хориглох, устгах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхээр төлөвлөсөн.

Түүнчлэн ГБХЗХГ-ын ажилтнуудтай болон МАОЭНХ, МҮЭХ, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдийг хамруулан нийт 4 фокус бүлгийн ярилцлага хийхээр төлөвлөсөн. Сонгон авсан 2 дүүрэгт ГБХЗХГ, ЗДТГ-ын Хуулийн хэлтэс, дүүргийн цагдаагийн газрын алба хаагчидтай нийт 13 фокус бүлгийн ярилцлага хийхээр төлөвлөснөөс 19 фокус бүлгийн ярилцлага хийснээр 46 хувийн илүү гүйцэтгэлтэйгээр ажиллаж, үр дүнг нэгтгэн судалгааны тайланд тусгалаа.

Хүснэгт 7. Нутгийн өөрөө удирдах байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын алба хаагчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлагын судалгааны тоо, талбараар

№	Аймаг, орон нутаг	Цагдаагийн байгууллагын төлөөлөл	ГБХЗХГ болон ТББ-ын төлөөлөл	Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл	АОЭНХ, Ажил олгогчдын төлөөлөл	Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны төлөөлөл	Аймаг, орон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл	Нийт
1	Улаанбаатар хот	1	3	1	1	1	1	8
2	Сэлэнгэ аймаг	1	2	0	0	0		3
3	Өвөрхангай аймаг	1	1	0	0	0		2
4	Өмнөговь аймаг	1	1	0	0	0	1	3
5	Сүхбаатар аймаг	1	1	0	0	0	1	3
	Нийт	5	8	1	1	1	3	19

Асуулгын судалгаа

Хүүхдийн ажил, хөдөлмөр, тэр дундаа тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг илрүүлэх асуудал нь нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн өргөн хүрээний асуудалтай хамааралтай учир аль болох бага хугацаанд олон оролцогчоос үнэн зөв мэдээлэл цуглуулах үүднээс цахим хэлбэрээр асуулгын судалгаа бөглүүлэх аргыг ашиглав.

Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа ажлын байр, хүүхэд ажил хийхэд тохиолдож байгаа хүүхдийн хөдөлмөрийн хүнд болон тэвчишгүй хэлбэрт хамаарч болох нөхцөлүүд, тэдгээрийн байршил, хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлт нь хүүхдийн сурч боловсрох эрх, хүмүүжил, сурлагын чанарт нь хэрхэн нөлөөлж байгаа зэргийг илүү тодорхой харуулахын тулд тоон судалгааны үр дүнг чанарын судалгааны үр дүнтэй харьцуулалт хийн дүгнэлээ.

Цахим асуулга нь орон зайн хувьд хүрэхэд хүндрэлтэй газарт хүрэх, хугацаа хэмнэх, зорилтот бүлгийг оролцуулах боломжтой, олон хүнийг зэрэг хамруулсан, газар зүйн байршил хамаарахгүй нэгэн зэрэг өргөн цар хүрээтэй явуулах боломжтой, богино хугацаанд их хэмжээний мэдээлэл цуглуулахад боломжтой зэргээр давуу талтай юм.

Цахим асуулгын сул тал нь хариултыг сонголтоор өгч байгаа учир судалгаанд оролцогчдын санаа бодлыг бүрэн дүүрэн илэрхийлэх боломжгүй тул ярилцлагын аргыг хослуулан хэрэглэж, тухайн асуудлыг олон талаас нь тодруулж, нөхцөл байдлыг тодорхойллоо.

Судалгаанд нийт 2,175 үүнээс 1,658 хүүхэд оролцсон бөгөөд цахим асуулгад оролцогчдын нэр төрийг эрхэмлэх, хувь хүний нууцыг хадгалах, үнэн зөв мэдээлэл олж авах зорилгоор оролцогчдод хувийн чанартай мэдээллийг илрүүлэх асуулт оруулаагүй болно.

Чанарын судалгааны түүврээс хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрүүдийг илрүүлэх боломж харьцангуй бага байсан тул цахим асуулгын судалгааг нийтэд, нээлттэй байдлаар 21 аймаг, 9 дүүргээс 7 өдрийн туршид авсан бөгөөд үүнд судалгаанд зорилтот бүлгийн, бүх насныхан болон аймаг, орон нутгийн төлөөллийг хамруулсан.

Судалгаанд оролцсон хүүхдүүд өөрсдийн болон эцэг, эх, ажил олгогчийн талаар мэдээлэл өгч, өөрт тохиолдсон бэрхшээл, хувийн амьдрал, ажлын байрны дарамт, хүчирхийлэл байдаг эсэх, ажил олгогчийн харилцаа, хандлага, ялгаварлан гадуурхалт, цалин хөлсний асуудлаар эргэлзэх, татгалзах асуудал цөөнгүй гаргаж байсан. Цахим асуулга нь үнэн бодит мэдээлэл цуглуулахад хамгийн үр дүнтэй аргын нэг тул судалгааны үр дүнд эерэг нөлөөг үзүүлсэн гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцод заасан насны ангиллаар, хүйсээр ялган харвал дараах хүснэгтэд тусгасан үр дүн харагдана.

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо, насны бүлгээр, хүйсээр

Д/д	Насны ангилал	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
1	5-11 нас	83	60	143
2	12-14 нас	256	147	403
3	15-18 нас	652	460	1,112
	Нийт	991	667	1,658

Судалгааны асуулгад ХЭҮК, ОУХБ - ын саналыг тусган боловсруулсан. Ингэхдээ судалгааныхаа зорилго, зорилтыг хангахын тулд нарийвчилсан хэд хэдэн асуултыг оруулсан хэдий ч оролцогчийг залхаахгүй байх үүднээс асуултын тоог хүүхдээс 50, насанд хүрэгчдээс 55-аас хэтрүүлэхгүй байхаар тогтсон.

Өгөгдлийн боловсруулалт

Мэдээллийг КОВИД-19 цар тахлын үед хуанлийн 20 хоногт багтаан цуглуулав. Тоон судалгааны мэдээллийг “SPSS 22.1” программ, нээлттэй асуултын мэдээллийг “Microsoft Excel 2010” программ, баримт бичгийн шинжилгээ болон ярилцлагын судалгааны мэдээллийг “Microsoft Word 2010” программыг тус тус ашиглан боловсруулав.

Судалгааны хүрээнд цуглуулсан тоо, чанарын мэдээллийг нэгтгэн дүгнэж (analyzing), харьцуулж (comparing), эрс тэс ялгааг илрүүлж (contrasting), тайлбарлалаа (interpreting).

Чанарын судалгааны хүрээнд хэд хэдэн ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлагын үр дүнг нэгтгэн шинжилсэн (Cross-case analyses) ба дүгнэлт, кейсийг судалгааны эх олонлогт тархаан тайлбарлах оролдлого хийгээгүй болно.

Тайланг ХЭҮК, ОУХБ-ын зөвлөмж, судалгааны ажлын удирдамжийн бүтцийг баримтлан судалгааны тайланг бүтэцчилж боловсруулан, судалгааны дүгнэлтэд тулгуурлан санал, зөвлөмжийг дэвшүүлсэн болно.

Судалгааг явуулахад гарсан хүндрэл, бэрхшээл, хязгаарлалт

Анх төлөвлөж байснаас бодит байдал дээр ярилцлагын судалгааны объектууд өөрчлөгдөж, судалгааны түүврийн тоог зайлшгүй нэмэх шаардлагатай болсон.

Судалгаанд хүүхдээр ажил, хөдөлмөр эрхлүүлж буй эцэг, эхтэй ярилцахаар төлөвлөсөн хэдий ч ярилцлага өгөх эцэг, эхийн төлөөллийг олж чадаагүй тул ярилцлагын түүврээс хассан.

Судалгаанд хамрагдан мэдээлэл өгч байгаа төрийн захиргааны байгууллагын ажилтан, алба хаагчид, мэргэжилтнүүд хүүхдийн ажил, хөдөлмөр, тэвчишгүй хэлбэрийг ялгаж мэдэхгүйгээс асуултыг ойлгуулахын тулд мэдээлэл өгч, нэмэлт тайлбар хийж байсан нь ярилцлагын 30 минутыг сунгах, дараагийн ярилцлагын цаг багтахгүй байх хүндрэл үүссэн. Сонгон авсан төрийн байгууллагаас ирүүлсэн бүртгэл, судалгаа бодит байдлаас зөрүүтэй байсан. Тухайлбал ЦЕГ болон УЕПГ-ын мэдээлэлтэй зөрүүтэй, мөн хүүхдийн хөдөлмөрийн талаарх ҮСХ болон ГБХЗХГ-ын мэдээлэлтэй зөрүүтэй байсан зэрэг нь аль мэдээллийг эх сурвалж болгон ашиглахад ойлгомжгүй байдал үүсгэсэн.

БҮЛЭГ 2.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРТЭЙ
ХОЛБООТОЙ ТӨРИЙН БОДЛОГО,
ХУУЛЬ ТОГТООМЖИД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ



НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор баталсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай 1924 оны Женевын тунхаглал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1959 онд баталсан Хүүхдийн эрхийн тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүүхэд бол эрх зүйн бие даасан субъект мөн хэмээн үзэж, хүүхдийн эрхийг эрхэмлэн хүндэтгэж, хамгаалах асуудлыг тунхаглан баталгаажуулсан.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйлд “хуулийн дагуу 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд” гэж үзэхээр заасан бол Хүүхэд хамгааллын тухай хуульд “Монгол Улсын иргэнийг төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 нас хүртэл хүүхэд” гэж тооцон хамгаалахаар зохицуулжээ. Харин Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалтад “... хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан.

Энэ бүлэгт Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, түүний 190 дүгээр зөвлөмж, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенц, түүний 146 дугаар зөвлөмжийн зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид тусгасан байдлыг харьцуулан судалж, холбогдох санал, зөвлөмжийг боловсруулав.

2.1. ОУХБ-ын 182 дугаар конвенц болон үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээ

Энэхүү конвенцод нэгдэн орсноор манай улсын хөдөлмөрийн харилцаанд тодорхой өөрчлөлт гарч тухайн үед батлагдаад удаагүй байсан Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид конвенцын зүйл заалтад нийцүүлэн нэмэлт өөрчлөлт хийсэн нь сайшаалтай байна. Гэвч энэхүү конвенцод нэгдэн орсны дараа хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг зайлшгүй хөндөн тусгавал зохих зарим бодлого, эрх зүйн зохицуулалтад оруулахгүй орхигдуулсан тал ч байна. Тухайлбал УИХ-аас 2016 онд баталсан Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудад хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тусгайлсан зохицуулалт агуулаагүй байна.

Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах чиглэлээр дараах бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Засгийн газрын 2005 оны 234 дүгээр тогтоолоор баталсан “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2014 онд хэрэгжүүлж дууссан;

2. Засгийн газрын 2011 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж 2016 онд дууссан;
3. Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-т хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, зан суртахуунд сөргөөр нөлөөлөх хөдөлмөрийг хориглох чиглэлээр 2 зорилт дэвшүүлсэн;
4. Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор баталсан баталсан “Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журам”-д 15 нас хүрсэн оюутны хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгасан байна.

Монгол Улс хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсан нь эерэг үр дүнд хүрсэн цөөнгүй тохиолдол харагдаж байгаа боловч хөтөлбөрүүдийн хувьд хэрэгжих хугацаа дуусгавар болсноор хүүхдийн хөдөлмөрийг хориглох, устгахад чиглэсэн нэн чухал үзэл баримтлалууд хэрэгжихгүй орхигдох тохиолдол гарч байгаа тул Монгол Улс “...хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ нэн даруй авч хэрэгжүүлнэ” гэсэн олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа хангалттай биелүүлж чадахгүй байна гэж үзэж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгахад чиглэсэн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгасан байдал

Конвенцын 3 дугаар зүйлд “Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр”⁷ гэсэн нэр томъёог тодорхойлж, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гишүүн улс бүр энэхүү конвенцын заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх, биелэлтийг хангахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээ, түүний дотор эрүүгийн ял шийтгэл, зохих тохиолдолд бусад шийтгэл бий болгох болон хэрэглэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж заасан. Түүнчлэн Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай ОУХБ-ын 1999 оны 190 дүгээр зөвлөмжийн 12 дугаар зүйлд “Гишүүн орнууд нь дор дурдсан хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг эрүүгийн гэмт хэрэгт тооцвол зохино”, 13 дугаар зүйлд “Гишүүн орнууд нь конвенцын 3 дугаар зүйлийн (d) хэсэгт заасан ажлын аливаа төрлийг хориглох ба устгахтай холбогдсон үндэсний хууль тогтоомжийг зөрчсөн этгээдүүдэд хариуцлага,

⁷ (a) Боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөн ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа; (b) Хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох; (c) Олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох; (d) Ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил гэж тус тус тодорхойлсон.

шаардлагатай бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгтэй” гэжээ.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгасныг тус конвенцод заасны дагуу (a) боолчлол, боолчлолын хэлбэрүүд, (b) хүүхдийг биеэ үнэлэлт, садар самуунд татан оролцуулах, (c) мансууруулах бодисын эргэлт, гэмт хэрэгт татан оролцуулах болон (d) хүүхдээр аюултай ажил хийлгэх гэсэн дөрвөн хэсэгт ангилан судалж үр дүнг энэхүү хэсэгт танилцуулж байна.

(a) Боолчлол ба боолчлолын хэлбэрүүд

Боолчлол, боолын худалдааг хориглох тухай 1926 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 82 дугаар конвенцын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Боолчлол гэдэгт өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцөлийг ойлгоно”, 2 дахь хэсэгт “Боолын худалдаа гэдэгт хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл; боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл; худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна” гэж тус тус заасан.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1956 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр баталсан Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенцын⁸ Боолчлолтой адилтгах ёс, заншил хэсгийн 1 дүгээр зүйлд “Энэхүү конвенцод оролцогч улс гүрэн бүр ... Боолчлолын тухай конвенцын 1 дүгээр зүйлд заасан боолчлолын тухай тодорхойлолтод туссан эсэхийг нь харгалзалгүйгээр хараахан устаагүй байгаа дараах ёс болон заншлыг бүрэн халах буюу устгахыг аль болох богино хугацаанд амжилттай гүйцэтгэхийн тулд бүхий л хэрэгжихүйц болон шаардлагатай хуулийн болон бусад арга хэмжээ авна” гээд “(d) хэсэгт 18 нас хүрээгүй болон бага насны хүүхдүүдийг ашиглах буюу тэдний хөдөлмөрийг мөлжих зорилгоор эцэг эхийнх нь аль нэг, эсхүл хоёул, эсхүл асран хамгаалагч нь тэднийг шан харамжтай буюу түүнгүйгээр бусдад өгдөг аливаа ёс буюу заншил” гэсэн байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “хүн худалдаалах” гэж хүнийг ... боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, ...зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах,

⁸ Монгол Улс энэхүү нэмэлт конвенцыг 1968 онд хүлээн зөвшөөрсөн. Монгол хэл дээрх эхийг дараах холбоосоор үзнэ үү: <https://legalinfo.mn/mn/detail/1291>

хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг” ойлгоно гэж заасан. Харин Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор ...” гэж боолчлох нь тодорхой гэмт үйлдлийн зорилго байхаар заажээ. Үүнээс үзэхэд Монгол Улсын хууль тогтоомжид “боолчлол”-ын тодорхойлолт, түүнд хүлээлгэх эрүүгийн болон зөрчлийн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалтыг шууд утгаар нь зааж өгөөгүй бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал буюу гэмт хэргийн зорилгод л хамааруулан тодорхойлсон байна. Энэ нь конвенцод хүн худалдаалах нь өөрөө боолчлолын нэг хэлбэр буюу түүнтэй төстэй үйл ажиллагаа гэж тодорхойлсонтой нийцэхгүй байна. Түүнчлэн “боолчлох зорилготой” гэдгийг хэрхэн ойлгохыг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлоогүй тул энэ зорилгоор гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг практикт тогтоох боломжгүй гэж үзэж байна.

Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенцод заасан боолчлолтой төстэй үйл ажиллагааг нарийвчлан судалбал дараах байдалтай байна. Үүнд:

а.1 Хүүхдийг худалдах, дамжуулан худалдах

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Палермогийн протоколын 3 дугаар зүйлд “Хүн худалдаалах гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ”, Мөлжих гэдэгт наад зах нь бусдыг биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно” хэмээн тодорхойлжээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “хүн худалдаалах” үйлдлийг тодорхойлсон бөгөөд энэхүү тодорхойлолтод үндэслэн Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлд хүн худалдаалах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тусгажээ. ХЭҮК-оос 2008 онд хийсэн “Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн

тэвчишгүй хэлбэрүүд” судалгааны тайланд “Эрүүгийн хуулийн дагуу манай улсад зөвхөн хүн (хүүхэд) худалдсан этгээд л эрүүгийн хариуцлага хүлээх, худалдан авсан этгээд нь эрүүгийн хариуцлага хүлээдэггүй. Хүүхдийг худалдан мөнгө авсан, худалдаж авсан мөнгө төлсөн аль аль нь буруутай бөгөөд хариуцлага хүлээх учиртай” гэжээ. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр оруулсан нэмэлт, Эрүүгийн хуулийн (2015) шинэчилсэн найруулгад хүүхэд худалдаалахтай холбоотой зохицуулалтыг конвенцод нийцүүлсэн төдийгүй худалдсан хүүхдийг хүлээн авсан этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулахаар зохицуулсан нь чухал дэвшилтэт алхам болсон.

а.2 Өрийн төлөөс, хамжлагын албат болгох

Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай НҮБ-ын 83 дугаар нэмэлт конвенцын 1 дүгээр зүйлд “Өрөнд баригдаж боолчлогдсон, өөрөөр хэлбэл өртэй хүн өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсоор үнэлсэн үнэлгээ нь уг өрийн төлөөсөнд тооцогдохгүй, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус бол”, “Хамжлага болох, өөрөөр хэлбэл, хууль, заншил, эсхүл гэрээний дагуу түрээслэгч өөр хүний эзэмшил газарт амьдарч шан харамжтай буюу түүнгүйгээр хөдөлмөр хийх болон тухайн хүнд тодорхой зарим үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн нөхцөл, байдал болон уг байдлыг өөрчилж чадахааргүй бол” боолчлолтой төстэй ёс заншил гэж үзэн түүнийг аль болох богино хугацаанд бүрэн халах буюу устгахын тулд шаардлагатай бүхий л хуулийн болон бусад арга хэмжээг авна гэжээ.

Хөдөлмөрийн тухай, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд хүүхэд гэлтгүйгээр хүнийг өрийн төлөөс, хамжлага болгох, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар тусгагдаагүй байна. ХЭҮК-оос 2008 онд хийсэн “Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд” судалгааны тайланд “хүүхдийг өрийн төлөөс, хамжлагын албат болгох үйлдлийг гэмт хэрэг гэж тооцохоор Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай”⁹ гэж дүгнэсэн боловч одоог хүртэл зохицуулалтгүй байна.

а.3 Хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх

Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29 дүгээр конвенцын тодорхойлолтын дагуу “Албадан хөдөлмөр гэдэг нь ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар

⁹ ХЭҮК, “Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд судалгааны тайлан”, 2008 он, дараах холбоосоор үзнэ үү: https://nhrcm.gov.mn/media/documents/1431398066_2008-hhdiyn-hdlm-riyn-tevchishgy-helberd.pdf

заналхийлж аливаа хүнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээ”-г ойлгоно. Энэ нь ажлын мөн чанараар бус харин ажлыг гүйцэтгүүлж, гүйцэтгэж байгаа хүмүүсийн хоорондын харилцаагаар тодорхойлогдоно гэж заасан.

Мөн хүүхдийн эрхлэх ажил, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь албадан хөдөлмөрийн шинжийг агуулж байгаа эсэхийг анхаарах шаардлагатай. Албадан хөдөлмөрийн доор дурдсан¹⁰ шалгуур үзүүлэлтийг “Албадан хөдөлмөрийг тодорхойлох ОУХБ-ын шалгуур үзүүлэлтүүд”¹⁰- д заасан. Харин Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29 дүгээр конвенцод “албадан хөдөлмөр” гэх нэр томъёонд дараах зүйлийг оруулахгүй гэжээ. Үүнд:

1. Цэргийн алба заавал хаахыг заасан хуулийн дагуу цэвэр цэргийн шинжтэй ажил гүйцэтгэхтэй холбогдсон аливаа ажил буюу үйлчилгээ;
2. Өөрийгөө бүрэн удирдах улсын иргэний хувьд хүлээсэн иргэний ердийн үүргийн хэсэг болох аливаа ажил буюу үйлчилгээ;
3. Шүүхийн шийдвэрээр ногдуулсан шийтгэлийн үр дүнд аливаа этгээдээр гүйцэтгүүлэх ажил буюу үйлчилгээ, гэхдээ уг ажил буюу үйлчилгээг төрийн эрх бүхий байгууллагын хяналтын дор гүйцэтгэх бөгөөд тэрхүү этгээдийг хувь хүн, компани эсхүл нийгэмлэгийн мэдэлд хөлслөх буюу шилжүүлэхгүй байх ёстой;
4. Онцгой тохиолдолд тодруулбал дайн буюу гамшгийн үед эсхүл гамшиг тулгарсан үед тухайлбал гал түймэр, үер, өлсгөлөн, газар хөдлөлт, гоц халдварт өвчний тархалт, амьтан, шавж буюу ургамлын хортон шавжны нүүдэл, ер нь нийт хүн ам буюу хүн амын хэсэг амьд явах буюу хэвийн амьдрахад аюул учруулах аливаа нөхцөл байдалд гүйцэтгэх аливаа ажил, үйлчилгээ;
5. Бүлэглэлийн шууд ашиг тусын тулд тухайн бүлэглэлийн гишүүдийн гүйцэтгэдэг бөгөөд тиймээс тухайн бүлэглэлийн гишүүдийн иргэний ердийн үүрэг гэж үзэж болох хамтын шинжтэй жижиг үйлчилгээ, гэхдээ энэ үйлчилгээ хэрэгтэй эсэх талаар бүлэглэлийн гишүүд буюу тэдний шууд төлөөлөгчтэй зөвлөлдөх ёстой.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Албадан хөдөлмөрлүүлэх гэж аливаа торгууль, шийтгэл ногдуулахаар

¹⁰ ОУХБ, “Албадан хөдөлмөрийг тодорхойлох ОУХБ-ын шалгуур үзүүлэлтүүд”, эх сурвалжийг бүрэн эхээр дараах холбоосоор үзнэ үү: https://www.ilo.org/beijing/what-we-do/publications/WCMS_537158/lang--en/index.htm

айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ажил, үйлчилгээ эрхлүүлэхийг ойлгоно” гэж тодорхойлжээ. Мөн суурь боловсрол эзэмших, хугацаат цэргийн алба хаах, шүүхийн шийдвэрийн дагуу нийтэд тустай ажил хийх зэргийг албадан хөдөлмөрт хамаарахгүй ажил үйлчилгээ гэж заасан байна.¹¹ Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “албадан хөдөлмөр”-ийн асуудлыг конвенцод нийцүүлэн зохицуулсан нь ач холбогдолтой болжээ.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад албадан хөдөлмөрлүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, ял оногдуулах, мөн хуулийн этгээдэд хариуцлага ногдуулах зохицуулалт бий болгосон ч хуульд “насанд хүрээгүй хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх” тохиолдлыг тусгайлан заагаагүй бөгөөд нийтлэг байдлаар томъёолжээ. Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүнийг албадан хөдөлмөрлүүлсэн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд нэмж оруулах нь зүйтэй байна.

Хөдөлмөрийн тухай хуульд тусгасан тодорхойлолт болон Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн тодорхойлолтыг Албадан хөдөлмөрийг тодорхойлох ОУХБ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан илүү тодорхой болгох боломжтой байгааг анхаарах нь шаардлагтай.

Ингэснээр энэхүү гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, шийтгэл оногдуулах үйл явц илүү тодорхой болох юм.

а.4 Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протоколд оролцогч улсууд өөрийн үндэсний зэвсэгт хүчинд 18 нас хүрээгүй цэргийн алба хаагчдыг байлдааны ажиллагаанд шууд оролцуулахгүй, зэвсэгт хүчинд албан журмаар элсүүлэхгүй байхаар, түүнчлэн төрийн зэвсэгт хүчнээс ангид зэвсэгт бүлэглэлүүд ямар ч тохиолдолд тэднийг байлдааны ажиллагаанд татан оролцуулж, ашиглахгүй байхаар тус тус заасан.

Цэргийн албаны тухай (2016) хуульд 18-25 насны эрэгтэйчүүдийг хугацаат цэргийн албанд татах бөгөөд шашин шүтлэг, ёс зүйн шалтгаанаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж болно гэж тус тус заасан.¹² Харин Эрүүгийн хуулийн 29.6 дугаар зүйлд хөлсний цэрэг ашиглах гэмт хэрэгт хүүхдийг татан оролцуулж үйлдсэн бол гэмт хэрэгт тооцохоор заажээ.

¹¹ Хөдөлмөрийн тухай (2021) хуулийн шинэчилсэн найруулгын 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг.

¹² Цэргийн албаны тухай (2016) хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг.

Иймд цэргийн алба хаах насны доод хязгаарыг 18 нас байхаар заасан боловч байлдааны үйл ажиллагааны үед насанд хүрээгүй хүнийг татан оролцуулахыг хориглох заалтыг Цэргийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай болон Зэвсэгт хүчний тухай хуулиудад тусгах нь зүйтэй байна.

(b) Хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох

b.1 Хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглах, зуучлах, санал болгох

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд “садар самуун явдал” гэх нэр томъёог биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлүүлэх, эсхүл эдгээр үйлдэлд бусдыг татан оролцуулах, түүнчлэн садар самууныг сурталчлахыг ойлгохоор, “садар самууныг сурталчлах” гэдгийг бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг ойлгохоор тодорхойлж, тус хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 12.6 дугаар зүйл болон Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлүүдэд тус тус заажээ.

Гэхдээ Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлийн тайлбар хэсэг болон 13.1 дүгээр зүйлд зааснаас харахад насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлэхэд зуучилсан үйлдлийг орхигдуулж, биеийг нь үнэлүүлсэн тохиолдолд ял шийтгэхээр харагдаж байна. Иймд насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлэхэд зуучилсан үйлдэл нь хуулиар хариуцлага хүлээхээргүй байгаад анхаарал хандуулж, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай юм.

b.2 Хүүхдийг садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “18 насанд хүрээгүй хүнд эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих урлаг, үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн, бусад үзвэрийг үзүүлэхийг хориглоно”, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “18 насанд хүрээгүй хүнийг шөнийн цэнгээний газарт оруулах болон эротик тоглолтод оролцуулахыг хориглоно” гэж тус тус заасан. Үүнээс үзэхэд манай улс үндсэндээ садар самуун үйл ажиллагаанд 18 насанд хүрээгүй хүнийг оролцуулах, ашиглахыг аливаа нөхцөлгүйгээр хориглосон байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам зөрчсөн, эсхүл хуульд заасан эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйлийг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан, хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол” гэж тус тус заажээ.

(с) Олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох

Монгол Улс Мансууруулах эмийн тухай НҮБ-ын 1961 оны 84 дүгээр конвенцод 1990 онд, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын 1971 оны конвенцод 1999 онд, Мансууруулах эм ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны 87 дугаар конвенцод 2001 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенцод 2008 онд тус тус нэгдэн орсон.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийн үйлдвэрлэл, ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай (2002) хуулиар зохицуулж байна. Тус хуульд “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг насанд хүрээгүй хүнд худалдах, олгохыг хориглоно” гэж заасан бол хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Эрүүгийн хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.7 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсгүүдэд тус тус заасан. Мөн “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”¹³-д мансууруулах үйлчилгээтэй болон сэтгэцэд нөлөөлөх эмийн ургамал, түүхий эд цуглуулах үйл ажиллагаанд хүүхэд ажиллуулахыг хориглохоор тусгасан тул энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх” гэмт хэрэгт тооцон хариуцлага хүлээлгэх боломжтой юм.

Харин Эрүүгийн хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг үйлдэхэд “насанд хүрээгүй хүүхдийг ашигласан, татан оролцуулсан” байдлыг харгалзан үзэх шаардлагатай.

(d) Ажлын шинэ чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц болон Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон

¹³ Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 дугаар тушаалаар баталсан.

нэн даруй устгах тухай ОУХБ-ын 190 дүгээр зөвлөмжид тусгасан хүүхдэд хор нөлөө үзүүлэх ажлыг нэгтгэж үзвэл хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөх аюултай ажилд хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц, эрүүл бус орчинд гүйцэтгэхэд хүргэж буй ажлуудыг оруулж үзэхээр байна. Харин хүүхдийн аюулгүй байдалд хор нөлөө үзүүлэх ажилд газар дор, усны гүнд, аюултай өндөрт эсвэл хэтэрхий давчуу орон зайд хийж буй, аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж зэвсэгтэй харьцаж буй ажил хийгээд хүнд ачааг гараараа өргөж зөөх болон тээвэрлэх зэрэг биеийн хүчний ажил, тодорхой хүнд нөхцөлд, тухайлбал уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар, эсвэл ажил олгогчийн ажлын байранд барьцаалагдан хүчээр хийж буй ажил багтаж байна. Хүүхдийн ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлыг ОУХБ - ын 190 дүгээр зөвлөмжид заасны дагуу тусад нь авч үзэх нь зүйтэй байна.

Ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлын талаар Хөдөлмөрийн тухай (2021) хуулийн 142 дугаар зүйлийн 142.9 дэх хэсэгт зааснаар насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглох ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батлан мөрдүүлж ирсэн байна.¹⁴

Хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажлын талаар Хөдөлмөрийн тухай хуулийн 142 дугаар зүйлийн 142.2 дахь хэсэгт заасан бөгөөд “хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц” ажлыг энд хамааруулсан нь дэвшилттэй алхам болжээ. Мөн Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйлд хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх үйлдэл нь гэмт хэрэг байхаар заасан ч тэвчишгүй хөдөлмөрийг зөвхөн “зориуд эрхлүүлсэн” шинжтэй байхаар хязгаарласныг өөрчлөх шаардлагатай байна.

Хүүхдийг сэтгэл санааны хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил гэсэн ойлголтыг хөдөлмөрийн харилцааны хүрээнд хуульчлан тодорхойлох шаардлагатай бөгөөд ингэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2016) хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасныг харгалзан үзэх нь зүйтэй байна.

Газар дор, усны гүнд болон аюултай өндөрт эсвэл хэтэрхий давчуу орон зайд хийж буй ажлыг хуульд тусгайлан тодорхойлсон зохицуулалт байхгүй бөгөөд насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглох ажлын байрны жагсаалт болон

¹⁴ Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын “Эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүмүүсийн хийхийг хориглосон ажлын байрны жагсаалт батлах тухай” 1999 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/204 дүгээр тушаал, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 2008 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/107 дугаар тушаал, Хөдөлмөрийн сайдын “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/36 дугаар тушаалаар энэ асуудлыг зохицуулж иржээ.

“Хөдөлмөрийн эрүүл ахуй, ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2015 стандартын дагуу тодорхойлж байна.

Аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж зэвсэгтэй харьцаж буй ажил, түүнчлэн хүнд ачааг гараараа өргөж зөөх болон тээвэрлэх зэрэг биеийн хүчний ажлын асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 142 дугаар зүйлийн 142.4 дэх хэсэгт зааснаар насанд хүрээгүй хүний хөнгөн ажлын төрлийг журмаар зохицуулан нарийвчлан заах шаардлагатай. Хэрэв энэ заалтыг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хариуцлагыг хүлээхээр байна.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт зааснаар хүүхдийг аюултай бодис, урвалжтай харьцах, аюултай ажилбар гүйцэтгэхэд хүргэж буй ажлыг 18 нас хүрээгүй хүн эрхлэхийг хоригложээ.

Тодорхой хүнд нөхцөлд тухайлбал уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар, эсвэл ажил олгогчийн ажлын байранд “барьцаалагдан” хийж буй хүүхдийн ажлыг хориглох талаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байх¹⁵ бөгөөд тэднийг шөнийн цагаар¹⁶ болон илүү цагаар¹⁷, уртын ээлжээр¹⁸ ажиллуулахыг хориглоно, мөн урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг албан томилолтоор ажиллуулахыг хориглоно¹⁹ гэж тус тус заасан. Харин насанд хүрээгүй хүүхдийг уртасгасан, шөнийн цагаар эсхүл амралтын өдөр ажиллуулсан бол Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага оногдуулахаар байна.

Цаашид хүүхдийг хуульд зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулсан, мөн хүүхэд ажил олгогчийн байранд барьцаалагдан ажил, хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хууль болон хориглосон ажлын байрны жагсаалтад тусгаж, зохицуулах нь зүйтэй юм.

Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үндсэндээ ажлын байр, хөдөлмөрийн нөхцөл болон ажил, мэргэжлийг тоочих хэлбэрээр баталж, мөрдүүлж ирсэн. Цаашид энэхүү жагсаалтад “хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил, ажил олгогчийн ажлын байранд барьцаалагдан хийж буй ажил, хүүхдийн сэтгэхүй, ёс суртахуунд нөлөөлөхүйц ажлыг нарийн

¹⁵ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэг.

¹⁶ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 88 дугаар зүйлийн 88.6 дахь хэсэг.

¹⁷ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 91 дүгээр зүйлийн 91.5 дахь хэсэг.

¹⁸ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 92 дугаар зүйлийн 92.10 дахь хэсэг.

¹⁹ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 143 дугаар зүйлийн 143.3 дахь хэсэг.

тодорхойлон зайлшгүй тусгаж, шаардлагатай бол энэ талаар тодорхой тайлбар, зөвлөмжийн шинжтэй баримт бичиг гаргах нь чухал байна.

2.2. ОУХБ-ын 138 дугаар конвенц болон үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээ

Монгол Улс тус конвенцод нэгдсэнээр насанд хүрээгүй хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглодог. Хөдөлмөрийн тухай хуулийн 142 дугаар зүйлийн 142.1 дэх хэсэгт зааснаар 15 насанд хүрээгүй хүнийг хөдөлмөр эрхлүүлж болохгүй билээ.

Конвенцын 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт эдийн засаг, боловсролын салбар нь төдийлөн сайн хөгжөөгүй гишүүн улс ажил олгогч, ажилчдын холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр эхний үед 14 насаар тогтоож болно гэжээ. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг ОУХБ-ын 138 дугаар конвенцын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй уялдуулан хөнгөн ажил эрхлэх нас 13 байхаар тогтоосон нь насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шинэлэг үзэл баримтлал болсон. Гэвч ийнхүү хөнгөн ажил эрхлэх насыг 13 байхаар тогтоосон нь тус конвенцын 1 дүгээр зүйлд “... гишүүн улс бүр дотооддоо хүүхдийн хөдөлмөрийг бүрмөсөн устгах үндэсний бодлогыг хэрэгжүүлж, хөдөлмөрийн насны доод хязгаарыг өсвөр үеийнхний бие бялдар болон оюун ухааны хөгжил бүрэн гүйцэд төлөвших насанд хүргэхээр аажмаар нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ”, мөн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Конвенцын 4 болон 8 дугаар зүйлийн дагуу тогтоосон насны хязгаарт хүрээгүй хүнээр хөлсний болон өөр төрлийн хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно” гэж заасан үндсэн зарчмуудаас ухарсан зохицуулалт бөгөөд хуулиар зөвшөөрөхөөс өмнө Монгол Улс хөнгөн хөдөлмөр нь хүүхдийн (a) эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй, (b) хичээлдээ суух, эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн чиг олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамруулах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх гэсэн хоёр үндсэн нөхцөлийг хангасан байх шаардлагатайг зайлшгүй анхаарч, урьдчилан бэлтгэсээр ирлээ.

Хүүхдээр хөнгөн ажил эрхлүүлэх боломжийг хангахдаа дараах шаардлагыг анхаарах ёстой. Үүнд:

1. Ажлын байрыг тоочих буюу жагсаах нь нэг талаас тухайн зохицуулалт хоёрдмол утга агуулдаггүй, ойлгоход хялбар, тухайн заалтыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх боломжийг олгодог боловч нөгөө талаас жагсаалтад багтаагүй

ажлын байранд насанд хүрээгүй хүнийг ажиллуулах боломжийг бий болгодог сул талтай. Иймд конвенц болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад туссан хүүхдийн “эрүүл мэнд”, “өсөлт хөгжил”, “сурч боловсрох”-д саад учруулах нөхцөл байдлыг шинжлэх ухааны үүднээс тодорхойлох шаардлагатай. Эдгээрээс гадна хүүхдийн эрхлэх ажил, хөдөлмөрийн нөхцөлд хамаарах нас, хүйс, ажлын цаг, хэрэглэх багаж, төхөөрөмж, зэрэг нэмэлт нөхцөлүүдийг оруулан зохицуулах нь зүйтэй байна.

2. Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцын 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Эрх бүхий байгууллага нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсгүүдийн заалтад зөвшөөрсөн хөлсний болон өөр төрлийн хөдөлмөр эрхлэх цар хүрээ, ажлын цаг, ажиллах нөхцөлийг тогтооно” гэж заасан нь 13-15 насны хүүхдийн ажиллах цаг, ажиллах нөхцөлийг тусгайлан тогтоох шаардлагыг бий болгож байна. Гэвч Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт “Насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байна”, 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “насанд хүрээгүй ажилтан» гэж энэ хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож байгаа 18 насанд хүрээгүй хүнийг ойлгоно” гэж тус тус зааснаас үзэхэд 13-18 насны хүүхдийн ажлын цагийн хязгаарыг хэт нийтлэг байдлаар тодорхойлжээ. Энэ нь дээр дурдсанчлан “сурч боловсроход саад учруулах” нөхцөл байдалтай холбогдох тул 13-15 насны хүүхдийн ажиллах цагийн хязгаарыг конвенцод заасан насны бүлэг бүрээр тусгайлан заах шаардлагатай байна.

Тодорхой салбарт ажилд авах насны доод хязгаарыг тогтоох тухай

Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцын удиртгал хэсэгт Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл Женев хотноо хуралдаж, 1973 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 58 дугаар хуралдаанаар хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоох тухай тодорхой саналуудыг батлахаар шийдвэрлэхдээ Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1919 оны конвенц, Далайн тээвэр хийх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1920 оны конвенц, Хөдөө аж ахуйн салбарт ажиллах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1921 оны конвенц, Хөлөг онгоцонд нүүрс ачих, галч хийх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1921 оны конвенц, Аж үйлдвэрийн бус салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1932 оны конвенц, Далайн тээвэр хийх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1936 оны конвенц, Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1937 оны конвенц, Загас

агнуурын салбарт хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1959 оны конвенц, Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1965 оны конвенцын заалтуудыг анхаарах талаар тусгайлан дурджээ.

Монгол Улсын хувьд эдгээр конвенцоос Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 59 дүгээр конвенц, Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 123 дугаар конвенцыг тус тус соёрхон баталсан.²⁰ Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 59 дүгээр конвенцын хувьд Монгол Улс соёрхон баталсан боловч 2003 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ОУХБ-ын 138 дугаар конвенцын дагуу шууд цуцлагдсан байна.

2.3 Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, дүрэм журамд өөрчлөлт оруулах талаар:

1. Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний 82 дахь хэсэгт “2012-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнд тулгуурлан шинэчлэн батлах” гэсний дагуу хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан боловсруулах;
2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, хориглох чиглэлээр батлан мөрдүүлж буй бодлогын баримт бичиг, хөтөлбөр, арга хэмжээг боловсруулахдаа хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг тодорхой болгох, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээг тодорхой тусгах;
3. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
4. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэх нэр томъёоны тодорхойлолтод “тэвчишгүй хөдөлмөрт өртсөн хүүхэд” гэж нэмж тусгах;
5. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 84 дүгээр зүйлд “13-15 насны хүүхдийн ажиллах цагийн хязгаар”-ыг заалт болгон оруулах;
6. Циркийн үзүүлбэр, уран нугаралт, акробат зэрэг урлаг, спортын үзүүлбэрийг

²⁰ Эх сурвалжийг бүрэн эхээр нь дараах холбоосоор үзнэ үү: <https://legalinfo.mn/mn/detail/1253>

- хүүхдээр хийлгэхэд хөдөлмөр, хамгаалал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажлын байрны нөхцөл, шаардлагыг тодорхойлох;
7. Эрүүгийн хуульд “өрийн төлөөс, хамжлагын албат” болгох үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулахаар заах;
 8. Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлийн “Албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэрэгт насанд хүрээгүй хүнийг албадан хөдөлмөрлүүлсэн үйлдлийг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулж, оногдуулах ял, шийтгэлийг чангатгах; Тухайлбал цалин хөлс төлсөн ба төлөөгүй эсэхээс үл хамааран хариуцлага тооцдог болгох;
 9. Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн...” гэсний дараа “, биеэ үнэлэхэд зуучилсан” гэж нэмж тусгах;
 10. Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд “энэ гэмт хэргийг үйлдэхдээ насанд хүрээгүй хүүхдийг ашигласан, татан оролцуулсан” гэж нэмэх;
 11. Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол...” гэсний “зориуд” гэснийг хасах;
 12. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил олгогчийн байранд хашигдан хийх ажил”-ыг хориглох талаар нэмж тусгах;
 13. Хүүхдийг хуульд зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмж тусгах;
 14. Дайны байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлд “Дайны байдлын үед цэргийн дайчилгаанд 18 нас хүрээгүй хүүхдийг оролцуулахгүй байх” талаар нэмж тусгах;
 15. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад “хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил, техник, технологийн дэвшил, хурдацтай хөгжиж буй өнөө үетэй нийцүүлэн хүүхдийн сэтгэхүй, ёс суртахуунд нөлөөлөхүйц ажлыг нэмж тусгах;
 16. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр оршиж байгаа газрыг тогтоох, олон нийтийн болон төрийн захиргааны байгууллагын хяналт, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сайжруулах.

БҮЛЭГ 3.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДАЛ



Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийн судалгааг өргөн хүрээнд гурван удаа хийснээс хамгийн сүүлийнх нь 2012 онд хийжээ. Энэ нь хүүхдийн хөдөлмөрийн өнөөгийн нөхцөлийг тодорхойлсон судалгаа, статистик мэдээлэл дутмаг, цаашлаад хүүхдийн хөдөлмөрийн талаар бодлогын түвшинд оновчтой үйл ажиллагаа явуулах боломжгүй байгааг илтгэнэ. Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэх, түүнээс хөндийрөх нөхцөлийг бүрдүүлэхэд эрх зүйн зохицуулалт, хамтрагч талуудын хамтын ажиллагаа, мэдлэг ойлголт, хандлага дутмаг байна. Түүнчлэн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдэд ажил олгож буй ажил олгогчийн зүгээс хүүхдээр ажил эрхлүүлэх, хөдөлмөрийн харилцаанд оролцуулж байгаа үед тэдний нас, ажиллах цаг, ажлын нөхцөл, нийгмийн хамгааллыг хангах, тэдний оролцоог бий болгох чиглэлээр ойлголт, мэдлэг хангалтгүй байгаа нь ажил олгогчидтой хийсэн ярилцлагын үеэр ажиглагдлаа. Энэхүү тодорхойгүй нөхцөл байдлын дунд хүүхэд үйлдвэрлэл, үйлчилгээний бүх салбарт эдийн засгийн хийгээд эдийн засгийн бус үйл ажиллагаанд өдөр тутам ажил, хөдөлмөр эрхэлсээр байна.

ГБХЗХГ-ын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн санд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бүртгэдэг мэдээллийн бааз бий болгосон нь сайшаалтай ч мэдээллээ бүртгэдэг аргачлал нь тодорхойгүй, орон нутгийн хүүхдийн байгууллагын ажилтнууд нь мэдээлэл бүртгэх аргачлалаа ашиглах чадвар сулаас мэдээлэл зөрүүтэй бүртгэгдэж байна. Тухайлбал хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн насны ангиллыг 7-9 нас, 10-14 нас, 15-18 насаар бүртгэж байгаа нь конвенц болон үндэсний хууль тогтоомжид заасан насны ангилалтай таарахгүй байна. Мөн хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрөгдсөн хэлбэрийг бүртгэхгүй байгаа нь өрөөсгөл байна. Зарим орон нутгаас ирүүлсэн мэдээлэл нь хурдан морь унаач хүүхдийг давхардуулан бүртгэсэн, ХХҮЕГ-ын Хөдөлмөрийн биржээр дамжин ажилд орсон хүүхдийн мэдээлэл огт бүртгэгдээгүй, мэдээллийн бүртгэлийн ангилал нь тодорхойгүй, дутуу зэрэг олон асуудал байгааг сайжруулах, ҮСХ, ХХҮЕГ-ын мэдээллийн сантай холбогдох, мэдээллээ солилцох шаардлагатай байна.

Мэдээллийн эргэлт хангалтгүй байгаагаас ажил, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдэд үзүүлэх хариу үйлчилгээ, тэдний эрхийг хамгаалах асуудал орхигдсон, холбогдох төрийн байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд бусад асуудлыг тус тусдаа шийдвэрлэсэн байдалтай адил авч үздэг бөгөөд шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл нь хүүхдийн байгууллагад огт ирдэггүй байна.

3.1 Тэвчишгүй хөдөлмөрийн хэлбэрт өртөх эрсдэлтэй хүүхдийн талаар

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцод хүүхдийн хөдөлмөр нь ядуурлаас их хэмжээгээр шалтгаалдаг бөгөөд түүнийг шийдвэрлэх урт хугацааны арга зам, нийгмийн дэвшилд хүргэх эдийн засгийн тогтвортой өсөлт, ялангуяа ядуурлыг арилгах, бүх нийтэд боловсрол олгох үйл ажиллагаанд оршиж байгааг хүлээн зөвшөөрч, гишүүн орнуудад нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах, ядуурлыг бууруулах, бүх нийтэд боловсрол олгохыг зөвлөжээ.²¹ Мөн Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд бизнесийн салбарын үзүүлэх нөлөөний талаар төрийн хүлээх үүргийг заасан 2013 оны 16 дугаар Ерөнхий зөвлөмжийн дагуу “Гишүүн улс нь бизнесийн байгууллагуудаар хүүхдийн эрхийн талаарх олон улсын болон үндэсний хүний эрхийн баримт бичгүүд, хөдөлмөрийн орчин, бусад стандартыг мөрдүүлэх талаарх хуулийг боловсруулан сахиулах” үүрэгтэй байна.

Сүүлийн жилүүдэд манай орны ядуурал дорвитой буураагүй тул орлогын тэгш бус байдалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Ядуурлын түвшинг бууруулж, хүрсэн амжилтаасаа ухрахгүй байх, цаашид үргэлжлүүлэн бууруулах нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хориглох, устгах үйл ажиллагаанд чухал дэмжлэг болохоор байна.

Түүнчлэн ядуурал нь хүүхдүүдийн хувьд боловсрол эзэмших боломжийг хааж, үүнийгээ дагаад ирээдүйд хүрэлцээтэй цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж буурах, улмаар амьжиргааны түвшин, доройтлоос үүдэн гэр бүлийн зөрчил маргаан нэмэгдэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлэх, үл хайхралт, хараа хяналтгүй хүүхэд бий болох нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал ярилцлагын үеэр нэгэн оролцогч “Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлого зохицуулалт хангалттай гэж боддог ч иргэдийн амьдралын ядуу байдал хүүхдэд нөлөөлж байна. Эцэг, эхчүүдийг ажилтай болгоход илүү анхаарах хэрэгтэй” хэмээн хэлсэн.

Конвенцоор бүх нийтийн боловсролд анхаарал хандуулахыг зөвлөсөн нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгахад хүн бүрийн боловсрол чухал байгаагийн илэрхийлэл юм. Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа нь хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн боловсролын түвшин, буруу дадал зуршлаас үүдэлтэй тохиолдол багагүй гарч байна. Тухайлбал нэгэн

²¹ Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцын удиртгал хэсэг, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай ОУХБ-ын 190 дүгээр зөвлөмжийн 16 дугаар зүйлийн (г) хэсэг.

аймгийн Насан туршийн боловсролын байгууллагын ажилтан “Ажил хийдэг хүүхдүүдийн эцэг, эх нь боловсролгүй байх нь бас л 80, 90 хувьтай, олон хүүхэдтэй байх зэрэг нийтлэг шинжүүд байна” гэж хэлсэн.

Хараа хяналт сул байгаа хүүхдүүдийн гэмт хэрэгт өртөх магадлалтай талаар нэгэн аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч “Хараа хяналтгүйгээр гэр бариад айлын хашаанд амьдардаг, эсвэл өөрийнхөө гэрт насанд хүрсэн хүнтэй биш дангаараа амьдардаг хүүхдүүд их байгаад байна. Энэ бол бид нарын өгч буй нэршлээр өрх толгойлсон хүүхэд юм ... Ер нь бол эцэг, эхийн хараа хяналт сул хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож, өртдөг” гэж хэлсэн.

Хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-ын ажилтантай хийсэн ярилцлагаар “Бэлгийн мөлжлөгт өртөж байгаа шалтгаан, сонирхол нь өсвөр насны цахим орчны нөлөө, хүүхдийн ялгаварлан гадуурхалт зэрэг нь маш их нөлөөтэй гэжээ. Энэ асуудлаас урьдчилан сэргийлэх арга бол эцэг, эх, гэр бүлийн зүгээс маш их анхаарал хандуулах шаардлага байна. Бүх бэлгийн мөлжлөг бүр цахим хэлбэрт орсон нь охидыг бэлгийн амьдралд эрт орох, хүчирхийлэлд өртөх нөхцөлийг бүрдүүлж байна. Үүнд хяналт тавих боломж хомс болж байгаа учир эцэг, эх л анхаарах хэрэгтэй юм” гэсэн.

Үүнээс хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлт нь эцэг, эхийн боловсролгүй, хорт зуршилтай байдлаас үүссэн өрхийн ядуурал, түүнээс үүдэлтэй архидалтаас хамааралтай бол хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт тооцогдох гэмт хэрэг, зөрчил, хар тамхи, мансууруулах бодис, биеэ үнэлэлтэд өртөх байдал нь ядуурлаас тэр бүр хамааралгүй тохиолдолд үл хайхралтай илүү хамааралтай байгаа нь харагдаж байна. Түүнчлэн ядуурал болон үл хайхралтад нэгэн зэрэг өртсөн хүүхэд байхыг үгүйсгэхгүй боловч энэ судалгааны зорилго, зорилтод тусгагдаагүй тул тухайн бүлгийг тусгайлан судлаагүй болно.

Сүүлийн гурван жилийн дотор аливаа ажил, хөдөлмөр эрхэлсэн гэж хариулсан 468 хүүхэд байгаа нь 28,2 хувийг эзэлж байна. Ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн ар гэрт ажил, хөдөлмөр эрхэлж орлого олдог өөр нэг гишүүн байгаа гэж судалгаанд оролцосон хүүхдүүдийн 34 хувь, хоёр гишүүн байгаа гэж 49 хувь хариулсан нь ажил эрхэлдэг гэж хариулсан хүүхдүүдийн 82 хувийг эзэлж байв. Харин ар гэрт нь ажил хийдэг бусад 3 гишүүн байгаа гэж 13 хувь, 4 болон түүнээс дээш гишүүн байгаа гэж 4 хувь нь хариулжээ. Үүнээс үзэхэд өрхөд ажил хийдэг хүний тоо нэмэгдэх тусам хүүхдийн хөдөлмөр эрхлэлт буурах харилцан хамаарал илэрч байна.

Хүснэгт 9. Сүүлийн 3 жилийн дотор ажил, хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийн ар гэрийн нөхцөл байдал, өрхийн гишүүдийн тоогоор

Амьдарч байгаа газар	Дотуур байранд	Өөрийн гэрт	Түрээсийн байранд	Хамаатны айлд	Хамаатны бус айлд	Өвөө, эмээгийн дээ	Нийт
Ажил хийсэн	39	323	27	49	1	27	468
Өрхийн 1 гишүүн	12	103	11	18		11	157
Өрхийн 2 гишүүн	21	168	10	22		9	230
Өрхийн 3 гишүүн	2	43	5	7	1	4	63
Өрхийн 4 болон түүнээс дээш гишүүн	4	9	1	2		3	19
Ажил хийгээгүй							1,189
Нийт	39	323	27	49	1	27	1,658


Ажил, хөдөлмөр эрхлэлтэд өртөх эрсдэлтэй хүүхдүүдийн дотор МСҮТ-ийн суралцагчид нь ЕБС-д суралцагчдаас ялгаатай байгаа нь ажиглагдсан.

МСҮТ-д хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн асуудал маш их байна. Энэ оюутнууд 18 нас хүрээгүй хүүхдүүд байдаг. Зүгээр хөдөлмөр эрхлээд цалинтай, цалингүй дадлага хийгээд явдаг. Судалгаа авахад тэр дадлага хийлгэж байгаа газрууд хүүхдийг хайрлахгүйгээр зөвхөн зарах зорилготой байдаг. Хүүхэд гэж харах биш ажиллах хүч гэж хардаг. Тухайн өдрөө тэр хүүхдээр албан байгууллага ажлаа хийлгээд тэд нарын ажил бүтэж байвал тэр хүүхэд хэдэн цагт босоод хэдэн цагт явж байгаа нь сонин биш. Дадлага хийж байгаа хүүхдээр цэвэрлэгээ хийлгэдэг газрууд байна. Өглөө 9 цагаас ажил эхэлдэг байтал үүрийн 5 цагт босоод явчихдаг. Үүрээр 5 цагт босож явж байгаад тэр хүүхэд хүчирхийлэлд өртвөл яах вэ, ямар нэгэн асуудалд орвол яах вэ гэдэг асуудал гарч ирдэг. Энэ бол байж болохгүй зүйл. Тийм тохиолдол гарч байгаа. Хүүхдийн хөдөлмөрийг мөлждөг тийм газрууд байна. Дадлага ярихаар хүүхдийн хөдөлмөрийг шулаад байгаа асуудал байна. Энэ бол байж боломгүй зүйл. Хүүхэд эрт очихгүй бол дадлага хийсэнд тооцохгүй гээд хасчих учраас заавал хэлсэн цагт нь очдог.”

(Нэгэн аймгийн ГБХЗХГ-ын ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас)

Иймд МСҮТ-д хүүхдүүдийг дадлага хийлгэх нэрээр хөдөлмөрлөх эрхийг зөрчдөг байх магадлал өндөр байгаа тул энэ асуудлыг хянах, шалгах чиглэлээр судалгаа хийж холбогдох байгууллагууд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

МСҮТ болон ЕБС суралцагчдын ажил, хөдөлмөр эрхлэх байдлыг харьцуулж үзэхэд МСҮТ-ийн суралцагчид ажил, хөдөлмөр эрхлэх нь ЕБС-ийн суралцагчдаас 1.8 дахин их байна.



Судалгаанд хамрагдсан 1,658 хүүхдээс сүүлийн гурван жилийн дотор ажил, хөдөлмөр эрхэлсэн 468 хүүхэд байна. Тэдний суралцаж буй боловсролын байгууллагыг авч үзвэл 64 хувь нь МСҮТ-д, 36 хувь нь ЕБС-д суралцаж байна.

Ажил хийхэд заримдаа өглөө эрт босох хэцүү байдаг. Гэрийнхээ бүх ажилд тусалдаг, тоглох зав бага. Дүү нар гэрээ цэвэрлэдэг. Ар гэрийн байдал сайн бол ажил хийх шаардлага надад байхгүй, сургуульдаа сурч, мэргэжилтэй болмоор байна.

(Ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас)

Ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд гэрийн ажлаас гадна насанд хүрсэн хүний ажилд цалин хөлсгүй туслах байдал энэхүү судалгаагаар илэрсэн. Өөрөөр хэлбэл хүүхэд ажил, хөдөлмөр эрхэлж, мөнгө олохын зэрэгцээ гэрийн ажилд олон цаг зарцуулах нь хүүхдийн сурч боловсрох эрхэд халдсан явдал юм. Хүүхэд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, гэрийн ажилд оролцож, насанд хүрсэн хүний ажилд цалин хөлсгүйгээр тусалж байгаа нөхцөл байдлын талаар судалгааны тайлангийн энэхүү 3 дугаар бүлгийн 3.3 дахь дэд бүлгээс илүү дэлгэрэнгүй танилцах боломжтой юм.

3.2 Монгол Улс дахь хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн хэлбэрүүд

3.2.1 Хүүхдийг боолчлох, албадан хөдөлмөрлүүлэх хэлбэр

Боолчлолын шинжтэй аливаа ёс, заншил энэхүү судалгааны явцад илрээгүй боловч боолчлол, орчин цагийн боолчлолын хэлбэр болох албадан хөдөлмөрийн шинжийг агуулсан тохиолдлууд цөөнгүй илэрсэн билээ.

Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай НҮБ-ын нэмэлт конвенцын IV хэсгийн 7 дугаар зүйлийн (а) хэсэгт өрөнд баригдаж боолчлогдсон өөрөөр хэлбэл өртэй хүн өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсоор үнэлсэн үнэлгээ нь уг өрийн төлөөсөнд тооцогдохгүй, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус бол гэж заасан байдаг. Харин энэхүү судалгааны явцад эцэг, эхийнхээ өрийг төлөх, орон гэргүй болох эрсдэлийг давхар үүрч ажил, хөдөлмөр хийж байгаа хүүхдүүд хэд хэд илэрсэн нь дээрх конвенцод заасан “... хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл ...” гэж заасантай дүйцэхүйц хэлбэрүүд мөн байлаа. Тухайлбал судалгааны явцад эцэг, эхийнхээ өрийг төлөхийн тулд ажил хөдөлмөр хийдэг хүүхэд байдаг талаар нэгэн хүүхэд хэлсэн.

Найз маань онц сурдаг, ирээдүйд хуульч болно гэж ярьдаг байсан. Гэхдээ аав нь нас бараад, ээж нь өвчтэй болсон болохоор эцэг, эхийнхээ тавьсан өрийг дарах гээд аргагүй эрхэнд 11 дүгээр ангиасаа сургуулиа орхиод ажил, хөдөлмөр эрхэлж байгаа. Сардаа олсон мөнгөө өр төлөхөд зарцуулдаг болохоор гэртээ болон өөртөө юм авч чаддаггүй. Хүүхдэд өгдөг хөдөлмөрийн хөлс бага болохоор хоёр ажил хийсэн ч гэсэн сардаа 500,000-800,000 төгрөг олдог учир хүрэлцдэггүй. Манай найз өглөө нь цагийн ажил хийдэг, худалдагч, бараа өрөх гэх мэт, үдээс хойш нь бааранд ажилладаг. Миний хувьд ажил хийдэг найзууд олон бий. Бид энэ найздаа ажил, хөдөлмөр эрхэлж, олсон мөнгөөрөө гэрт нь хоол унд авч өгдөг. Саяхан мөнгөө нийлүүлээд гэрт нь хонины мах авч өгсөн. Бүтэн том хонины мах авах гэсэн хүрээгүй л дээ. Тэгээд төлөгний мах авч өгсөн.

*(Ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлагаас)*

Түүнчлэн асуулгын судалгаанаас харахад эцэг, эх асран хамгаалагчийнхаа өрийг төлөлцөхийн тулд ажил эрхлэх болсон хүүхдүүд цөөнгүй байна. Доорх хүснэгтэд хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааныг давтамжаар нь ангилан харуулав.

Хүснэгт 10. Хүүхдийн ажил эрхлэх болсон шалтгаан, давтамжаар, хувиар

д/д	Ажил эрхлэх шалтгаан	Тоо	Хувь
1	Өөрийнхөө дуртай хэрэгтэй зүйлийг худалдаж авахын тулд	291	51
2	Эцэг, эх, гэр бүлдээ дарамт болохгүйн тулд өөрийгөө болгохын тулд	213	37
3	Эцэг, эх, асран хамгаалагчийнхаа өрийг төлөлцөхийн тулд	45	8
4	Бусдын шахалтаар ажил хийсэн	12	2
5	Найздаа туслахын тулд	9	2

Энэхүү хүснэгтээс бусдын өрийг төлөхөөс гадна бусдын шахалтаар болон найздаа туслах зорилгоор буюу бусдын эрх ашгийн төлөө ажил хийх тохиолдол цөөнгүй байгаа гэж дүгнэж болохоор байна. Иймд хүүхдээ албадан хөдөлмөрлүүлэх эрсдэлд оруулж буй эцэг, эх, асран хамгаалагчид хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тодорхой тусгах шаардлагатай юм.

НҮБ-ын Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц болон Албадан хөдөлмөрийн устгах тухай ОУХБ -ын 105 дугаар конвенцод “... хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус...” гэж тодорхойлсон тэвчишгүй хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд энэхүү судалгаагаар цөөнгүй илэрсэн юм. Ялангуяа чанарын судалгааны явцад хүүхдүүд ямар нэгэн байдлаар хөдөлмөрийн гэрээ, иргэний хэлцэл байгуулаагүйгээс үүдэн ямар ажил, хөдөлмөр эрхэлж гүйцэтгэхээ, хэдэн цаг ажиллахаа, ямар нөхцөлд, хэр хэмжээтэй ажил үүрэг гүйцэтгэхээ мэдэхгүйгээр ажиллаж байгаа болохоо илэрхийлжээ. Чанарын судалгааны явцад ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдээс гэрээ байгуулж ажил хийсэн нэг ч хүүхэд байгаагүй. Тухайлбал ажил хийдэг хүүхэд “Гэрээ гэх юм байхгүй. Ажлын байранд гэмтэж бэртвэл захирал нь өөрөө хариуцна гээд аман гэрээ хийдэг” гэж хариулсан байна.

Хүүхдээр ажил, хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчтой хийсэн ярилцлагаар “Эцэг, эх, ажиллах гэж байгаа хүүхэд, ажил олгогч гэсэн гуравласан гэрээ маягтай зүйл А4 цаасан дээр гараар өргөдөл шиг юм бичүүлээд ажиллуулдаг. Албан ёсны

тийм хуулиар хийсэн гэрээ гэх зүйл байхгүй. Бид хөдөлмөрийн гэрээ хийх гэхээр НДШ 11,5 хувь байснаа одоо 12,5 хувь болчихоор ажилтнууд дургүй байдаг” гэжээ. Харин ТББ-ын ажилтантай хийсэн ярилцлагаар ажил олгогчид хүүхдээр ажил, хөдөлмөр эрхлүүлэхийн давуу талыг “Ажил олгогчийн хувьд хүүхдийн хөдөлмөрийн хөлс бага, хямд ажиллах хүчин гэж үздэг. Гэрээ хийх шаардлагагүй, дуртай цагтаа дуудна, өөр ажил ч хийлгэх боломж байдгаас ажиллуулах сонирхолтой байдаг” гэсэн байна.

Ажил олгогчид, хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчид болон төрийн болон ТББ-ын ажилтан, алба хаагчид гэсэн оролцогч талууд бүгд хүүхэдтэй гэрээ байгуулж ажиллуулдаг тохиолдол маш цөөн бөгөөд гэрээ байгуулсан ч хэлбэр төдий, ажлын хөлс, хөдөлмөрийн нөхцөл, ажиллах цагийг тохиролцдоггүй нөхцөл байдал нийтлэг байгааг хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болохоор байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд дээр дурдсанчлан эцэг, эх нь хүүхдээ өөртөө туслуулах эсвэл танилынхаа ажлын байранд ажиллуулах нь элбэг байх бөгөөд энэ тохиолдолд гэрээ байгуулахгүй зөвхөн амаар тохиролцдог нийтлэг жишиг ажиглагдлаа. Энэ нь гэрээгүй ажиллах хамгийн түгээмэл тохиолдол байна.

Энэ мэтчилэн гэрээгүй, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цаг, цалин хөлс тодорхойгүй байдлаар ажиллаж байгаа хүүхэд өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүйн улмаас боолчлолын шинжтэй хөдөлмөрийн мөлжлөгт өртөж байгаа тохиолдол илэрч байна.

“Аав, ээж нь гэрээ хийгээд өөрсдийнхөө дансаар мөнгийг нь аваад, хүүхэд нь өөр аймагт ажилладаг байсан тохиолдол байна. Тэр хүүхэд ерөнхийдөө хар үгээр хэлэхэд зарцын байдалтай бүх л ажлыг нь хийж байгааг амьдрал дээр нь очоод харж байсан. Зарим хүүхэд гэрээ байхгүйгээ шууд хэлдэг. Зарим нь гэрээ байгаа гэдэг боловч харуулж байсан удаа байхгүй.

(Нэгэн аймгийн цагдаагийн алба хаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас)

Үүнээс үзэхэд гэрээгүй, цалин хөлс, ажлын нөхцөл тодорхойгүй ажиллаж байгаа хүүхдийн ажиллах нөхцөл муудаж, улмаар боолчлолын илүү хүнд хэлбэрт шилжих магадлалтай байна. Тухайлбал хүүхэд ажиллаж байгаа газраа орхиж явах эрхгүй, боломжгүй нөхцөлд хүрсэн тохиолдол цөөнгүй байгаа нь судалгаагаар илэрсэн юм. Судалгаанд оролцсон ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд ихэвчлэн өөр ажил олдохгүй гэх шалтгаанаар ажлын байраа орхиж чаддаггүй бол ажил

олгогчийн дарамт, шахалтаар өрөө төлөхийн тулд ажиллан, ажлын байраа орхих боломжгүй байгаагаа хэлсэн. Энэ нь хүүхдийн эрхийн зөрчил бөгөөд зарим талаар боолчлолын шинжийг агуулж байгаа тул энэ төрлийн таньж, ирүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай. Хүүхэд ажлын байраа орхих боломжгүй болсон шалтгааныг давтамжаар нь ангилж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 11. Хүүхэд ажлын байраа орхиж чадаагүй шалтгаан, давтамжаар

Д/д	Ажлын байраа орхиж болохгүй байсан шалтгаан	Хувь
1	Өөр ажил олоход хэцүү байсан учраас	11
2	Ажил олгогч ажлаасаа гарахыг зөвшөөрөхгүй учраас	4
3	Хамт ажиллаж байгаа, эсвэл ойр дотны хүнийг ажлаас хамт хална гэсэн учраас	2
4	Манай гэр бүлд эсвэл надад ямар нэгэн юм тохиолдоно гэж айсан	2
5	Ажиллуулж байгаа хүнд өртэй учраас	1

Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай НҮБ-ын нэмэлт конвенцын IV хэсэг, 7 дугаар зүйлийн (b) хэсэгт “Хамжлага болох, өөрөөр хэлбэл хууль, заншил, эсхүл гэрээний дагуу түрээслэгч өөр хүний эзэмшил газарт амьдарч шан харамжтай буюу түүнгүйгээр хөдөлмөр хийх болон тухайн хүнд тодорхой зарим үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн нөхцөл, байдал болон уг байдлыг өөрчилж чадахааргүй бол” гэж заасан байдаг. Чанарын судалгааны явцад ядуурал, ажилгүйдэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор ийм тохиолдол Улаанбаатар хотод илүү олон илэрсэн юм. Үүний нэг жишээг дараах ярилцлагын хэсгээс харж болно.

Ээж маань хөдөөнөөс ирээд буух газар байхгүй байсан тул гэрээ хотоос нилээн зайдуу нэг байгууллагын хашаанд бариад, хашаанд буусны түрээсээ төлж амьдардаг. Ажил төрөлгүй, олдсон ажлаа хийдэг. Сүүлийн үед түрээсийнхээ оронд тухайн байгууллагын хашааг цэвэрлэх, байгууллагын хашаа манах, бараа бүтээгдэхүүн буулгах, зөөх, хураах ажил, хөдөлмөр эрхэлж байгаа. Бэлэн мөнгө авдаггүй болохоор хэцүү байдаг. Би ээждээ хааяа ажил хийгээд мөнгө өгдөг.

*(Ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлагаас)*

Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай НҮБ-ын нэмэлт конвенц²²-ын Боолчлолтой адилтгах ёс, заншил хэсгийн 1 дүгээр зүйлд “Энэхүү конвенцод оролцогч улс гүрэн бүр ... хараахан устаагүй байгаа дараах ёс болон заншлыг бүрэн халах буюу устгахыг аль болох богино хугацаанд амжилттай гүйцэтгэхийн тулд бүхий л хэрэгжихүйц болон шаардлагатай хуулийн болон бусад арга хэмжээ авна” гээд (d) хэсэгт “18 нас хүрээгүй болон бага насны хүүхдүүдийг ашиглах буюу тэдний хөдөлмөрийг мөлжих зорилгоор эцэг эхийнх нь аль нэг, эсхүл хоёул, эсхүл асран хамгаалагч нь тэднийг шан харамжтай буюу түүнгүйгээр бусдад²³ өгдөг аливаа “ёс буюу заншил” гэж тус тус заажээ. Судалгаанд хамрагдсан 18 насанд хүрээгүй болон бага насны хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нь шан харамжтай эсвэл шан харамжгүй, бусдад өгдөг гэсэн нь конвенцод заасан үндсэн шинжийг хангаж байна.

Харин хүүхдийн хөдөлмөрийг мөлжих зорилгоор бусдад өгч байгаа эсэхийг тодруулахын тулд “хөдөлмөрийн мөлжлөг” гэдэг ойлголтыг тусгайлан судлах шаардлагатай болсон. Энэхүү ойлголтыг монгол хэл дээрх эх сурвалжид тодорхойлсон онолын тодорхойлолт байхгүй байна. Харин ОУХБ-ын англи хэл дээрх эх сурвалжийг үзэхэд “ажлын байран дахь хөдөлмөрийн мөлжлөг”-ийг илрүүлэхэд 9 шалгуураар шалгадаг байна.²⁴ Эдгээр 9 шалгуурын аль нэгийг хангахад тухайн ажил нь мөлжлөгт тооцогдох бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийн дагуу чанарын болон асуулгын судалгааны үр дүнг ангилан дүн шинжилгээ хийхэд хүүхдийн ажил, хөдөлмөрт хөдөлмөрийн мөлжлөгийн бүх шинж илэрсэн. Ялангуяа хурдан морь унаач хүүхдийн ажил, түүнийг хийж гүйцэтгэдэг нөхцөл нь дангаараа хөдөлмөрийн мөлжлөгийн бүх шинжийг агуулж байгаа нь анхаарал татаж байна.

²² НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1956 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр баталсан. Монгол Улс энэхүү нэмэлт конвенцыг 1968 онд хүлээн зөвшөөрсөн, монгол хэл дээрх эхийг дараах холбоосоор үзнэ үү: <https://legalinfo.mn/mn/detail/1291>

²³ Энэхүү “бусдад өгөх” гэсний англи хэл дээрх хувилбар нь “a child or young person ... is delivered” буюу “хүүхдийг ... хүргэж өгөх эсвэл хүлээлгэн өгөх” гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд үүнийг худалдах, үрчлүүлэх шинжийг агуулна гэж үзэхээргүй байна.

²⁴ ОУХБ, “Хөдөлмөрийн мөлжлөгийн шалгуур үзүүлэлтүүд”, Эх сурвалжийг бүрэн эхээр нь дараах холбоосоор үзнэ үү: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_norm/---declaration/documents/publication/wcms_105035.pdf

3.2.2 Хүүхдийг биеэ үнэлэлт, садар самуунд ашиглах, худалдах хэлбэр

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцын 3 дугаар зүйлд “Энэхүү конвенцын зорилгод нийцүүлэн “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэгт: (b) хүүхдийг биеэ үнэлэх²⁵, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох” гэж заасан байна.

Эрүүгийн хуульд заасан биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт өртсөн хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртсөн хэмээн тооцож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Мөн хүн худалдах, хүн хулгайлах гэмт хэргүүд нь бэлгийн мөлжлөгт өртүүлэх өндөр эрсдэлтэй байдаг тул эдгээр гэмт хэргийг хүүхдийг биеэ үнэлэлт, садар самуунд ашиглах тухай энэ хэсэгт хамруулан авч үзлээ.

Ярилцлагаар хүүхдийг садар, самуунд уруу татсан гэсэн хариултыг шүүж үзэхэд анхаарал татахуйц асуудал илэрсэн. Тухайлбал нэгэн аймгийн ЗДТГ-ын алба хаагч “Насанд хүрээгүй хүүхдүүдийг бэлгийн шинжтэй үйлдэлд уруу татдаг хүн байдаг” гэсэн бол тус аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч “Насанд хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон тохиолдол гарсан. Манай аймгийн 9 дүгээр ангийн 2 охин ар гэрийн боломж муутай хүүхдүүд хааяа ах хүнтэй уулзаж аймгаас гараад машинд нь бэлгийн харьцаанд орж уулздаг, заримдаа мөнгө, утасны нэгж авдаг тогтмол шинжтэй үйлдэл болсон байсан” гэсэн.

Харин нэгэн сургуулийн нийгмийн ажилтан “Өнгөрсөн жил сургуулийн хүүхэд хамгааллын баг дээр нэг жирэмсэн болсон тохиолдол хэлэлцсэн. Нөхөр нь гээд хүн иртэл өөр суманд гэр бүлтэй залуу байсан. Отроор явж байхдаа нөгөө охинтой танилцаад, охин жирэмсэн болчихсон. Ээж нь дагуулж орж ирээд мэдсэн үү гэхээр ээж бол мэдэж байдаг. Гэтэл ээж нь охиноо нөгөө залуутай амьдрахыг зөвшөөрсөн. Бид гайхаж байсан. Иймэрхүү асуудлыг харахаар ихэвчлэн орон нутгийн хүүхэд ийм асуудалд орсон байдаг” гэж хэлсэн. Мөн нэгэн аймгийн ГБХЗХГ-ын алба хаагч “Насанд хүрсэн хүний зүгээс насанд хүрээгүй охинд чи том болчихсон юм чинь ойлгоно биз дээ, байнгын харилцаатай байж болно, чамд ямар нэгэн зүйл хэрэгтэй

²⁵ Харин хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэдэгт дараах үйлдлүүд багтана. Үүнд:

- Хүүхдийн асран хамгаалагч, төрөл садан, эсвэл хэн нэгэн этгээд хүүхдийг хүчээр эрхшээлдээ оруулан хүүхдийг мөлжих, орлого олох зорилгоор ашиглах, өөрийн болон бусдын дур хүслийг хангах хэрэгсэл болгох;
- Биеийг нь үнэлүүлэх;
- Садар самуунд татан оруулах, ашиглах;
- Түүнчлэн хүүхдийг бэлгийн болон сексийн холбогдолтой зан үйл, уламжлал, ёслолын үйл ажиллагаанд оруулах зэргийг багтаана (MCFD, 2003)

болоход санаа зоволтгүй шүү гэж хандсан тохиолдол бол байсан. Ийм байдлаар сэдэл өгчихдөг, нөгөө хүүхдийн хувьд гэр орны нөлөөнөөсөө шалтгаалаад үнэхээр хэрэгцээ шаардлага гараад, аав ээж нь боломжгүй өрхийн хүүхэд бол зөвшөөрөх хандлагатай” хэмээн хэлж байна..

Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн 2018-2020 онд гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүүхдийн талаарх статистик үзэхэд дараах байдалтай байна.²⁶

Хүснэгт 12. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүүхдийн тоо, оноор, байршлаар

Д/д	Хуулийн зүйл, заалт	Он	Аймаг, орон нутаг	Улаанбаатар хот	Улсын дүн
1	Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хүүхдийн тоо	2018	0	1	1
2		2019	0	4	4
3		2020	1	1	2
4	Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлийн биеэ үнэлэхийг зохион байгуулахад өртөж, 13.1 дүгээр зүйлээр шийдэгдсэн гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо	2018	0	0	0
5		2019	0	0	0
6		2020	0	1	1
7	Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн хүн худалдаалах гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо	2018	0	4	4
8		2019	0	5	5
9		2020	0	0	0
10	Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлийн хүн хулгайлах гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо	2018	2	0	2
11		2019	1	1	2
12		2020	1	1	2
13	Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлийн хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэгт хохирсон тоо	2018	0	4	4
14		2019	1	13	14
15		2020	2	5	7
16	Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлийн хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо	2018	0	0	0
17		2019	0	0	0
18		2020	0	0	0

КОВИД-19 цар тахлын улмаас хил хаагдаж олон улсын хилээр зорчих боломжгүй болсон тул цагдаагийн байгууллагад хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдол сүүлийн нэг жилд бүртгэгдээгүй байна. Нэгэн судалгаанд хүүхдийг

²⁶ ЦЕГ-ын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 5/183 дугаар албан бичиг.

албадан хөдөлмөр эрхлүүлж бэлгийн мөлжлөгт оруулахад зарим тохиолдолд гэр бүлийн гишүүд нь хамсаатан болж байгаа бөгөөд өмнөх жилүүдэд эцэг, эхийнх нь гарын үсэг зурж байгуулсан гэрээний дагуу ажиллаж буй уран нугараач монгол охидыг Монгол Улс болон гадаадын зарим улсад албадан хөдөлмөр эрхлүүлж байсан нь бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд хүргэсэн гэж дүгнэсэн байна.²⁷

Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” гэмт хэрэгт өртсөн хүүхдийн тоо 2018 онд 1 байсан бол 2019 онд 4, 2020 онд 2 болж харьцангуй нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо 2018 онд 4 байсан нь 2019 онд 5 болж бага зэрэг нэмэгдсэн бол 2020 онд харин энэ гэмт хэрэгт хохирсон хүүхэд бүртгэгдээгүй байна. Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлд заасан “Хүн хулгайлах” гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо сүүлийн гурван жилд тус бүр 2 илэрчээ.

Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлд заасан “Бэлгийн дарамт учруулах” зөрчилд хохирсон насанд хүрээгүй хүн 2018, 2019 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй бол 2020 онд 5 тохиолдол бүртгэгдсэн байна. Ярилцлагын үр дүнгээс үзэхэд бэлгийн дарамтад хохирсон насанд хүрээгүй хүн өөрөө гомдол гаргахгүй л бол хууль бус үйлдлийг ирлүүлэх боломжгүй, нөгөө талаас хэргийг шийдвэрлэхдээ өгсөн мэдээллийн нууцлалыг хадгална гэдэгт тэд итгэдэггүйгээс хэргийн тоон үзүүлэлт улсын хэмжээнд бүртгэгддэггүй байсан байх магадлалтай гэж үзэж байна.

Ажлын байрны бэлгийн дарамт охидод их хэцүү. Нэг ажил хийсэн. Тэгсэн ажлын газрын нэг ах намайг байнга өддөг. Тэгээд байж байгаад хажууд ирээд сонин сонин юм яриад байдаг. Чи гарч орж яваач, чиний насан дээр ууж идэж, наргиж явах нас. Хүнтэй суучихвал гоё сайхныг мэдрэхгүй гэх мэт. Заримдаа ирээд хажууд зогсоод чи хүнтэй унтаж үзсэн үү? гээд асуудаг. Тэгээд + гэсэн сайт үзүүлээд, энийг ороод үзээч, ийм юм үзсэн үү? гээд Тэгээд чимээгүй байгаад, хариу хэлэхгүй болохоор байж байгаад чихэн дээр ирээд шууд чанга хашхирдаг.

*(Бэлгийн дарамтад өртсөн хүүхэдтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлагаас)*

ЦЕГ-ын ирүүлсэн статистикаас үзвэл Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд заасан “Биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэрэгт 2020 онд насанд хүрээгүй

²⁷ Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яам, “Монгол Улсын хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан”, 2021 он. <https://mn.usembassy.gov/mn/2021-trafficking-in-persons-report-mn/>, <https://www.state.gov/wp-content/uploads/2021/09/TIPR-GPA-upload-07222021.pdf> холбоосноос дэлгэрүүлэн уншина уу.

нэг хүн холбогдсон байна. Харин Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Биеэ үнэлэн эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон” зөрчилд 2018 онд 186, 2019 онд 138, 2020 онд 86 хүн буюу сүүлийн 3 жилд насанд хүрээгүй нийт 410 хүн холбогдсон байна.

Улаанбаатар хотоос бусад аймаг, орон нутагт сүүлийн 2018-2020 онд насанд хүрээгүй нийт 12 хүн энэ зөрчилд холбогдсоноос Дархан-Уул аймагт 7, Дорноговь аймагт 3, Орхон аймагт 2 хүн байв. Харин Улаанбаатар хотын хувьд Сүхбаатар дүүрэгт сүүлийн гурван жилийн дотор насанд хүрээгүй 4, Чингэлтэй дүүрэгт насанд хүрээгүй 27 хүн биеэ үнэлэх зөрчилд холбогдсон нь хамгийн бага үзүүлэлтүүд байсан бол Баянгол дүүрэгт 171, Сонгинохайрхан дүүрэгт 127, Баянзүрх дүүрэгт 72 хүн бүртгэгдсэн нь анхаарал татахуйц өндөр үзүүлэлт байна.

ТББ-ын ажилтантай хийсэн ярилцлагын үеэр “Зах дээр судалгаа хийж байхад тор зардаг охид бэлгийн мөлжлөгт өртсөн асуудал үүсээд бид цагдаа шүүхэд хандаж байсан. Тэд яаж мөлжлөгт өртөөд байгааг үзэхэд фэйсбүүк, утсаар холбогдоод хэнд ч мэдэгдэхгүй далд хэлбэрт орсон байсан. Түүнчлэн МСҮТ-д сурдаг 5 охинтой ажиллаж, сэтгэл зүйчийн үйлчилгээ үзүүлсэн. Охидын бэлгийн мөлжлөгийн хэлбэр нэлээд далд хэлбэртэй байна” хэмээн хэлсэн юм. Мөн хүүхдийн бэлгийн мөлжлөгт өртөж байгаа цаад шалтгааны талаар асуухад тэрээр “Ажилгүйдэл хүчтэй нөлөөлж байна. Бэлгийн мөлжлөгт өртөж байгаа сонирхол нь юу байна гэхээр цахим орчны нөлөө их байна. Хүүхдийг ялгаварлан гадуурхах байдал маш их нөлөөлж байна. Энэ асуудлаас урьдчилан сэргийлэх арга бол эцэг эх, гэр бүлийн зүгээс маш их анхаарал хандуулах. Бэлгийн мөлжлөг бүр цахим хэлбэрт орсон байна. Эдгээр нь охидыг бэлгийн амьдралд эрт орох хүчирхийлэлд өртөх нөхцөл үүсгэж байна. Үүнд хяналт тавих боломж хомс болж байгаа учир эцэг, эх анхаарах хэрэгтэй юм” хэмээн хариулсан.

Биеэ үнэлэлт нь өндөр зохион байгуулалтад орсон үед хувь хүнд маш хүнд хор хохирол учруулдаг. Судалгааны хүрээнд бэлгийн мөлжлөгт өртөж гадаадад биеэ үнэлж байсан насанд хүрээгүй хүнтэй тусгайлан ярилцлагын судалгаа хийж зохион байгуулалттайгаар бусдын биеийг үнэлүүлэх үйл ажиллагааны талаар зарим мэдээлэл авсан билээ. Насанд хүрээгүй хүн зохион байгуулалттай биеэ үнэлэлтэд өртсөнөөр ирээдүйн амьдралд нь гарах сөрөг нөлөөллийн талаар асуухад “Нэгэнт өртсөн хүн 26-27 хүрээд өөрийгөө татаж авч чадахгүй бол ер нь тэгээд амьдрал нь дууссантай адилхан. Дандаа мөнгөтэй, ихэвчлэн ахимаг насны хүмүүст ийм үйлчилгээ үзүүлдэг. Тэд бэлгийн чадавх сул учраас мөнгө төлж гаж зүйлийг сонирхдог. Энэ нь сэтгэл зүйн хувьд стресстэй болгодог. Өдөрт 8-9 ийм

хүнд үйлчлэхэд хар тамхи хэрэглүүлэн, хүсэхгүй байгаа муухай мэдрэмжийг нь алга болгоно. Амьдрал нь утгагүй болоод архи, тамхи, мансууруулах бодист ороод өнгөрдөг нь их байдаг” гэжээ.

Хүүхдүүдээс хэдэн наснаасаа эхлэн, ямар шалтгаанаар зохион байгуулалттай биеэ үнэлэлтэд өртөж байгааг тодруулахад “Ер нь бол 14-15 нас хүрэхэд нь хүмүүст үйлчлүүлж эхэлдэг. Ерөнхийдөө эдийн засгийн ямар ч боломжгүй хүүхдүүд ийм юм хийж байна. Ар гэрт нь ашигтай. Царай муу, сайхан байх нь ялгаагүй” гэжээ. Харин биеэ үнэлснээр хэдий хэмжээний мөнгө олдог талаар тодруулахад “Зуучилж байгаа хүн нь мөнгө авдаг ч, 50-аас илүү хувь авна гэж бол байхгүй. Монгол охид өөрсдөө ядуу амьдралтай болохоор мөнгө олоод ирэхээрээ ийм ажлаас гарч чаддаггүй” гэжээ.

Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах зэрэг гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо өсөж, бэлгийн дарамтад өртсөн хүүхдийн тоо огцом нэмэгдсэн, ялангуяа Улаанбаатар хотын Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд насанд хүрээгүй хүн биеэ үнэлэх явдал түгээмэл²⁸ байгаа нь нийгмийн шинжтэй асуудал болсны цаана бэлгийн мөлжлөг явагдаж байх өндөр магадлалтай байгааг анхаарах шаардлагатай байна. Аймаг, орон нутгуудад охидын бэлгийн болон нөхөн үржихүйн эрх зөрчигдөж бэлгийн хүчирхийллийн хохирогч болох, жирэмслэх тохиолдол цөөнгүй гарч, насанд хүрээгүй, ялангуяа ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд садар самуунд уруу татагдах, бага хэмжээний мөнгө, утасны нэгж зэрэг хэрэглээний зүйл авч хариуд нь бэлгийн харьцаанд тогтмол орох байдал түгээмэл байгааг судалгааны үр дүнгээс дүгнэж болохоор байна.

3.2.3 Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх хэлбэр

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцын энэ заалтад аюултай байдлыг хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх гэсэн гурван хэсэгт ангилж үзэж болохоор байна.

Асуулгын судалгааны үр дүнгээс дүгнэхэд эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн бие, эрүүл мэндэд нь сөрөг нөлөөтэй, гадаа халуун, хүйтэн нөхцөлд ажиллаж байгааг, хүүхдээрээ хүнд, насанд нь тохироогүй ажлыг хийлгэж байгаагаа хүлээн зөвшөөрсөн нь харагдаж байна. Тухайлбал хүүхдүүд уртасгасан цагаар, удаан хугацаагаар, тоосжилттой орчинд ажиллаж байгаа гэж хариулсан нь хүүхдүүдийн өгсөн хариулттай таарч байна. Энэ нь эцэг, эх, асран хамгаалагчид ямар ажил

²⁸ ЦЕГ-ын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 5/183 дугаар албан бичиг.

хийлгэж болох, болохгүйг ялгаж мэддэггүй, тухайн ажил хүүхдэд ямар хор хохирол, сөрөг нөлөө үзүүлж болох талаар тодорхой ойлголтгүй байдаг. Жишээлбэл арьсыг цочроодог, амархан шатдаг, эвгүй үнэртэй, тэсэрч болох, уур ялгаруулдаг, шингэн эсвэл нунтагтай ажиллаж байсан тэд хүүхдийг хортой нөхцөлд, аюултай ажил хийдэг гэж мэддэггүй байх магадлалтай байна.

Хүснэгт 13. Аюултай ажил эрхэлсэн хүүхдийн тухай мэдээлэл, хүүхэд болон эцэг эхийн байр сууриар

Д/д	Ажлын нөхцөл	Хүүдийн тоо	Хувь	Эцэг, эхийн тоо	Хувь
1	Халуун наранд, эсвэл хэт хүйтэнд гадаа ажиллаж байсан	59	13	12	15
2	Хүнд зүйл өргөх, түлхэх, татах	50	11	15	19
3	Ажилдаа өглөө үүрээр очиж байсан эсвэл орой их харанхуй болтол ажилласан	46	10	7	9
4	Гадаа болон байшин дотор шороотой, амьсгалахад төвөгтэй, тоосжилт ихтэй, утаа угаартай, харах эсвэл амьсгалахад хүндрэлтэй газар ажиллаж байсан	38	9	6	8
5	Хашхирч ярих шаардлагатай дуу чимээ ихтэй орчинд ажиллаж байсан	35	8	3	4
6	Хурц иртэй зүйл хэрэглэж байсан	35	8	3	4
7	Нэг үйлдлээ олон дахин завсарлагагүй давтаж олон цагаар ажиллаж байсан	34	8	4	5
8	Цахилгаан багаж хэрэгсэл ашиглаж байсан	26	6	2	3
9	Хөргөгч зэрэг маш хүйтэн газарт эсвэл цастай бороотой эсвэл чийгтэй нойтон цаг агаарт гадаа ажиллаж байсан	21	5	3	4
10	Галтай эсвэл их халуун зүйлтэй ойр ажиллаж байсан	19	4	1	1
11	Их өндөрт авирч ажил хийсэн	17	4	2	3
12	Арьсыг цочроодог амархан шатдаг эвгүй үнэртэй тэсэрч болох уур ялгаруулдаг шингэн эсвэл нунтагтай ажиллаж байсан	15	3	0	0
13	Химийн бодистой эсвэл түүний ойролцоо ажиллаж байсан эсвэл үүнийг хийж байгаа хүнд тусалж байсан	13	3	2	3
14	Тог цахилгаанд өртөж болохуйц ажил, хөдөлмөр эрхэлж байсан	11	2	2	3
15	Хүнд машин механизмтай ажиллаж эсвэл машин барьж байсан	11	2	1	1
16	Газраас доошоо гүнд орж агааргүй давчуу нөхцөлд ажил хийсэн	10	2	3	4

Судалгаанд оролцсон ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд болон тэдний эцэг, эх хүүхдийнхээ хөдөлмөрийн нөхцөлийг төдийлөн тодорхой мэддэггүй болох нь ажиглагдсан. Судалгааны үр дүнд хүүхдийг үл хайхрах явдал нь хүүхдийн садар самуун, биеэ үнэлэлт, мансууруулах бодис зэрэг гэмт хэрэг, зөрчилд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг төдийгүй аюултай нөхцөлд ажил, хөдөлмөр эрхлэх нь ч хүүхдийг үл хайхрахтай холбоотой байх өндөр магадлалтай болохыг дахин өгүүлэх нь зүйтэй байна.

Дээрх хүснэгтэд харуулсан аюултай ажил хийсэн хүүхдүүдийн хариултаас хамгийн нийтлэг дурдагдсан гурван ажлын нөхцөлийг хүүхдийн сэтгэл санаа болон биед нөлөөлөх байдалтай нь харьцуулан судалж доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 14. Халуун наранд эсвэл хүйтэнд гадаа ажилласан нь хүүхдийн сэтгэл санаа, бие бялдарт нөлөөлсөн байдал

Халуун наранд эсвэл хэт хүйтэнд гадаа ажиллаж байсан гэж хариулсан 59 хүүхдийн бие, сэтгэцийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт					
Сэтгэл санаанд үзүүлж буй хор нөлөө	Хүүхдийн тоо	Хувь	Биед үзүүлж буй хор нөлөө	Хүүхдийн тоо	Хувь
Ядрахаас зүрхшээх	25	42	Гүн эсвэл том зүсэгдэх	8	14
Хүнд зүйл өргөх зөөхөөс халшрах	14	24	Толгой, нуруу, хүзүүний гэмтэл	8	14
Даарах, халууцахаас халшрах	12	20	Нүд эсвэл чихээ гэмтээх	5	8
Гэмтэх, бэртэхээс айх	7	12	Биеийн аль нэг хэсгийг алдах	4	7
Цалингаа авч чадахгүй болов уу гэж санаа зовох	7	12	Хөхрөх, хавдах булчин сунах эсвэл мултрах	4	7
Бусад хүүхдүүдээс ичих	6	10	Түлэгдэх	4	7

Гадаа ажилладаг хүүхдүүд ихэвчлэн ядардаг, хүнд зүйл өргөж зөөх болон халууцаж, даарахаас халшрахын зэрэгцээ зүсэгдэх, толгой, нуруу, хүзүүний хэсэг, нүд эсхүл чихээ гэмтээдэг байна.

Хүснэгт 15. Хүнд зүйл өргөх, түлхэх, татах ажил хийсэн нь хүүхдийн сэтгэл санаа, бие бялдарт нөлөөлсөн байдал

Их хүнд зүйл өргөх түлхэх татах (ус түлшний мод нүүрс хог шуудайтай элс шавар зэрэг) гэж хариулсан 50 хүүхдэд орсон өөрчлөлт					
Сэтгэл санаанд үзүүлж буй хор нөлөө	Хүүхдийн тоо	Хувь	Биед үзүүлж буй хор нөлөө	Хүүхдийн тоо	Хувь
Их ядрахаас зүрхшээх	9	18	Хөхрөх, хавдах, булчин сунах эсвэл мултрах	4	8
Хүнд зүйл өргөх зөөхөөс халшрах	7	14	Гүн эсвэл том зүсэгдэх	3	6
Аливаа аюултай зүйлээс айх	4	8	Өндрөөс уналтаас үүдэлтэй гэмтэл	2	4
Бусад хүүхдүүдээс ичих	3	6	Толгой, нуруу, хүзүүний гэмтэл	2	4
Загнуулахаас айх	3	6	Биеийн аль нэг хэсгийг алдах	1	2
Цалингаа авч чадахгүй болов уу гэж санаа зовох	2	4	Жижиг бэртэл хөхрөлт	1	2

Харин хүнд зүйл өргөх, зөөх ажил хийдэг хүүхдүүд ядрах, хүнд зүйл өргөх, зөөхөөсөө халшрах, аюул учрахаас эмээх зэрэг айдастай байдаг бөгөөд хөхрөх, хавдах, булчин сунах, зүсэгдэх болон өндрөөс унаснаас шалтгаалсан бусад гэмтэл авах нь илүү нийтлэг байна.

Хүснэгт 16. Ажилдаа өглөө үүрээр очиж байсан эсвэл орой их харанхуй болтол ажилласан нь хүүхдийн сэтгэл санаа, бие бялдарт нөлөөлсөн байдал

Ажилдаа өглөө үүрээр очиж байсан эсвэл орой их харанхуй болтол ажилласан. (Үүрээр харанхуй байх үед ажилдаа явах ажлаасаа тарах зэрэг) хариулсан 49 хүүхдэд орсон өөрчлөлт					
Сэтгэл санаанд үзүүлж буй хор нөлөө	Хүүхдийн тоо	Хувь	Биед үзүүлж буй хор нөлөө	Хүүхдийн тоо	Хувь
Их ядрахаас зүрхшээх	20	43	Гүн эсвэл том зүсэгдэх	5	11
Загнуулахаас айх	5	11	Түлэгдэх	4	9
Гэмтэх бэртэхээс айх	4	9	Жижиг зүсэгдэх	2	4
Хоол ундгүй өлсөх цангахаас халшрах	4	9	Өндрөөс уналтаас үүдэлтэй гэмтэл	2	4
Цалингаа авч чадахгүй болов уу гэж санаа зовох	4	9	Хөхрөх, хавдах, булчин сунах эсвэл мултрах	2	4

Эрт ажилдаа очдог, хэт оройтож тардаг хүүхдүүдийн хувьд ядрах, загнуулах, гэмтэж бэртэхээс, өлсөхөөс айх айдастай байхын зэрэгцээ зүсэгдэх, түлэгдэх, унаж бэртэх зэргээр гэмтэл, бэртэл авах нь нийтлэг байна.

Ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй 56 эцэг, эх асуулгын асуултад оролцож хүүхдийнхээ биед гарсан өөрчлөлт болон бэртэл гэмтлийн талаар хариулахдаа 14 хувь нь арьс, хумсны бүтцэд, 11 хувь нь аарцаг нурууны яс, үе мөчид, 8 хувь нь хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, элэг цөс, нойр булчирхайд, 6 хувь нь бөөр, шээсний замын үрэвсэл, эмгэг болон хүзүү, тулгуур эрхтэн, булчинд өөрчлөлт орсон гэж хариулжээ.

Эдгээр эцэг, эхчүүд хүүхдийнхээ сэтгэл санаад гарсан өөрчлөлтийн талаар хүүхэд нь санаа бодлоо илэрхийлэхэд илэн далангүй, нээлттэй болсон гэж 40 хувь, өөрчлөлт ороогүй 28 хувь, яаруу адгуу зантай болсон гэж 11 хувь нь тус тус хариулсан бол сөрөг зан чанар илэрсэн нь бага хувь эзэлж байна. Нөгөө талаас хүүхдэд тохирсон ажил, хөдөлмөр эрхлүүлэх нь хүүхдэд биеэ даах, бусадтай харилцах чадамж бий болгох нөхцөл болдог гэж зарим насанд хүрэгчид үзэх тохиолдол байна.

Хүснэгт 17. Ажил хийх нь хүүхдийн сэтгэл санаа, зан харилцаанд хэрхэн нөлөөлснийг эцэг, эхчүүдийн илэрхийлснээр

Д/д	Сэтгэл санаа, зан харилцаанд гарсан өөрчлөлт	Эцэг, эхийн тоо	Хувь
1	Илэн далангүй нээлттэй болсон	23	40
2	Өөрчлөлт ороогүй	16	28
3	Яаруу адгуу зантай болсон	6	11
4	Айдастай цочдог болсон	3	5
5	Зөрүүдлэх дуугүй зантай болсон	3	5
6	Биеэ тоосон бусдын үгийг сонсдоггүй болсон	2	4
7	Ууртай уцаартай эгдүүцэх болсон	2	4
8	Атаархдаг бусдыг үзэн ядсан яриа гаргадаг болсон	1	2
9	Илүү даруухан	1	2

Хэдийгээр эцэг, эх, асран хамгаалагчдын олонх нь хүүхэд ажил, хөдөлмөр эрхэлснээр сэтгэл санаа, зан харилцааны хувьд эерэг өөрчлөлт гарч байгаа гэж хэлсэн бол зөрүүдлэх, бусдын үгийг сонсохгүй байх, уур уцаартай болох зэрэг сөрөг өөрчлөлтүүд гарч байгаа гэж хариулсан нь цөөнгүй байна. Түүнчлэн судалгааны энэхүү хэсгийн хүүхдийн ёс суртахуунд нөлөөлөх ажлын тухай доорх хэсэгт ажил, хөдөлмөр эрхлэх нь хүүхдийн төлөвшил, ёс суртахуунд сөрөг нөлөөлдөг талаар дурдсаныг анхаарах нь зүйтэй юм.

Хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөх ажил

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай ОУХБ-ын 190 дүгээр зөвлөмжийн дагуу эрүүл мэндэд хор нөлөө үзүүлэх гэдгийг дараах байдлаар ойлгох бөгөөд бие бялдарт өөрчлөлт өгөхүйц, сэтгэл зүй дарамтад болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц, аюултай бодис, урвалжтай харьцах, агаарын хэм хэт халуун, хүйтэн, хэт дуу чимээтэй, чичиргээ бүхий нөхцөлд, эсхүл уртасгасан цагаар ажиллахыг ойлгоно. Эдгээрийг ерөнхийд нь хүүхдийн сэтгэл санаанд нөлөөлөх ажил, хүүхдийн бие, бялдарт нөлөөлөх ажил болон хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил гэсэн гурван хэсэгт ангилан авч үзэх боломжтой байна.

Асуулгын судалгаагаар дээрх хэлбэрийг илрүүлэх асуултад 468 хүүхэд оролцсоны 62 хувь нь эрүүл мэндэд хор нөлөөтэй ажлыг, 38 хувь нь аюулгүй байдалд хор нөлөө үзүүлэх ажлыг хийсэн гэж тус тус хариулжээ. Хүүхдийн ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх болон хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажлыг асуулгын судалгаагаар авах нь зохимжгүй гэж үзсэн тул чанарын судалгааны мэдээллээс энэ төрлийн ажлын талаар илрүүлэхээр төлөвлөж дүн шинжилгээ хийсэн болно.

Хүүхдийн сэтгэл санаанд хор нөлөө үзүүлж болох ажил

Ажил, хөдөлмөр эрхлэх нь хүүхдийн сэтгэл санаанд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх зорилгоор тухайн хүүхэд насандаа ажил хийхгүй амьдрахыг хүсдэг эсэхийг асуусан асуултад 468 хүүхэд хариулт өгснөөс 57,4 хувь нь байнга эсвэл заримдаа ажил хийхгүй амьдрахыг хүсэж байсан гэж хариулжээ. Харин хүүхэд насандаа ажил хийхгүй амьдрахыг тогтмол хүсдэг хүүхдүүд 10,9 хувийг эзэлж байсан бол тэдний дунд барилгын ажил, ачаа зөөх зэрэг биеийн хүчний ажил хийдэг хүүхэд 43,1 хувь, бар, ресторан, цайны газар, хүнсний үйлдвэрт олон цагаар болон шөнө оройн цагаар ажилладаг хүүхдүүд 20,8 хувь, хөлсгүйгээр бусдад туслах, айлын хүүхэд асрах зэрэг ажил хийдэг хүүхдүүд 18,1 хувийг тус тус эзэлж байв. Үүнээс үзэхэд биеийн хүчний ажил хийдэг хүүхдүүд ажлаас хамгийн их халширдаг бөгөөд ядрах, хүнд зүйл өргөж зөөх нь илүү хэцүү байдаг ажээ.

Хүүхдүүдээс ажил, хөдөлмөр эрхлэхэд юу нь хамгийн хэцүү вэ? гэж асуухад 45,4 хувь нь их ядрах, 23,1 хувь нь хүнд зүйл өргөж зөөх нь хэцүү гэж хариулсан нь дээрх дүгнэлтийг баталж байна. Мөн хүүхдүүд бар, ресторан, хүнсний үйлдвэр зэрэг газарт ажил, хөдөлмөр эрхэлж байгаа нь харьцангуй их бөгөөд тэдний дунд шөнө ажиллаж байсан хүүхдүүд 47,9 хувийг хүйсийн ойролцоо харьцаатайгаар

эзэлж байв. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад²⁹ хүүхдийг шөнийн цагаар ажиллуулахыг хориглосон бөгөөд ийнхүү бар, ресторан, хүнсний үйлдвэр зэрэг газарт шөнийн цагаар ажиллаж байгаа нь хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлдөг гэж үзэж болохоор байна.

Цаашилбал хүүхэд насандаа ажил хийхгүй амьдрахыг хүсдэг хүүхдүүдийн дунд 7 хоногийн 5 болон түүнээс олон өдөр ажилладаг хүүхдүүд 72,9, 7 өдрийн туршид ажилладаг хүүхдүүд 39,6 хувийг эзэлж байсан бол хэд хэдэн ажил зэрэг хийдэг хүүхдийн эзлэх хувь 29,2 байв. Мөн хүүхэд насандаа ажил, хөдөлмөр эрхлэхгүйгээр амьдрахыг хүсдэг хүүхдүүдийн 68,8 хувь нь зөвхөн зуны улиралд ажил хийсэн, 66,6 хувь нь ямар нэгэн байдлаар шийтгүүлж ажил, хөдөлмөр эрхэлсэн гэжээ.

Түүнчлэн ажил, хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд тулгардаг бэрхшээлүүдийг тодруулахад хариулт өгсөн 441 хүүхдээс 45 хувь нь ядардаг, 23 хувь нь хүнд зүйл өргөх зөөх, 23 хувь нь даарах, халууцах, 19 хувь нь цалингаа авч чадахгүй болов уу гэж санаа зовдог гэж хариулсан бол 10 хувь нь бусад хүүхдүүдээс ичдэг гэж хариулсан байна. Үүнээс үзвэл хүүхдүүд ажил, хөдөлмөр эрхэлж байгаагаасаа ичихээсээ илүүтэй өөрийн биед нь нөлөөлж байгаа хүчин зүйлсээс их бэрхшээдэг, өөрт ахадсан ачаалал авдаг нь тэдний хувьд хүндээр тусдаг байна. Мөн хүүхэд цалингаа авч чадахгүй байхаас айдаг байдал бараг 20 хувь байгаагаас үзэхэд нь ажил олгогчид хүүхдэд цаг тухайд нь, тохиромжтой цалин хөлс өгдөггүй болохыг харуулж байна.

Эдгээрээс үзэхэд ихэвчлэн биеийн хүчний болон гадаа ажилладаг хүүхдүүд ерөнхийдөө ядрахаас зүрхшээх, хүнд зүйл өргөхөөс шантрах, даарах болон халууцахаас бэрхшээх зэрэг сэтгэл санааны айдас, түгшүүртэй байдаг бол бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн хувьд гутралд орох, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх нь хамгийн нийтлэг бөгөөд илүү ноцтой шинжтэй хор нөлөө байна.

Хүүхдийн бие, бялдарт хор нөлөө үзүүлж болох ажил

Хүүхдүүд нүд эсвэл чихээ гэмтээх, цахилгаанд цохиулж бэртэж гэмтсэн нь 6 хувь, хүнд зүйлд цохигдох, хавчуулагдсан, өндрөөс унаж бэртсэн, биеийн аль нэг хэсгээ алдсан тус тус 5 хувь эзэлж байгаа нь аюултай, хүнд хөдөлмөр эрхлэлт хүүхдүүдийн дунд түгээмэл байгаагийн тод илрэл юм.

ТББ-ын ажилтантай хийсэн ярилцлагын үеэр “Өвөл ажиллах нь эрүүл мэндийн асуудал ихтэй. Даарах, хатгаа авах, ханиах гэх мэт асуудал гардаг. Зах дээр ажилладаг хүүхдүүд гар хөлөө гэмтээх явдал байдаг. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн хоол

²⁹ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 88 дугаар зүйлийн 88.6 дахь хэсэгт “Насанд хүрээгүй ажилтныг шөнийн цагаар ажиллуулахыг хориглоно.” гэж заасан.

хүнсний судалгаа хийхэд голдуу маш түргэн хугацаанд тостой хуушуур, ундаа гэх мэтээр аль болох хямдхан хооллодог. Тэр нь ирээдүйд эрүүл мэндийн асуудал үүсгэж болох нөхцөл үүсгэж байгаа юм” гэж хэлсэн.

Хүүхдүүдийн хувьд халуун наранд эсвэл хэт хүйтэнд гадаа ажиллах, их хүнд зүйл өргөх, түлхэх, татах, ажилдаа өглөө үүрээр очиж байсан эсвэл орой их харанхуй болтол ажилласан, дуу чимээ ихтэй орчинд ажилласан болон нэг үйлдлээ олон дахин завсарлагагүй давтаж олон цагаар ажиллаж байсан нь хамгийн нийтлэг байна.

Иймд хогийн цэг зэрэг бусадтай харилцах, холбогдох боломж хязгаарлагдмал нөхцөлд ажилладаг жимс, самар түүх, малчны отроор хүүхэд авч явах, аялал жуулчлалын бааз, үйлдвэрийн газрууд зэрэг бусад ажлын байранд хүүхэд ажиллах, амьдрах нөхцөлийг анхаарч зохицуулах шаардлагатай байна.

Гоо сайхны бүтээгдэхүүн худалдах ажил, хөдөлмөр хийж байсан хүүхэд “Суухыг хориглоно. Өдөржингөө зогсоод, холхиод байхад хөл өвддөг” гэж хэлсэн. Зөвхөн гоо сайхны бүтээгдэхүүн гэлтгүй байнга зогсох нөхцөлтэй хоолны газрын угтах үйлчилгээ зэрэг ажлын байранд хүүхдийн ажиллах цагийг хязгаарлах, хяналт тавих шаардлагатай гэж үзэж байна.

Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил

Судалгааны явцад хүүхдүүд ажлын байрны бэлгийн дарамтад өртөх, биеэ үнэлэхэд уруу татагдах, цаашилбал бэлгийн мөлжлөгт өртөх байдал цөөнгүй илэрсэн. ЦЕГ-ын статистик мэдээллээс³⁰ үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг хуулийн байгууллагаар шийдвэрлэгдсэн нь төдийлөн нийтлэг биш бөгөөд нууц хэлбэрээр оршин байгаа нь ажиглагдсан.

Хүүхдийн аюулгүй байдалд нөлөөлөх ажил

Хүүхдийн аюулгүй байдалд хор нөлөө үзүүлэхүйц нөхцөл гэдгийг “газар дор, усны гүнд болон аюултай өндөрт эсвэл хэтэрхий давчуу орон зайд хийж буй ажил, аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж зэвсэгтэй харьцаж буй ажил, түүнчлэн хүнд ачааг гараараа өргөж зөөх болон тээвэрлэх зэрэг биеийн хүчний ажил, тодорхой хүнд нөхцөлд, тухайлбал уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар, эсвэл ажил олгогчийн ажлын байранд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хашигдан хийж буй ажил” гэж ойлгохоор ОУХБ-ын 190 дүгээр зөвлөмжийн 3 дугаар зүйлд тусгажээ.

Цахим асуулгад оролцсон хүүхдүүд тэдний аюулгүй байдалд нөлөөлөхүйц дээр дурдсан ажил, хөдөлмөр эрхэлж байсан талаараа өгсөн хариултыг дараах хүснэгтэд давтамжаар нь ангилан харууллаа.

³⁰ ЦЕГ-ын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 5/183 дугаар албан бичиг.

Хүснэгт 18. Аюултай нөхцөлд ажилласан хүүхдийн хариулт, давтамжаар

Хүүхдийн ажилласан аюултай нөхцөлүүд	Хариулт-ын давтамж
Гадаа болон байшин дотор шороотой амьсгалахад төвөгтэй, тоосжилт ихтэй, элс, утаа угаартай, харах эсвэл амьсгалахад хүндрэлтэй газар ажиллаж байсан	38
Сүх, хутга, балиус, заазуур гэх мэт хурц иртэй зүйл хэрэглэж байсан	35
Суурь машин, цахилгаан өрөм, хөрөө, гинжтэй суурь хөрөө, цахилгаан зүлгүүр зэрэг цахилгаан багаж хэрэгсэл ашиглаж байсан	26
Галтай эсвэл их халуун зүйлтэй ойр ажиллаж байсан.	19
Барилга, кран дээр, өндөрт самбар тогтоох, шон дээр авирах, байшингийн цонх, фасад цэвэрлэх, машины ачаа бүтээх зэрэг өндөрт авирч ажил хийсэн	17
Тог цахилгаанд өртөж болохуйц ажил, хөдөлмөр эрхэлж байсан	11
Хүнд машин механизмтай ажиллаж эсвэл машин барьж байсан	11
Газраас доошоо гүнд орж агааргүй давчуу нөхцөлд ажил хийсэн	10

Судалгаанд оролцсон 436 хүүхдээс ажил, хөдөлмөр эрхэлж байхдаа бэртэж гэмтэж байсан 242 хүүхэд байна. Эдгээр хүүхдийн бэртлийг авч үзвэл гүн, том хэмжээтэй зүсэгдэх, хөхрөх, хавдах, толгой нурууны гэмтэл, түлэгдэх байдлаар гэмтэж бэртэх нь их гэжээ.

Нэгэн аймгийн сургуулийн нийгмийн ажилтан “Манай аймагтай ойр байрладаг нэг тоосгоны үйлдвэрт хувийн ажлаар очиход 13-тай охид ажиллаж байсан. Шөнө хоноод үүрийн 3, 4 цаг хүртэл ажилладаг гэж тэдгээр хүүхдүүд хэлжээ. Манай сургуулийн хүүхдүүд байгаагүй. Танихын аргагүй болчихдог юм билээ. Цалин нь сая төгрөг шахуу авдаг гэсэн. Тэндээ хонож байрладаг, зуны халуунд халуун гал дотор байдаг юм билээ. Өвөл бас ажилладаг байх” гэж хэлсэн.

Харин хогийг цэг дээр ажилладаг 14 настай хүүтэй хийсэн ярилцлагаар “Овоолсон хог дээр өглөө 10 юм уу 11 цагт гараад орой гэгээ тасрахаар буудаг. Хог дээр ажиллахад эхлээд муухай үнэртдэг байсан боловч одоо үнэрт дассан. Хогийн машин дээр гарч байгаад хөргөгч буулгаж байсан нь хамгийн хүнд зүйл байсан” гэсэн бол дугуй хийлэх, засах ажил хийдэг хүүхэд “том дугуйнд даруулсан”, машин угаалгад ажиллаж байсан хүүхэд “Машин угаалгад ажиллаж байгаа хүүхдүүдийн бөөр их өвддөг болдог юм байна. Мэдээж хүнд юм өргөж, зөөхөд нуруу өвддөг” хэмээн ажлын аюултай нөхцөлийн талаар хариулжээ.

Хүүхдийн ёс суртахуунд нөлөөлөх ажил

Ёс суртахуун нь бусадтай харилцаж байгаа зан үйлийн харилцаагаар тодорхойлогдох бөгөөд хөгжлийн явцад ёс суртахууны зарчим, хэм хэмжээ үүсэж нийгмийн ухамсрын тодорхой хэлбэр болдог. Ёс суртахуун нь сайн, муу болон шударга, шударга бус, нэр төр, гутамшиг болох зэрэг амьдралын үйл явцын зөв, бурууг ялган таних хандлагыг тогтоосон шинжтэй хэм хэмжээ билээ. Энэ нь биеийн хэлэмж, хэл яриа, сэтгэл оюуны үйлээр илрэх бөгөөд зөв үйл хийхийг хичээх, муу зүйлийг жигшин цээрлэх, сайн үйлийг хөгжүүлэх зэрэг шаардлагыг нийгэмд бий болгодог байна.

Хүүхдийн ёс суртахуун нь бусдыг дагаж дуурайх замаар хөгждөг онцлогтой. Тухайлбал хүүхдийн анхдагч ёс суртахууны хэм хэмжээ нь гэр бүл дэх зан, харилцааны хэм хэмжээ, хэвшмэл ойлголтуудаас шууд хамааралтай. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүүхэд мөн л бусдын хийж байгаа үйлдэл, хоорондоо харилцах зан харилцаа хэвшин, тогтсон ёс суртахуун, үйл ажиллагааг шууд сурч хэрэгжүүлж эхэлдэг. Иймд тухайн хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн орчин нь хүүхдийн ёс суртахуунд сайн болон муу аль аль талаараа маш хүчтэй нөлөөлдөг байна.

Ажил, хөдөлмөр эрхэлснээр хүүхдийн ёс суртахуунд эерэг өөрчлөлт ордог гэж зарим судалгаанд оролцогчид үзэж байна. Энэ талаар “Ажил, хөдөлмөр эрхэлснээр харилцаа хандлага, ёс зүйн хувьд муу тал гэхээсээ илүүтэйгээр нийгмийн харилцаанд орсон гэдэг утгаараа сайн өөрчлөлтүүд харагддаг. Тухайлбал багшдаа өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах тал дээр нээлттэй болсон байдаг” гэж Насан туршийн боловсролын байгууллагын ажилтан илэрхийлсэн байна. Мөн хүүхдийн хөдөлмөрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТТБ-ын ажилтан “Ажил хийдэг хүүхдүүдийн дунд архины асуудал харьцангуй бага байдаг. Тэд ар гэрийнхээ амьдралыг авч явдаг гэдэг утгаараа архи уух бодолгүй байдаг. Өөрөө зовж олдог учраас архинд мөнгө зарахгүй” гэж хэлсэн.

Нөгөөтэйгүүр хүүхэд ажил, хөдөлмөр эрхлэхдээ худал хэлэх, хараалын үг хэлэх, архи, тамхи хэрэглэх, цаашилбал мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх, гэмт хэрэг болон зөрчилд холбогдох зэрэг байдал илэрсэн. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцод хүүхдийн ёс суртахуунд хор нөлөө үзүүлж болох ажлыг хүүхдээр хийлгэхгүй байхаар заасан байдаг.

Конвенцод заасан ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь ёс суртахуунд хор нөлөө үзүүлж болох ажил, хөдөлмөр эрхэлснээс үүдэлтэй хүүхдэд үүсэж байгаа

ёс суртахууны сөрөг үр дагавруудаас ялгаж үзэх нь чухал байна. Тухайлбал ажил, хөдөлмөр эрхэлснээр хүүхдэд гарах өөрчлөлтийн талаар нэгэн аймгийн ГБХЗХГ-ын ажилтан “Яах вэ, биеэ эрт даагаад сайн талтай гэж харж л байгаа юм. Гэхдээ тэдэнд эрсдэл өндөр байдаг. Гэмт хэрэгт холбогдох, газ үнэрлэх, тамхи татах эрсдэлтэй” гэж хэлсэн бол өөр нэгэн аймгийн ГБХЗХГ-ын ажилтан “Насанд хүрэгчдийн дунд ороод ирэхээрээ өөрийгөө том болчихсон, арай дээгүүр үнэлэх, том хүмүүсээс зан байдлын хувьд сайныг нь биш мууг нь сурах ч гэдэг юм уу тиймэрхүү өөрчлөлтүүд ажиглагддаг” гэж хэлэв. Эдгээр нь тодорхой ажлын байр, ажлын нөхцөлтэй холбогдоогүй тул конвенцод заасан зохицуулалттай шууд холбон дүгнэх боломжгүй ч хүүхдээр ажил хийлгэх нь сайн талтай гэж үзэхэд шүүмжлэлтэй хандах хэрэгтэй бөгөөд хөдөлмөрийн харилцаанд хүүхдийн ёс суртахууныг доройтуулахаас урьдчилан сэргийлэх зохицуулалт шаардлагатайг илэрхийлж байгаа гэж үзэж байна.

Үүний зэрэгцээ ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд ажлын орчноос бус өөрийн гэр бүлийн гишүүдээс суралцан архи уух, тамхи татах зэрэг муу зуршилтай болсон, зан харилцааны алдаа, дутагдалтай болсон асуудлыг тухайн хүүхдийн эрхэлж байгаа ажил, хөдөлмөр түүнийг гүйцэтгэх нөхцөлтэй холбон үзэх нь буруу юм.

Харин тодорхой ажлын байр, ажиллах нөхцөлтэй холбоотойгоор ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болох нөхцөл байдлын талаар дурдвал:

- Нэгэн аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч “Ээж, аав нь цайны газар, бар, ресторан ажиллуулдаг айлын хүүхдүүд архи согтууруулах ундаа худалдан борлуулж л байгаа” гэж хэлсэн бол өөр аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч “Дэлгүүрт ажиллах нь 18 нас, худалдах нь 21 нас байгаа. Дэлгүүртэй айлын хүүхдүүд өөрсдөө архи, пиво хэрэглэх гээд байдаг талтай. Аав, ээжийнхээ эзгүйд архи, пиво, тамхинаас нь авч гараад найзтайгаа уух, тамхи татах шинж ажиглагдсан” гэжээ. Хогийн цэг дээр ажилладаг хүүхэд энэ талаар дурдахдаа “Газны үлдэгдэл хэрэглэдэг хүүхдүүд байгаа. Би бараг тэдэнтэй нийлдэггүй. Аав, ээж хоёр уурладаг” гэжээ.
- МСҮТ-д сурдаг хүүхэдтэй эцэг, эхийн төлөөлөл хэлэхдээ “Хүүхдийг дадлагаар ажиллуулж байгаа хүмүүс нь хүүхдүүдтэй п... гэх мэтээр хэлэх хэлэхгүйгээр харааж загнадаг. Хариуцсан багшид нь хэлэхээр хүүхдүүд ажил, хөдөлмөр эрхэлж харилцаа сурах ёстой гэдэг. Тэднээс хүүхэд харилцаа сурах юм уу? Ер нь одоо үүнийг байгууллагын түвшинд, холбогдох байгууллагуудад хандъя гэж бодож байгаа. Дээр нь багш нар үе тэнгийн хүүхдүүдийг хүчирхийлдэг. Магадгүй эмэгтэй хүүхдийг оролддог асуудал хүртэл байгаа байх” гэсэн байна.

Үндсэндээ ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн архи, тамхины хэрэглээ, ёс суртахууны доройтолд автах нь нийтлэг асуудал биш гэж үзэж болох бөгөөд ёс суртахуунд нөлөөлөхүйц ажил хийдэг хүүхдүүд ихэвчлэн хурдан морь унаач, архи, тамхи худалдан борлуулдаг дэлгүүр, бар ресторанд ажилладаг хүүхдүүд болон бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэлтэд өртсөн хүүхдүүд байдаг гэж үзэж болохоор байна.

3.3 Хүүхэд гэрийн ажил болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүйгээр оролцож байгаа байдал

Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хэлбэрээр нь ангилан үзвэл 1,441 хүүхэд цалин хөлстэй, 2,333 хүүхэд хувиараа, 61,954 хүүхэд хөдөө аж ахуйн салбарт, 27,948 хүүхэд өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй ажил, хөдөлмөр эрхэлж байжээ.³¹

Хүүхдийн цалин хөлсгүй хийж байгаа ажил, хөдөлмөр эрхлэлтийг ерөнхийд нь гэрийн ажил хийх болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүйгээр оролцох гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваан үзэж болно. Статистикийн салбарт гэрийн ажил нь эдийн засгийн бус үйл ажиллагаанд тооцогдох бол өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь эдийн засгийн үйл ажиллагаанд хамаардаг байна. Хүүхдийн зарцуулж байгаа цаг хугацаанаас хамааран энэхүү хоёр төрлийн үйл ажиллагаа нь хүүхэд хийхийг зөвшөөрч болох ажил эсвэл хүүхдээр хийлгэхээс хориглох хөдөлмөрийн хэлбэрийг агуулдаг байна.

Хүүхдийн хөлсгүй ажлын талаар НҮБХС, ОУХБ-ын аль аль нь тусдаа судалгаа, шинжилгээний ажлыг хийсээр ирсэн бөгөөд 2013 онд дээрх байгууллагууд хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох цаг болон хүүхэд цалин хөлсгүйгээр гэрийн ажилд оролцох цагийн хязгаарыг хамтран тогтоож, 2013 онд Женев хотод зохион байгуулагдсан хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19 дүгээр хуралдаанд дараах зөвлөмжийг танилцуулснаар 2020 онд хүүхдийн хөдөлмөрийн судалгааг хийх аргачлалд дараах өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- 5-11 насны хүүхдэд: Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хугацаа 7 хоногт 1 цаг, гэр орны ажилд оролцох хугацаа 7 хоногт 21 цаг байх;
- 12-14 насны хүүхдэд: Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хугацаа 7 хоногт 14 цаг, цалин хөлсгүй гэр орны ажилд оролцох хугацаа 7 хоногт 21 цаг байх;
- 15-17 насны хүүхдэд: Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хугацаа 7 хоногт 43 цаг, цалин хөлсгүй гэр орны ажилд оролцох хугацааны хязгаар заахгүй байхаар тогтоосон байна.

³¹ ҮСХ, ОУХБ, “Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2011-2012”, УБ, 2013 он, 23-24 дүгээр тал.

Энэхүү цагийн хязгаараас давсан тохиолдолд хүүхдээр ажил, хөдөлмөр эрхлүүлж байгаа гэж үзэх үндэслэлтэй бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд энэ талаар таниулан сурталчилж, хүүхдэд сурч боловсрох, хөгжих боломжийг олгох нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад нэн тэргүүний ач холбогдолтой гэдгийг ойлгуулах нь чухал юм.

3.3.1 Гэрийн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн нөхцөл байдал

Хүүхдийн гэрийн цалин хөлсгүй үйл ажиллагаанд өөрийн гэртээ өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олохгүй нөхцөл байдлыг хамруулан ойлгоно. Үүнд:³²

- Гэр орон цэвэрлэх, хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах;
- Хувцас угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засах;
- Хоол цай бэлтгэх, аяга таваг угаах;
- Хүүхэд асрах;
- Өндөр настан, өвчтөн асрах;
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах гэх мэт.


Хүснэгт 19. Хүүхдийн гэрийн ажилд зарцуулдаг цаг хугацаа, нас, хүйсээр

Өдөрт гэрийн ажил хийдэг цаг	3 хүртэл цаг	3-4 цаг	5-6 цаг	7-8 цаг	9 ба түүнээс дээш цаг	Хүүхдийн тоо
7 хоногт гэрийн ажил хийдэг цаг	21 цаг хүртэл	21-28 цаг	29-42 цаг	49-56 цаг	57-оос дээш цаг	
Өдөр болгон гэрийн ажил хийдэг хүүхэд хувиар	59	28	9	3	1	672
5-11 нас	76	19	2	0	2	42
Эмэгтэй	76	18	3	0	3	33
Эрэгтэй	78	22	0	0	0	9
12-14 нас	62	26	8	3	1	197
Эмэгтэй	57	31	8	3	1	143
Эрэгтэй	76	15	7	2	0	54
15-17 нас	56	29	11	3	1	433
Эмэгтэй	54	30	11	4	1	317
Эрэгтэй	60	26	11	1	2	116

³² ҮСХ, ОУХБ, “Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2011-2012”, УБ, 2013 он, 23-24 дүгээр тал.

Цахим асуулгын үр дүнгээс үзвэл гэрийн ажилд зарцуулдаг хугацааны талаар мэдээлэл өгсөн нийт 1,217 хүүхдийн 79,2 хувь нь 6-8 насандаа гэрийн ажил, хөдөлмөр эрхэлж эхэлдэг бол 16,8 хувь нь 12 болон түүнээс дээш насандаа, 4 орчим хувь нь 3-5 насандаа гэрийн ажил, хөдөлмөр эрхэлж эхэлдэг байна. Харин эдгээр хүүхдийн 55,6 хувь нь өдөр бүр гэрийн ажил хийдэг бол 41,4 хувь нь заримдаа, 3 орчим хувь нь огт хийдэггүй гэж хариулсан байна.

Хүснэгт 20. Хүүхдийн гэрийн ажилд зарцуулдаг цагийг гэрийн ажил хийдэг давтамжтай нь харьцуулсан үзүүлэлт



Гэрийн ажилд хоногт 7-8 цаг зарцуулдаг хүүхдийн 90 хувь нь, гэрийн ажилд 9 цаг зарцуулдаг хүүхдийн 80 хувь нь голчлон ЕБС-д сурдаг 15-17 насны эмэгтэй хүүхэд байна. Харин ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд ихэвчлэн 4 хүртэл цагийг гэрийн ажилд зарцуулдаг бол эдгээр хүүхдийн дунд ажил, хөдөлмөр хийсний улмаас сургуульд сурахад хэцүү байдаг, дүүгээ эсвэл өндөр настай хүн хардаг учир хичээл хийх хэцүү байдаг гэж хариулсан хүүхэд харьцангуй олон байв.

3.3.2 Хүүхэд гэр бүлийнхээ өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцож байгаа байдал

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчийг “Мал аж ахуйгаас бусад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцон, хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэн”³³ гэж тодорхойлсон байна.

³³ ҮСХ, ОУХБ, “Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2011-2012”, УБ, 2013 он, 24 дүгээр тал.

Судалгааны өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд хөлсгүй оролцдог эсэх тухай асуултад хариулсан 1,145 хүүхдүүдийн 26,4 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ямар нэгэн байдлаар хөлсгүй оролцдог, үлдсэн 73,6 хувь нь оролцдоггүй гэж хариулсан. Эдгээр хүүхдүүдийн 16,2 хувь нь тогтмол шинжтэй, 10,2 хувь нь заримдаа оролцдог байна.

Зураг 3. Хүүхэд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд хөлсгүй оролцож буй нөхцөл байдал, хувиар



Өөрийн гэр бүлийн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй тогтмол оролцдог гэж хариулсан 1,145 хүүхдийн 65,2 хувь нь заримдаа оролцдог, 67,5 хувь нь 15-17 насны хүүхдүүд байгаа бол тогтмол оролцдог хүүхдүүдийн 26,9 хувь, заримдаа оролцдог хүүхдүүдийн 27,4 хувь нь 12-14 насныхан, харин өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцдог нийт хүүхдийн 6,5 хувь нь 5-11 насны хүүхдүүд байна.


Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд аймгийн хүүхдүүдийн нийтлэг хийдэг ажил, хөдөлмөрийн 26 хувь нь хүнс, барааны дэлгүүрт худалдагч хийх, 14 хувь нь гоёл чимэглэл зэрэг гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд, 9,6 хувь нь хувцас завсар, оёдлын ажилд, 6,5 хувь нь хүнс үйлдвэрлэлд, 4 хувь нь гэрийн бүрээс цаваг оёх ажилд, 3,7 хувь нь модон эдлэлийн үйлдвэрлэлд, үлдсэн 36 орчим хувь нь ногоо тарьж хураах, төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн зарах, бараа зөөх, хүргэх болон сүлжээний бизнесийн ажилд оролцдог байна.

Эдгээр хүүхдийг насны бүлгээр нь ангилж үзвэл 5-11 насны хүүхдүүдийн хувьд дэлгүүрт худалдагч хийх нь 29,4 хувь, монгол гэрийн бүрээс, цаваг оёх нь 16,7 хувь, гар урлал, гоёл чимэглэлийн зүйл хийх нь 15,8 хувь, хүнс үйлдвэрлэлд оролцох нь 15,1 хувь байна. Харин 12-14 насны хүүхдүүдээс дэлгүүрт худалдагч хийдэг 41,4 хувь, гар урлал, гоёл чимэглэлийн зүйлс хийдэг 17,2 хувь, модон эдлэл, хувцас засвар, оёдол,

хүнсний үйлдвэрлэл тус бүр 7 орчим хувь байсан бол 15-17 насны хүүхдүүдийн хувьд хүнс, барааны худалдагч хийх 49 хувь, гар урлал, гоёл чимэглэлийн зүйлс хийх 13,8 хувь, хувцас засвар оёдол 13,1 хувь, хүнсний үйлдвэрлэлд оролцох 7,6 хувь, монгол гэрийн бүрээс цаваг оёх 6,2 хувь байгаа нь хамгийн нийтлэг шинжтэй байна. Үүнээс үзэхэд 5-11 насны хүүхэд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцох нь цөөн бөгөөд 12-14 болон 15-17 насны хүүхдүүдийн хувьд хүнс, барааны дэлгүүрт худалдагч хийх нь илүү нийтлэг байгаа зүй тогтол ажиглагдлаа.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд өдөрт 5-6 цаг зарцуулдаг хүүхдүүдийн 70 хувь нь 15-17 насны, 27,3 хувь нь 12-14 насны, үлдсэн 2,3 хувь нь 5-11 насны хүүхэд байна. Мөн 7-8 цаг зарцуулдаг хүүхдүүдийн 71,5 хувь нь 15-17 насны, үлдсэн 28,5 хувь нь 12-14 насны хүүхэд байгаа бол бага насны буюу 5-11 насны хүүхэд байхгүй байна. 9 болон түүнээс дээш ажилладаг хүүхдүүдийн 71,4 хувь нь 15-17 насны, 12-14 болон 5-11 насны хүүхдүүд 14,3 хувь тус тус байна.

Зураг 4. Өрхийн үйлдвэрлэлд хүүхдийн өдөрт зарцуулдаг цаг, насны бүлгээр



Өрхийн үйлдвэрлэлд 15-17 насны хүүхдүүд хамгийн олон цагаар, хамгийн их оролцож байгаа бол 12-14 насны бүлгийнхэн дундаж хэмжээнд, дундаж цагаар, харин 5-11 насныхан хамгийн бага хувиар, цөөн цаг оролцож байгаа нь ажиглагдлаа. Гэвч 9 болон түүнээс дээш цаг ажилладаг 5-11 насны хүүхдүүд харьцангуй их байгаа нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамаарч байна.

3.4 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа хүүхдийн нөхцөл байдал

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 142 дугаар зүйлийн 142.7 дахь хэсэгт “Ажил олгогч энэ хуульд заасны дагуу 15-18 хүртэлх насны

хүнээр хөдөлмөр эрхлүүлэх бол хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) болон тухайн насанд хүрээгүй хүнтэй гуравласан хөдөлмөрийн гэрээ байгуулна” гэж заасан.

Үүний дагуу техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллага, мэргэжлийн чиг баримжаа олгодог сургалтын төвүүдэд суралцаж байх хугацаандаа цалинтай дадлага хийсэн, төгсөөд албан ёсоор хөдөлмөрийн санд бүртгэгдэж ажилд зуучлагдах үйл ажиллагаа нь хуулийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн үндсэн мэдээлэл болж байна.

Хүснэгт 21. Хөдөлмөр, халамжийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн, ажилд зуучлагдсан, шинээр ажлын байранд орсон 15-17 насны иргэдийн тоо, оноор

Д/д	Нас/он	2018 он	2019 он	2020 он
Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн 15-17 насны иргэдийн тоо, оноор				
1	15 нас	183	247	274
2	16 нас	569	579	338
3	17 нас	1,010	1,057	598
Нийт		1,762	1,883	1,210
Ажилд зуучлагдсан 15-17 насны иргэдийн тоо, оноор				
1	15 нас	16	16	13
2	16 нас	87	88	83
3	17 нас	358	324	238
Нийт		461	428	334
Шинээр ажилд орсон 15-17 насны иргэдийн тоо, оноор				
1	15 нас	10	1	13
2	16 нас	36	28	45
3	17 нас	117	108	137
Нийт		163	137	195

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сан

Дээрх хүснэгтээс үзэхэд 15-17 насны иргэд нас нэмэгдэх тусам ажил хайж бүртгүүлэх, ажилд зуучлагдах, шинээр ажлын байранд орох нь нэмэгдэж байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн даатгалд даатгуулна”, 32 дугаар

зүйлийн 1.2 дахь хэсэгт “Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор, Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс”-д НДШ ногдуулна гэж тус тус зааснаас үзэхэд эдгээр 3 гэрээний төрлөөс үл хамааран гэрээний дагуу хөдөлмөрийн харилцаа үүссэн тохиолдолд НДШ төлөх үүрэг үүснэ.

Судалгаанд оролцсон ажил, хөдөлмөр эрхэлдэг 474 хүүхдийн 67 хувь нь аман тохиролцоогоор ажил, хөдөлмөр эрхэлсэн гэж хариулснаас үзэхэд цалин авахуйц буюу эдийн засгийн үр дүнтэй ажлыг гэрээ байгуулахгүй хийсэн тохиолдол маш нийтлэг байх бөгөөд үүнээс шалтгаалан цалин хөлсөө авч чадахгүй, нийгмийн даатгалд хамрагдах боломжгүй байсныг Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгаар хамгаалалт бүхий заалтыг тусгасан.

Ярилцлагын үеэр нэгэн ажил олгогч “Манайх хүүхдийн цалин хөлсийг олгохдоо шууд бэлэн мөнгөөр нь олгодог, эцэг эхтэй нь гэрээ хийх гэхээсээ илүүтэй утсаар яриад зөвшөөрлийг нь авах, эсхүл өргөдөл маягийн зүйл гараар нь бичүүлээд гарын үсэг зуруулдаг. Ер нь хүмүүс нарийн гэрээ хийгээд авч байгаа цалин, хөлснөөсөө НДШ-ийн 11,5 хувь суутгал авах гэхээр дургүй байдаг” гэснээс үзвэл хуульд заасны дагуу хүүхэдтэй албан ёсны гэрээ хийдэггүй, гэрээний дагуу ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг хангадаггүй, ажилтнууд дургүй байгаа гэдэг үгээр хаацайлан өөрийн байгууллагаас төлөх 12,5 хувийн шимтгэлээс зугтаах байдлаар хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, хохироох тохиолдол гарч байна.

Цаашид хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийг илрүүлэх, бүртгэх, нээлттэй болгох ажил маш чухал, хүүхдийн асуудал хариуцсан салбар салбарын мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөмж өгөх, мэргэшүүлэх, хүүхдийн хөдөлмөрийн талаар зөв ойлголт мэдлэг олгох, зөвшөөрөгдөх, зөвшөөрөгдөхгүй шинжүүдийг ялгаж таних чадварт сургах, хөдөлмөр, нийгмийн гурван талт зөвшлийн хүрээнд насанд хүрээгүй хүний ажил, хөдөлмөр эрхлэлтийн асуудалд тусгайлан анхаарах шаардлагатай байна.

БҮЛЭГ 4.

ХУРДАН МОРЬ УНААЧ
ХҮҮХДИЙН ӨНӨӨГИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДАЛ



Хурдан морины уралдаан нь Монголын ард түмний төрт ёсны өв соёлын үнэт баяр цэнгээн байх уламжлалт хэв маягаасаа илүү өргөн цар хүрээтэй болж, зөвхөн зун³⁴ биш жилийн дөрвөн улиралд үсэргээ, сунгаа хийж, зарим тохиолдолд далд хэлбэрээр бооцоот уралдаанууд зохиож бизнесийн болон бооцоот спортын төрөлд илүү ойртож хэв шинж, арга барилын хувьд өөрчлөгдсөөр ирлээ. Хурдан морины уралдаан нь унаач хүүхдийн эрх, аюулгүй байдлыг орхигдуулж амь нас, эрүүл мэндэд нь аюултай нөхцөл байдлыг бий болгодог нь олны шүүмжлэлд өртөх болсон.

Хурдан морь унаач хүүхдүүдтэй хийсэн ярилцлагаар хүүхдүүд эрх зүйн болон эцэг, эх, асран хамгаалагчийн ямар нэгэн хамгаалалтгүй унаач болж байгаа тохиолдол цөөнгүй байна. Зарим тохиолдолд тэдгээр хүүхдүүд бие махбод, сэтгэл санаа, ёс суртахууны хүчирхийлэлтэй нөхцөлд ажил, хөдөлмөр эрхэлж, ажлын хөлсөө зөвхөн эцэг, эх, ар гэртээ зориулж, өрийн төлөөсөнд орж байна. Үүнээс гадна аймаг, бүсийн хооронд танихгүй айлд, удаан хугацаагаар морины ажил хийх, морь унах нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байгаа нь ажиглагдлаа.

4.1 Хурдан морины уралдаан ба унаач хүүхдийн эрхийн талаарх эрх зүйн дүн шинжилгээ

ОУХБ-ын Конвенц, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хянах шинжээчдийн хорооноос 182 дугаар конвенцын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн шууд хүсэлтийн заалт (г)-д “уралдааны морь унах нь утгаараа өөрөө аюултай буюу осолтой нөхцөлд тооцогдох ба хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд гэмтэл учруулах магадлалтай тул 18 наснаас доош насны хүүхдийг морь унахыг үргэлжлүүлэн зөвшөөрч байгаад эмзэглэн санаа зовж байгаагаа” илэрхийлсэн байна. Түүнчлэн Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тавдугаар тайланг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос 2017 онд хурдан морь унаач хүүхдийн талаар тусгайлан “... Хурдан морины уралдаанд оролцож байгаад хүндээр гэмтсэн, амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг мөрдөн шалгаж буруутай этгээдэд хариуцлага ногдуулах, хурдан морины уралдаан гэх мэт аюултай, хортой хүүхдийн хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг бизнес эрхэлж буй төрийн алба хаагчдын хувийн болон албаны ашиг сонирхлын зөрчил гаргаж буй үйлдэлд арга хэмжээ авах, ийм үйлдэл гаргуулахгүй байхад чиглэсэн хээл хахуулийн эсрэг арга хэмжээнүүдийг авах”³⁵ гэж дурдсан байна.

³⁴ <https://mlsp.gov.mn/uploads/files/a79cb10e766cab0a8cc567e0c7c00cc186c571fc.pdf>

³⁵ <http://www.monef.mn/index.php?con=legal&id=45>

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”, мөн зүйлийн 1 дэх заалтад “амьд явах эрхтэй...”, мөн зүйлийн 7 дахь заалтад “сурч боловсрох эрхтэй”, мөн зүйлийн 11 дэх заалтад “...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж зааснаар хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахаар байна. Нөгөөтэйгүүр үндэсний их баяр наадам, соёлоо өвлөн тээж, хойч үедээ үлдээх үүргийг хууль тогтоомжоор зохицуулсан. Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу Үндэсний их баяр наадам нь үндэсний уламжлалт их баяр бөгөөд төрийн хамгаалалтад байхаар байна. Эдгээрээс шалтгаалан унаач хүүхдийн нас³⁶ нь нэг талаас хүний эрх, хууль тогтоомжийн нөгөө талаасаа үндэсний соёл, өв уламжлалын уулзах зөрчилдөөнт цэгт маргаантай байна.

Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрмийн 3.1-д “Уяач, унаач хүүхэд нь Үндэсний их баяр наадмын тухай хууль болон энэ дүрэмд заасан эрхийг эдэлж, доорх үүргийг ёсчлон биелүүлнэ”. Мөн дүрмийн 3.1.1-д “уралдах морийг 7-гоос дээш настай, морь унаж, давхиулж сурсан, эрүүл хүүхдээр унуулах” гэж зохицуулсан байна.

Хүүхдээр хэзээ, ямар хугацаанд, ямар давтамжтайгаар хурдан морь унуулах, хэрхэн эрүүл мэндийг нь хамгаалах, эдгээрт хяналт тавих эрх бүхий этгээдүүдийг тодорхойлох, улмаар хууль тогтоомж зөрчсөн этгээд ямар хариуцлага хүлээх асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. ОУХБ-ын зөвлөмжид насанд хүрээгүй хүнээр хурдан морь унуулж уралдуулахгүй байх зөвлөмжийг өгсөн.

Зөрчлийн тухай болон Үндэсний их баяр наадмын тухай хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын заалт оруулж өгөөгүй бөгөөд тус хуулийн 6.20 дугаар зүйл³⁷-ийн дагуу хувь хүн буюу зөвхөн уяачийг 100,000 (нэг зуун мянган) төгрөгөөр, хуулийн этгээдийг 1,000,000 (нэг сая) төгрөгөөр торгохоор, харин төрийн албан тушаалтны шийдвэрийг биелүүлээгүй гэж үзвэл тус хуулийн 15.2 дугаар зүйл³⁸ - ийн дагуу торгох шийтгэл оноохоор заажээ.

Эрүүгийн хуулийн Тусгай ангид хүүхдийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирвал эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, албан тушаалтнуудад хариуцлага

³⁶ Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Баяр наадмын хурдан морийг 7-гоос дээш насны хүүхэд унах бөгөөд ослын даатгалд даатгуулсан байна.” гэж заасан байна.

³⁷ Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл “Хүүхдийн эрх зөрчих”.

³⁸ Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйл “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах”.

хүлээлгэх тухай заагаагүйн улмаас эрүүгийн хуулиар хамгаалах ёстой чухал объектыг орхигдуулжээ.³⁹

Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн орчныг бий болгох, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр “Хурдан морины өвөл, хаврын уралдаанд 16-аас доош насны хүүхэд оролцохыг хориглох, зөвшөөрөгдсөн уралдааны үед хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах асуудлыг хуульчлах” зорилтыг дэвшүүлсэн байна. Мөн Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглож, хүний эрх нь хүн бүрийн эдлэх түгээмэл эрхийн ойлголт бөгөөд Монгол Улс төдийгүй дэлхийн бүх хүүхдэд ч хамаарах асуудал тул эдгээр эрх зүйн шинэчлэлтийг судлан шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

4.2 Хурдан морь унаач хүүхдийн статистик мэдээлэл

Өмнө хийгдсэн судалгаанаас үзэхэд “2015 оны байдлаар жилд давхардсан тоогоор 40,000 орчим хүүхэд хурдан морь унадаг. Хурдан морины уралдаанч хүүхдүүдийн ихэнх нь бага насны буюу 7-10 насны хүүхдүүд байгаа нь хүүхдүүд өөрийгөө эрсдэлээс хамгаалах, гэнэтийн аюултай нөхцөл байдлыг даван туулах чадвар сул, бие бялдар, оюун ухааны хувьд төлөвших болоогүй байдагтай шууд холбоотой хэмээн үзэж болохоор байна”⁴⁰ гэжээ. ГБХЗХГ-ын “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн сан”-гийн “Хурдан морины уралдааны мэдээллийн дэд сан”-гийн мэдээнээс харахад Монгол Улсын хэмжээнд хурдан морь унаач 15,885 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 15,403 эрэгтэй, 482 эмэгтэй хүүхэд байна.⁴¹ Энэ нь нийт хурдан морь унаач хүүхдийн 96 хувь нь эрэгтэй, 4 хувь нь эмэгтэй хүүхэд эзэлж байна. Харин насны ангиллаар авч үзвэл 7-9 насны 5,308, 10-12 насны 6,971, 13-15 насны 2,743, 16-18 насны 323 хүүхэд байх бөгөөд 14,082 хүүхэд орон нутгийн, 1,797 хүүхэд Улаанбаатар хотын харьяалалтай байна.⁴²

³⁹ МХХ-ны Хүүхдийн эрхийн дэд хорооны мэдээллийн “Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал”-ын хэсгээс.

⁴⁰ ХЭҮК, Эрх зүйн судалгааны төв, ОУХБ, НҮБХС, “Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх судалгааны тайлан”, 2015 он, 17 дугаар хуудас.

⁴¹ ГБХЗХГ-ын “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн сан”-гийн “Хурдан морины уралдааны мэдээллийн сан”, 2021 он.

⁴² Committee on the Rights of the Child. 2017. Concluding observations on the fifth periodic report of Mongolia.

Мэргэжлийн хяналтын байгууллагын мэдээлэлд 2020 оны байдлаар 17,450 хүүхэд хурдан морь унаж уралдсанаас 7-оос доош насны хүүхэд морь унаагүй байна.⁴³ Харамсалтай нь унаач хүүхдүүдийн дийлэнхийг буюу 80,64 хувийг өөрийгөө эрсдэлээс хамгаалах, гэнэтийн аюултай нөхцөл байдлыг даван туулах чадвар сул, бие бялдар, оюун ухааны хувьд бүрэн төлөвшөөгүй 12 хүртэлх насны хүүхэд эзэлдэг хэвээр байна.

Өвлийн уралдааны талаар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/36 дугаар тушаалаар шинэчлэн баталснаар 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосонтой холбоотойгоор хүйтний улиралд аливаа уралдаан зохион байгуулагдаагүй гэх боловч хүүхдүүд, уяачидтай хийсэн ярилцлагаар жилийн дөрвөн улиралд үсэргээ, сунгаа, тодорхой хэмжээний бооцоот уралдаан хийгдсээр байгааг баталж өглөө.

МХХ-ны Хүүхдийн эрхийн дэд хорооны мэдээлэл дэх ГССҮТ-ийн статистик мэдээллээс үзэхэд 2019-2020 оны 1-4 болон 9-12 дугаар саруудад мориноос унаж гэмтсэн хүүхдийн тоо сард дунджаар 34.6 байсан бол ижил онуудын 5-10 дугаар сарын хооронд мориноос унаж бэртэж гэмтсэн хүүхдийн тоо дунджаар 1,282 байжээ. Хүүхдээр хурдны морь унуулахыг хориглосон саруудад мориноос унаж бэртсэн хүүхдийн тоо ийнхүү унуулахыг хориглоогүй саруудын мөн үзүүлэлтээс дунджаар 3,7 дахин бага байгаа нь харагдаж байна. Түүнчлэн 2019, 2020 онуудад мориноос унаж бэртэж гэмтсэн хүүхдийн тооноос энгийн мориноос унасан хүүхдийн тоо дунджаар 46,5 хувь харин хурдны мориноос унаж бэртсэн хүүхдийн тоо дунджаар 53,5 хувь байна.

Өмнөговь аймгаас бусад судалгааны бүх талбарт өвлийн уралдаан болж байгааг хүүхдүүд хэлж байсан ба ГССҮТ-өөс авсан мэдээллээс үзэхэд хурдан мориноос унаж гэмтсэн хүүхдийн тоо өвлийн цагт буюу 11 дүгээр сараас 4 дүгээр саруудад дунджаар сард 35 хүүхэд байна. Жишээлбэл хурдан морь унадаг 9 настай хүүхэд “6 настайгаасаа уралдаанд оролцож эхэлсэн. Өвөл уралдаанаар морь унах болгонд 20,000 төгрөг өгдөг. Хорин мянгаа задлуулаад арван мянгыг нь уяач ахдаа өгөөд үлдсэнийг нь хадгалаад энэ жил 220,000 төгрөгтэй болсон” гэж ярьжээ. Тухайн унаач хүүхэд нэг удаа уралдаад ойролцоогоор 10,000 төгрөг авдаг гэж тооцвол 2020 оны

⁴³ МХЕГ-ын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02/356 дугаар албан бичиг.

өвөл 11 удаагийн уралдаанд оролцсон нь харагдаж байна. Өөр нэгэн унаач хүүхэд “Өвөл уралдаан болдог. Хурдан морины комисст байдаг хүмүүс өвөл бооцоотой уралдаан зохион байгуулдаг” гэжээ.

Нэгэн уяачтай хийсэн ярилцлагаар “Унаач хүүхдүүд одоо амарч байгаа цагаан сараас наана хийх ажил байхгүй. Өвөл уралдаан зохион байгуулах нь буруу биш. Буцаагаад сэргээнэ гэвэл дэмжинэ. Өвөл комбинзон өмсгөөд уралдуулахад тэд даарахгүй. Хүмүүс хүүхдийг хөлдөөгөөд байна гэж буруу ойлгодог” гэж хэлснээс үзэхэд уяачид өвөл ч морины ажилд унаач хүүхдүүдийг оролцуулдаг хэвээр төдийгүй өвлийн цагт хурдан морины уралдаан зохион байгуулахыг дэмжсэн хандлагатай байгаа нь ажиглагдлаа.

Унаач хүүхдийн сурч боловсрох эрх

Монгол Улс Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцод нэгдэж орсонтой холбоотойгоор ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хурдан морь унаач хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2005 оноос хойш тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх, хурдан морь унаач хүүхдийн хамгааллын чиглэлээр хэд хэдэн томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцын 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Арван гурваас арван таван насны хүүхдийг хөлсний эсхүл өөр төрлийн хөнгөн хөдөлмөр эрхлүүлэхийг үндэсний хууль тогтоомж, журмаар зөвшөөрч болно. Ингэхдээ ийм төрлийн хөдөлмөр нь (а) эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй, (б) хичээлдээ суух, эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн чиг олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх шаардлагыг хангасан байх ёстой” гэж заасан.

Бодит байдал дээр хурдан морь унаач хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөж уяачид, эцэг, эхчүүд хичээлийн жил дуусаагүй байхад ойролцоогоор 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хүүхдүүдийг сургуулиас нь нууцаар авч явах тохиолдол нийтлэг гардаг байна.

Судалгаанд оролцсон сургуулийн захирал, нийгмийн ажилтан, дотуур байрны багш нартай хийсэн ярилцлагаар “Хаврын уралдаан чинь голцуу 5, 6 дугаар сард болдог. Энэ үед улсын шалгалт таардаг. Энэ үеэр манай бага ангийн багш нар гэр орондоо авсан хэдэн хүүхдүүдээ алдчихгүй гээд аав, ээжтэй нь хүртэл муудалцаад явж байсан тохиолдол байгаа” гэсэн бол сургуулийн захирал “Яг хичээлийн жил бүрэн дуусаагүй шалгалт эхлэх үеэр уяачид сургуулийн гадаа хүлээгээд унаач

хүүхдүүдийг авч явах гээд байдаг. Манай багш нар заримдаа хүүхдүүдээ гэртээ авч очдог. Зарим багш 10 хүүхэд гэртээ хонуулсан тохиолдол байгаа” гэжээ.

Нэгэн аймгийн төрийн алба хаагч “Эндээс юу алдаж болох вэ гэдгээ хүүхэд өөрөө тооцоолж чадахгүй, ээж аавдаа мөнгө олж ирээд байдагтаа дуртай. Шаардуулж, шахуулж хийдэг хичээлээсээ хөндийрөөд байгаадаа тэд баярладаг. Хүүхэд бол гэнэн, цагаахан учраас хурдан морь унах нь дургүй зүйл нь биш, өөрсдөө бүр дуртай, донтчихсон байдаг. Хичээл номноос улам хөндийрдөг” гэсэн бол сургуулийн багш “Хичээлээс хоцрогдож үеийн хүүхдүүдээс сурлагын дүнгээр мууд тооцогдох болсон хүүхдүүд хичээл ном сонирхохоо больж, морь унаж амьдрах нь боломжтой, энэ чигээрээ байж болно гэсэн сэтгэхүйтэй болох магадлал өндөр байна” гэсэн байна.

Хүүхэд 14-15 нас хүрч уралдах нас нь өнгөрсөн тохиолдолд системтэй мэдлэг олж авч чадаагүйгээсээ анги дэвшин суралцах боломжгүй болж энэ наснаасаа эхлэн тухайн уяач, эздийнхээ туслах уяач болох, морь малын бусад ажлыг нь хийж өгөх зэргээр бусдаас хараат байдлаар морь уях, мал маллахаас өөр сонголтгүйгээр ажил, амьдралаа үргэлжлүүлэх болж байна.

Унаач хүүхдүүдийн сурлагын чанар, идэвх ямар байдаг тухай асуухад сургуулийн нийгмийн ажилтан “Ихэвчлэн сэргэлэн хүүхдүүдийг сонгож авдаг болохоор морь унадаг хүүхдүүд хичээлдээ огцом их муудаад байдаггүй. Гэхдээ хичээлдээ сайн байх боломжоо алдаж байгаа гэж боддог” гэж хэлсэн. Харин уяачтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаар “Хичээл хийлгэх ширээ, сандал бид бэлдэж өгдөггүй ээ. Интернэт ч байхгүй” гэсэн байна.

Нэгэн аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч “Энэ үнэхээр харамсалтай санагддаг. Бага ангидаа хамгийн мундаг сэргэлэн байсан хүүхдүүдийг аав, ээж нь манай хүүхэд морь унана, чөлөө өгөөч, явуулаач гэсээр байгаад хичээлийн хоцрогдолд оруулчихдаг” гэсэн бол сургуулийн нийгмийн ажилтан “унаач хүүхдүүд гэрийн даалгавар хийхдээ тааруу байдаг. Унаач хүүхдийг морь уях нь үндсэн ажил мэт зарим эцэг эхчүүд нь үздэг” гэж хэлсэн байна. Унаач хүүхдүүдийн эцэг, эхчүүдийн тал хувь нь үр хүүхдээ хайхардаггүй, анхаардаггүй. Хичээлээ тасалсныг нь ч мэддэггүй, эсвэл өөрөө хичээлдээ явбал явна биз, үгүй бол морио унана биз гэсэн байр суурьтай ханддаг. Унаач хүүхдийн эцэг, эх нь хүүхдээ сураглаад, асуугаад явах тохиолдол бараг л ажиглагддаггүй” гэж хэлсэн.

Нэгэн аймгийн сургуулийн нийгмийн ажилтан “Хичээлээ таслаад явахад нь уяачтай хүртэл холбогдож байгаад хүүхдээ буцааж ирүүлдэг. Нэг хүүхдийн аав нь байна гэж ирээд худлаа яриад аваад явчихсан байсан. Ээж рүү нь утасдаад асуухаар манай хүүхэд гэртээ ирээгүй гэж хэлсэн болохоор цагдаагийн байгууллагад

мэдэгдэхэд саад болсон, ална хядна гэж сүрдүүлэх тохиолдол ч байсан. Уяачид уралдааныг эд хөрөнгөө арвижуулах нэг боломж гэж ойлгодог учраас ямар нэгэн байдлаар саад болохоор бухимддаг. Унаач хүүхдүүдийг байнга авч явах хандлагатай байдаг. Өвөл ч гэсэн мориныхоо ажлыг хийдэг юм билээ. Манай аймгийн урдуур том том блокон хашаатай, тойроод жүчээнүүд нь байдаг. Уяачид хүүхдүүдээр морины уяа тойлготой ажлыг өвөл гэхгүй хийлгүүлж, үндсэн ажилтан мэт ханддаг” гэжээ.

Нийгмийн амьдралд оролцох, хөгжих боломж

Хүүхэдтэй хийсэн ярилцлагаар “Ойлголцоход амар байдаг болохоор морь унадаг хүүхдүүдтэйгээ л найзлах дуртай. Би гурван сайн найзтай. Тэд хурдан морь унадаг байсан хүүхдүүд. Унаач хүүхдүүд мөнгөтэй байдаг болохоор найз нөхдөө сонгоход хэцүү. Мөнгөтэй гээд найзлах гэсэн хүүхэд олон байдаг учраас...”, мөн нэгэн аймгийн цагдаагийн алба хаагч “Том уяачийн морийг унадаг хүүхдүүд бусад жижиг уяачийн морь унадаг хүүхдүүд дотроо илүү том зантай байдаг. Ийм төрлийн зэрэглэл ажиглагддаг” гэж хэлсэн байна. Харин сургуулийн нийгмийн ажилтан унаач хүүхдүүдийн талаар “Зан харилцааны хувьд бусад хүүхдээс ялгаатай болдог. Тухайлбал ангийнхныгаа элдэв бусын хараал, доромжилсон үгээр дуудах нь их байдаг” гэсэн юм. Эдгээрээс дүгнэвэл хурдан морь унаач хүүхдүүд нийгмийн амьдралд хэвийн оролцох, бусад хүүхэдтэй ижил тэгш, зөв харилцах тал дээр хоцрогдолтой болдог байх магадлалтай байна.

“Үүрийн зургаан цагт босоод ус, тэжээл өгөөд, өдөр жүчээндээ байлгана, орой бас морины ажлаа хийгээд их оройтож гэртээ ордог. Тэр хооронд зав гарахаар л тоглодог” гэж 9 настай унаач хүүхэд хэлсэн бол туслах уяач, унаач 14 настай хүү “Ажил маш ихтэй. Ер нь 6, 7 дугаар ангид байхдаа л жаахан зав гардаг, тоглож нааддаг байсан тэрнээс хойш унаач хүүхдүүд уяачийн туслахтай адилхан өдөр шөнөгүй ажилладаг. Дээрээс нь бас морио унаж уралддаг. Ер нь 13-аас дээш настай унаач хүүхдүүдийн хувьд өглөө эрт ус зөөж, морио услаад, тэжээлийг нь зуурч тавьж өгөх, өдрийн цагаар морио алхуулж байгаад ..., Өвөл, хавартаа уралдаан цөөнтэй бол сургуульдаа яваад бага ч гэсэн зав гарна. Харин зун, намрын цагт зав гарна гэж бараг байхгүй. Уяачийн, туслах уяачийн хийдэг бүх ажлыг унаач хүүхэд хийгээд явдаг болохоор ажил үнэхээр ихтэй” гэж хэлсэн байна.

Аймаг, орон нутагт хүүхдүүд завгүй байдаг бол Улаанбаатар хотод амьдардаг унаач хүүхэд “Өглөө эрт босдог, орой 23 цаг гээд амардаг. Уралдааны үед үүрээр босдог. Морь унахаа болиод гэртээ байдаг ажил хийх юм сан гэж боддог. Унаач хүүхдүүд бүгд ижил завгүй. Морь унадаг эмэгтэй хүүхдүүдийн хувьд ялгаа бага ч тэд гүү, үнээ саахад тусалдаг. Морио услах, байраа цэвэрлэх хоол хийх гээд ижил

ажил хийдэг. Эрэгтэй хүүхдүүд малд явах, мал ялгах зэрэгт нэмж тусалдаг гэжээ.

Унаач хүүхдүүд “Бид бол ер нь зав муутай байдаг” гэж хэлснээс үзэхэд цаг завгүй, хүнд хөдөлмөр болох нь ойлгогдож байна. Нэгэн аймгийн сургуулийн нийгмийн ажилтан унаач хүүхдийн талаар “Өвс тавьж өгөх, усыг нь ойртуулж өгнө гэх мэтчилэн хийж байгаа ажлуудыг нь харахаар ерөөсөө зарц шиг байдаг. Жишээлбэл гэр худалдаж авсан гээд байгаа хүүхдийн хувьд бол өөрийнхөө гэрт очиж амьдардаггүй. Нөгөө уяачийндаа амьдардаг. Зарим айлын амьдралын боломж нь муу болохоор уяачийндаа амьдарсан нь илүү тухтай байдаг” гэжээ.

4.3 Хурдан морь унаач хүүхдийн гүйцэтгэдэг ажил нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн шинжийг агуулж буй байдал

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцын 3 дугаар зүйлийн (d) хэсэгт ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх болон (д) тодорхой хүнд нөхцөлд, тухайлбал уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар, эсвэл ажил олгогчийн ажлын байранд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хашигдан хийж буй ажлыг “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэж үзэх бөгөөд конвенцыг соёрхон баталж буй гишүүн улс бүр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ нэн даруй авч хэрэгжүүлэхээр заасан байна. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай ОУХБ-ын 1999 оны 190 дүгээр зөвлөмжид конвенцын өмнө дурдсан 3 дугаар зүйлийн (d) хэсэгт заасан ажлын төрлүүдийг тодорхойлох, тэдгээрийн оршин байгаа газруудыг тогтоохын тулд “хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил”-д анхаарлаа хандуулах бөгөөд “Үндэсний хууль тогтоомжоор, эсвэл эрх бүхий байгууллага нь ажил олгогчид болон ажиллагчдыг төлөөлсөн байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун бүрэн хамгаалагдсан, түүнчлэн хүүхэд хийж буй ажлынхаа талаар тодорхой зааварчилгаа авсан эсвэл тухайн ажлын чиглэлээр мэргэжлийн сургалтад хамрагдсан нөхцөлд конвенцын 3 дугаар зүйлийн (d) хэсэг болон дээрх 3 дахь хэсэгт дурдсан ажил болон гэрээт хөдөлмөрт 16 нас хүрсэн хүнийг ажиллуулахыг зөвшөөрч болно” гэж заасан.

Иймд судалгаагаар хурдан морь унадаг хүүхдүүд бие бялдар, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа эсэх, ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь унаач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлдэг эсэхийг илрүүлэхийг зорьсон.

Унаач хүүхдийн бие, эрүүл мэндэд гарах өөрчлөлт болон бэртэл, гэмтэл

Унаач хүүхдүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр “Хүүхдүүд хурдан морь унаснаар биед гарах нийтлэг өөрчлөлтүүдийг тодорхойлсон зүйл байхгүй байна. Унаач хүүхдүүд морин дээрээ тонгойж явдаг тул уралдааны явцад нуруу, хөл өвдөх зэргээр биед мэдрэгддэг” гэж хэлсэн.

Аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагчаас унаач хүүхдүүдийн биед гарах өөрчлөлтийн талаар асуухад “унаач хүүхдүүд бусад хүүхдээс илүү чанга биетэй болсон байдаг” гэж хариулсан. Нэгэн аймгийн ГБХЗХГ-ын ажилтан “Үнэн, худлыг нь мэдэхгүй хүүхдийн өсөлтийг зогсоох зүйл өгдөг гэж сонссон” гэж хариулсан бол нэгэн аймгийн ЗДТГ, ИТХ-ын Ажлын албаны ажилтнуудтай хийсэн ярилцлагаар “Хүүхдүүд жүжигчилсэн тоглолтондоо унаач хүүхдэд өсөлт зогсоох эм өгч байгаа үйл явцыг дүрсэлсэн байсан. Ам дамжсан ийм яриа байдаг. Үнэн худлыг нь мэдэхгүй” гэв.

Хэдийгээр унаач хүүхдийн биед гарах өөрчлөлтийг нийтлэг байдлаар тодорхойлсон үр дүн чанарын судалгаанаас гараагүй боловч Биеийн тамир, спортын улсын хорооны спортын мэргэжлийн эмч нартай хамтран 21 аймгийн 8-14 насны хурдан морь унаач 80 хүүхдийн бие бялдрын ерөнхий хөгжилд судалгаа хийсэн. Хэвийн хөгжилтэй хүүхдүүдтэй харьцуулахад нийт хурдан морь унадаг хүүхдүүдийн 12 хувьд нь цээжний хэлбэр шөвгөр, 28 хувьд нь хэт хөнгөн ясны бүтэцтэй биеийн хэв шинж, 8,75 хувьд нь нурууны нэг тал руу мурийсан мурийлттай, 8,75 хувьд нь хөлийн ул хавтгай болсон, 6,25 хувьд нь шувуун цээжтэй гэсэн байна.

Өмнөх судалгааны статистик мэдээнээс харахад жил бүр хүүхдийн бэртэл гэмтлийн тоо цөөрч байгаа ч амь нас эрсдэх, бэртэл, гэмтэл явдал гарсаар байна.

Ганцаарчилсан ярилцлагын судалгааны явцад унаач хүүхдүүдээс бэртэл, гэмтэл авч байсан эсэх талаар асуухад дараах хариултыг өгчээ. Үүнд:

- Эмнэг морины амыг дийлэхгүй мориноосоо унах, морьтойгоо бөмбөрөх тохиолдол их гардаг. Манай найз олон удаа толгойгоо хагалсан.
- Соёолон морь унаж, сунгаанд явахад миний олом тайлагдаад мориндоо чирэгдсэн. Ашгүй гутал сугараад үлдсэн. Хэвтэж байхдаа чихээ хөлдөөсөн. Намайг босож чадахгүй болохоор машинтай ирж авсан. Гэхдээ эмнэлэгт үзүүлээгүй.
- Миний хувьд их хүнд гэмтэж байгаагүй. Гэхдээ мориноос унаж хүнд бэртсэн хүүхэд олныг мэднэ. Тархи хөдлөх, шалбарах, цус гарах бол наад захын асуудал. Тэднийг ер нь эмнэлэгт үзүүлдэггүй. Өөрсдөө л хэсэг хугацааны дараа эдгэрдэг гэж боддог.
- Бороонд морь халтирч унах нь осолтой учир хэцүү санагддаг зэрэг болно.

Үүнээс үзэхэд ГССҮТ-д бүртгэлтэй хүүхдүүдийн тоо бодит байж чадахгүй байна. Хүүхдүүдтэй хийсэн ярилцлагаар гарцаагүй хүнд тохиолдолд хүүхдийг эмнэлэгт хүргэдэг нь нууц биш байна.

ГБХЗХГ-ын “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн сан”-гийн Хурдан морины уралдааны мэдээллийн дэд санд байгаа статистик мэдээллээс үзэхэд 2018-2020 онд нийт 671 уралдаан зохион байгуулагдсанаас аймаг, сумдад 647, нийслэлд 24 уралдаан зохион байгуулагдаж, 165 хүүхэд ямар нэгэн бэртэл гэмтэл авсан байна.

Дээрх уралдаанд оролцож бэртэл гэмтэл авсан хүүхдийн тоог ангилан үзэхэд 2018 онд улсын хэмжээнд 24 уралдаан зохион байгуулагдаж 1,939 хүүхэд морь унаж, 57 хүүхэд бэртэл, гэмтэл авсан байна. Мөн 2019 онд уралдаан 197 болж 21,8 хувиар, хурдан морь унасан хүүхдийн тоо 7,380 болж 400 орчим хувиар, бэртэл гэмтлийн тоо 89 хувиар тус тус өссөн байна. Суурь үзүүлэлт болгож буй 2018 онтой 2020 оны дүнг харьцуулахад уралдааны тоо 467 болж 19,4 дахин өссөн, хурдан морь унасан хүүхэд 6,666 буюу 350 орчим хувиар өссөн, бэртэл гэмтлийн тоо 19 болж буурсан үзүүлэлттэй байна.

Нэг уралдаанд эзлэх хурдан морь унаач хүүхдийн бэртэл гэмтлийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа нь Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандарт батлагдаж, 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Тухайлбал 2020, 2021 онд МХЕГ-ын даргын баталсан “Морь унаач хүүхдийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийг аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагуудад хүргүүлэн хурдан морины уралдаануудад хүүхэд унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх шалгалт хийж, зохион байгуулагч, уяач, эцэг, эхчүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж, танилцуулга, сэрэмжлүүлэг хүргүүлж ажилласнаар 17,450 хүүхэд хурдан морь унаж уралдсанаас 7,356 хүүхэд хамгаалалтын дуулга өмсөж, 17,081 хүүхэд хамгаалах хэрэгсэл өмсөж, 17,081 морийг хэрэгсэлтэй уралдуулжээ.⁴⁴

⁴⁴ МХЕГ-ын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02/356 дугаар албан бичиг.

Долдугаар ангийн нэг хүүхэд байсан. Самбо, жүдогоор хичээллэдэг, зүүн бүсийн аварга, улсын аваргад байр эзэлж байсан. Өөрөө жижигхэн биетэй. Ахынхаа морийг унаж яваад мориноосоо уначихсан. Одоо тэр хүүхэд морь ч унаж чадахгүй, барилдаж ч чадахгүй болчихсон. Тархиндаа гэмтэл авсны улмаас нилээн удаан эмнэлгээр явсан.

*(Сургуулийн нийгмийн ажилтнуудтай хийсэн
фокус бүлгийн ярилцлагаас)*

МХХ-ны Хүүхдийн эрхийн дэд хорооны мэдээллээс үзэхэд ГССҮТ-ийн “Мориноос унаж гэмтсэн шалтгаанаар эмнэлгийн тусламж авсан хүүхдийн судалгаа”⁴⁵-нд 2019 онд улсын хэмжээнд хурдан мориноос унаж бэртэл гэмтэл авсан 172, 2021 оны хагас жилийн байдлаар 31 хүүхэд байна гэжээ. Мэдээллээс харахад энгийн мориноос унасан, уралдааны мориноос унасан нас, хүйс, уралдааны тоо, нас баралтын шалтгаан нь аль хэлбэрээс болсон нь тодорхой харагдахгүй байна. Энэхүү статистик нь ГБХЗХГ-ын мэдээллийн сангийн мэдээллээс их зөрүүтэй байсныг анхаарах нь зүйтэй юм.

ГССҮТ-ийн статистикт жилийн дөрвөн улиралд хурдны мориноос унаж бэртсэн хүүхдийн тоо бүртгэгдсэн, мөн хурдан морь унаач хүүхдүүдтэй хийсэн ярилцлагад “жилийн дөрвөн улиралд уралдаан, үсэргээ, сунгаа явдаг” гэж хэлснээс үзвэл төрийн байгууллагуудын хянах боломжгүй байдлаар хурдан морины уралдаан зохион байгуулагдаж, уралдааны явцад хүүхэд мориноос унах, бэртэх тохиолдол эмнэлгийн үйлчилгээ авсан тоогоороо ийнхүү бүртгэгдсэн гэж дүгнэж болохоор байна.

ГБХЗХГ-ын алба хаагчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлагын явцад албан ёсны уралдаанд төрийн байгууллага хяналт тавьж, бүртгэж байгаа ч нууцаар зохион байгуулсан уралдааныг хянах хүн хүч, боломжгүйг дурджээ.

Унаач хүүхдийн ажиллах нөхцөл нь сэтгэл зүйн хүчирхийлэлд өртүүлэхүйц байдал, насны ангиллаар

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ” гэж тодорхойлсон байдаг. Судалгааны үр дүнд

⁴⁵ МХХ-ны Хүүхдийн эрхийн дэд хорооноос ирүүлсэн мэдээллээс. 2022 он.

ерөнхийдөө хүсэл зоригийнх нь эсрэг, албадах, үл хайхрах, мөрдөн мөшгөх, заналхийлэх, хязгаарлах, гутаан доромжлох хэлбэрээр сэтгэл санаанд айдас, түгшүүр, шаналал үүсгэхүйц нөхцөл унаач хүүхдийн ажлын шинж чанарт байдаг эсэхийг тодруулахыг хичээсэн юм.

Хурдан морь унаач хүүхдийн сэтгэл зүйн байдал нь хаана хэний морийг унаж байгаа эсэхээс ихээхэн хамаардаг нь тэдэнтэй хийсэн ярилцлагын үеэр тодорхой харагдлаа. Өөрөөр хэлбэл гэртээ байж өөрийн эцэг эх, эмээ өвөөгийнхөө морийг унадаг хүүхдийн сэтгэл зүйн байдал, айлд байж хүний морийг унадаг хүүхдийн сэтгэл зүйн байдал нэн ялгаатай байна. Бага насны буюу 12 хүртэлх насны унаач хүүхдийн сэтгэл зүйд гарах өөрчлөлт 13-аас дээш насны хүүхдүүдийн сэтгэл зүйд гарах өөрчлөлтөөс харьцангуй ялгаатай байгаа нь ажиглагдсан.

Хурдан морь унадаг 12 хүртэлх насны унаач хүүхдүүд сэтгэл санаанд сөргөөр нөлөөлөхүйц байдал тохиолддог талаар дараах асуудлыг хэлсэн. Үүнд:

Мөрдөн мөшгөх - “Багаасаа өөр айлын морь унадаг байсан. Манай хамаатны ах намайг ирээд булаагаад аваад явсан. Би зугтаагаад явахад дахиж ирээд авсан. Жаахан байхад хэний морийг унахаа өөрөө сонгох боломжгүй байдаг” гэжээ.

Хязгаарлах - Туслах уяач гэр лүүгээ явна гээд гутлаа бариад хөл нүцгэн зугтаахад араас барьж аваад сугандаа хийж хавчаад гэрт оруулаад хүлээд хонуулсан хэмээн хэлсэн бол худалдааны төвд ажилладаг нэгэн охин хэлэхдээ “манай ажил дээр нэг өдөр гартаа мөнгө бариад зугтаагаад ирсэн 6-7 орчим насны хүүхэд байсан. Тэр хүүхэд араас хүн ирээд бариад авна гэж айгаад манай ажлын ахын машинаас гарч чадахгүй нуугдаад байсан. Манай ажлынхан тайвшруулаад нутгийнх нь унаанд суулгаад явуулсан” гэжээ.

Гутаан доромжлох хэлбэр - Том хүнтэй харьцахад заримдаа хэцүү байдаг. Тийм үед бид жалганд очоод нуугдчихдаг. Хааяа нүх ухаж нуугддаг. Архи уухаараа ноолох, элдвээр хэлээд байх нь хэцүү байдаг гэж хэлсэн бол 13-аас дээш насны унаач хүүхэд энэ талаар “Уяач, туслахууд жаахан хүүхдийг шоглоод байдаг. Уяач айлынх нь хүүхдүүд нь бас дээрэлхэнэ. Уяачийн надаас ах нэг хүүхэд намайг байнга дээрэлхдэг байсан” гэж хэлжээ.

Сэтгэл санаанд айдас, түгшүүр, шаналалд өртөх - “Их насны морь, азарга, эрлийз морь унахад амыг нь дийлэхгүй, хадуурах, булгихад хэцүү байдаг, шанаа руу нь ташуурдах зэргээр аргалдаг. Морио эргүүлж уралдаанд оруулж чадахгүй бол яана аа гэж их айдаг” гэсэн бол “Анх 8 настай унаж эхлэхэд айж байсан, эхний 2 жил айдастай л байсан, гэхдээ магтуулаад ирэхээр айдсаа орхисон. Ер нь бол хоцрох вий, унаж гэмтэх вий надаас болж уралдаанд түрүүлэхгүй бол яана аа гэсэн бодол

байнга байдаг”, “Уулын өгсүүр уруу газар, шавартай газар, олон машин зэрэгцэж давхих үед морь үргээд би айдаг” гэх мэтээр унаач хүүхдүүд хариулсан байна.

Нэгэн аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч “Айлд байгаа унаач хүүхдүүд гөлийчихсөн байдаг. Ар гэрийг нь асуухад зарим нь шууд уйлна эсвэл нулимс нь цийлгэнээд гэрээ санасан гэдэг. Малчин айлынхан боловсрол багатай хүмүүс байдаг болохоор элдэв янзаар хандана. Зарц байдалтай харьцаад шийтгэнэ. Ийм асуудал бол гарч байсан” гэж хэлсэн.

Уяачаас энэ талаар асуухад энгийн нөхцөлд ямар ч асуудал байхгүй харин уралдааны үеэр л асуудал гардаг гээд “Уралдааны үед унаач хүүхдүүд, туслах уяачид хоорондоо зодолдох асуудал бол гардаг. Ташуурын хэмжээг тусад нь заагаад дүрэмдээ оруулсан. Нэг хэсэг урт ташуур эргүүлээд хоорондоо зодолддог байсан. Ер нь тавиач хүүхдүүд төхөөрөмжид ойр зогсох гэж муудалцах, тавиачгүй хүүхдийг дээрэлхэх зэрэг асуудлаас болж зодолддог. Үүнийг зохицуулах шаардлагатай” гэсэн байна.

МХЕГ-аас 2021 онд стандартын бус ташуур хэрэглэсэн 18, гуталгүй ирсэн 8 тохиолдол, биедээ богино долгионы станц чихэвч хэрэгсэл авч явсан 12, гар утас 2, хувцас биеийг нь скочоор ороож бэхлэх, урт суран оосор, резинэн утас, чулуугаар хийсэн дүүгүүр, гал асаагуур, гялгар уут, хадаг, шүгэл биедээ авч гарахыг оролдсон зэрэг 36 тохиолдлыг илрүүлж таслан зогсоосон байна.⁴⁶

Хурдан морь унадаг 13-аас дээш насны хүүхдүүд сэтгэл санаанд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл, тохиолдлыг ийнхүү ярьж байна. Үүнд:

Заналхийлэх - Уяачид, тэдний туслахуудад зодуулахаар морь унахаа болих юм сан гэж боддог. Зоддоггүй айл гэж хаа нэг байх болов уу. Алгадна, өшиглөнө, цохино, элдэв юмаар цохих үе ч байдаг. Морины ажил буруу хийх, ажлаас зугтаагаад мэдэгдэх тохиолдолд зодуулдаг.

Сэтгэл санаанд айдас, түгшүүр, шаналалд өртөх - “Хамгийн хэцүү нь ажил маш их байдаг. Дээрээс нь бас морио унаад уралдаад явдаг. Би цаашид уяач болохгүй. Хотод очиж банканд ажилладаг хүн болно” гэж хэлсэн бол энэ талаар Улаанбаатар хот орчимд амьдардаг унаач хүүхэд “Цалингаа авч чадахгүй муриулж байсан. Гэхдээ цагдаа, шүүхэд хандаагүй. Том хүн болохоор яаж ийгээд аргалаад өнгөрөх байх гэж бодоод айгаад өнгөрсөн. Намайг хамгаалах хүн байхгүй гэж хариулсан бол өөр нэгэн хүүхэд “Бидэнд заримдаа зөвлөгөө авах хэрэгцээ байдаг. Хэнд хандахаа мэдэхгүй байна. Хандвал цаашдаа яах бол гэж айдаг, морь унахгүй гэртээ ажил хийх юм сан” гэжээ.

⁴⁶ МХЕГ-ын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02/356 дугаар албан бичиг.

Үүнээс дүгнэж үзвэл 12 хүртэлх насны унаач хүүхдүүд морины амыг татаж дийлэхгүйгээс эсвэл бороонд морь халтирах зэргээс болж унаж гэмтэх, уралдааны үед бусдад ташуурдуулах, үеийн хүүхдүүдэд дээрэлхүүлэх, архи уусан хүнтэй харьцахаас айх, уралдаанд хоцрох, түрүүлэхгүй байх зэрэг айдас, түгшүүрээ илэрхийлсэн.

Гомдсон, гэрээ санасан тохиолдолд уяаны галаас зугтах тохиолдол ч цөөнгүй гардаг нь ажиглагдлаа. Харин 13 ба түүнээс дээш насны унаач хүүхдүүд мориноос хүчтэй унах, зодуулж шийтгүүлэхээс айх, завгүй ажиллахаас халшрах, цалингаа авч чадаагүй тохиолдолд том хүнээс нэхэж авахаас айх зэрэг айдас, түгшүүрээ илэрхийлсэн.

Аль ч насны бүлгийн хүүхдүүд мориноос унаж гэмтэх, бэртэхээс болон зодуулах, шийтгүүлэхээс айх тал ижил байгаа нь ажиглагдсан. Мөн аль ч насны унаач хүүхдүүдийг зодож шийтгэх буюу бие махбодын шийтгэл хүлээлгэх тохиолдол нийтлэг байгаа нь судалгаагаар илэрлээ. ОУХБ-ын “Ажлын байрны хүчирхийлэл”⁴⁷ тайлангаас үзэхэд бие махбодын шийтгэл оногдуулах нь сэтгэл санааны хэвийн байдлыг алдагдуулж стресс үүсгэн эрүүл мэндэд нөлөөлөх, сэтгэл, сэтгэл зүйн асуудалд илүү өртөмтгий болгох, төвлөрөх чадварыг бууруулах зэргээр танин мэдэхүйн чадварт нь нөлөөлөх, өөртөө итгэлгүй болгох, айдас, түгшүүр үүсгэхээс эхлээд сэтгэцийн эмгэгт хүргэх хүртэл муугаар нөлөөлдөг гэжээ. Түүнчлэн нэгэн аймгийн ИТХ-ын Ажлын алба, ЗДТГ-ын ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагын үер “Унаач хүүхдүүд загнуулж, зодуулдаг байх магадлалтай. Уяачийнхаа хажууд урагшаа замаа харж чадахгүй дальдчаад, уяач руугаа хараад яваад байдаг. Намайг загнах вий, цохиод авах вий гэсэн айдас байдаг байх гэж бодсон” гэсэн.

Өөрийн гэртээ байж өөрийн эцэг эх, эмээ өвөөгийнхөө морийг унадаг хүүхдүүд өөртөө итгэлтэй, өөрийгөө илэрхийлэх ярианы чадвар сайн, харилцааны хувьд нээлттэй байгаа нь хурдан морь унаач хүүхдүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс ажиглагдсан.

Айлд байж, хүний морийг унадаг хүүхдүүдийн хувьд өөртөө итгэх итгэлгүй боловч аливаа зүйлд дасан зохицохдоо амархан байх хандлага ажиглагдаж байгаа ч маш их зүйлд сэтгэл нь түгшиж айдаг, гэр бүлийн таагүй уур амьсгалаас шалтгаалсан сэтгэл зүйн түгшүүр өндөр, өөрийн ах, эгч, дүүгээ санадаг, мөн сайн байгаа эсэхэд эргэлзэж байнга санаа нь зовдог, гэр бүл нь мал байхгүй хэдий ч морины талаарх

⁴⁷ ОУХБ, “Ажлын байрны хүчирхийлэл”, 2006 он, 132-133 дугаар тал, бүрэн эхээр нь дараах холбоосоор үзнэ үү: https://www.ilo.org/global/publications/ilo-bookstore/order-online/books/WCMS_PUBL_9221108406_EN/lang--en/index.htm

мэдлэг их, хурдны морь унадгаараа өөрөөрөө бахархдаг, сэтгэхүйн хувьд насны дунджаас доогуур хөгжилтэй байгаа нь ажиглагдсан. Хурдан морь унаж байсан хүүхдүүд хөлсөөр морь унадаг, унаач хүүхдүүдийн хийх ажил нь ялгаатай хамаатны хүүхдээр арай хөнгөн ажил хийлгэж өөр айлаас ирж морь унадаг хүүхдээр ихэнх ажлыг хийлгэдэг, уяач, туслахууд жаахан хүүхдүүдийг шоглодог бол уяач айлынх нь хүүхдүүд нь бас дээрэлхдэг байна.

Унаач хүүхдийн ажил ёс суртахуунд нь хор нөлөө үзүүлдэг эсэх

Унаач хүүхдүүд ихэвчлэн гэрээсээ хол, өөр айлд очиж морь унадаг бөгөөд эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналтаас хол байдаг тул тамхи татах, хараалын үг хэлэх, согтууруулах ундаа хэрэглэх хорт зуршилд автах магадлал өндөр байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Сургуулийн нийгмийн ажилтнаас унаач хүүхдийн ёс суртахуунд гарах өөрчлөлтийг тодруулахад “Зан харилцааны хувьд бусад хүүхдээс ялгаатай болдог. Тухайлбал ангийнхныгаа элдэв бусын хараал, доромж үгээр дуудах нь их болдог. Ёс суртахууны хувьд эвгүй болчихсон байдаг. Уяач ах нараас янз бүрийн зан сурчихсан, өөрийгөө том хүн болчихсон гээд бодчихсон байдаг. Том ах болох гээд л... Зарим нь овортой зан гаргаад байдаг зүйл ажиглагддаг. Хичээлдээ тогтмол явдаг, морь унадаггүй хүүхэд, унаач хүүхдийн явж байгаа явдал нь хүртэл өөр. Алхаа гишгээ нь хүртэл настай хүн шиг явах жишээтэй” гэв.

Харин хурдан морины унаач хүүхэд “хараалын үг хэрэглэх нь их болдог байж магадгүй. Гэхдээ манай үеийн хүүхдүүд бүгд хараалын үг ашигладаг, бас хийе гэсэн юм аа сайн муу гэхгүй хийгээд л явчихдаг гэж бодож байна” гэсэн байна. Өөр нэгэн аймгийн хурдан морь унадаг байсан хүүхэд “Тамхины хувьд 5, 6 дугаар ангийн хүүхдүүд тамхи татах нь бага. Харин 7-8 дугаар ангийнхан нийтлэг тамхи татдаг болчихсон байдаг. Уяачид сүүлдээ мэддэг болоод унаач хүүхдүүдээ тамхи авч ирдэг болсон” гэсэн бол сургуулийн нийгмийн ажилтан “Архи, тамхины хэрэглээ байна. Мэр сэр байна” гэж хэлсэн.

Нэгэн аймагт туслах уяач хийдэг 16 настай хүүхэд “Уяач, уяачдын туслахууд унаач хүүхдүүдийг архи, тамхи хэрэглэхийг хориглодог тул тэд багаасаа тамхи, согтууруулах ундаа хэрэглэж сурах нь цөөн. Гэхдээ унаач хүүхдүүдээс туслах уяач болсон бол тамхи, архи хэрэглэж эхлэх нь их байдаг. Ялангуяа туслах уяачдын дунд тамхи татдаггүй хүн гэж байдгийг би мэдэхгүй. Ер нь унаач хүүхдүүд 15-16 наснаасаа бие нь том болоод уралдахаа больдог. Тэгээд зарим нь туслах уяач болоод тэр л үеэс эхлэн тамхи татаж, архи, пиво ууж эхэлдэг” гэж хэлснээс үзэхэд бага насандаа муу зуршилд автах нь цөөн байж болох ч цаашид туслах уяач болж ажиллах үедээ хорт зуршилтай болох нь элбэг байна.

Мөн туслах уяачид унаач хүүхдүүдэд байнга заавар өгч, хянаж ажиллах үүрэгтэй гэж үзвэл тэдний үлгэрлэл, зан харилцааны доголдол нь хүүхдийн ёс суртахуунд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой гэж үзэж болохоор байна. Жишээлбэл нэгэн аймгийн 9 настай унаач хүүхэд “Би тамхи татахгүй, аав маань ч тамхи татдаггүй. Харин хурдны морь унадаг 12 настай ах маань тамхи татдаг. Манай туслах уяачид манай найз бид хоёрыг хүлж байгаад ам, хамар дараад нэг хамраар маань тамхи соруулж тоглосон. Тэгэхдээ тамхи чинь гоё үнэртэй юм байна” хэмээжээ. Унаач, тавиач хүүхэд бусдыг дээрэлхэх, асуудлыг биеийн хүчээр шийдвэрлэх, нэгнээ ялгаварлан гадуурхах, ангилал, зэрэглэл тогтоох зэрэг нийгмийн сөрөг зан үйлд хэвшүүлэх хор нөлөөтэй болохыг анхаарах нь зүйтэй юм.

Түүнчлэн унаач хүүхдийн хийж байгаа ажил, түүнийг гүйцэтгэх шинж чанар нь (1) арван найман насанд хүрээгүй болон бага насны хүүхдийг, (2) ашиглах буюу хөдөлмөрийг нь мөлжих зорилгоор, (3) эцэг, эх, асран хамгаалагч нь шан харамжтай эсвэл шан харамжгүйгээр (4) бусдад өгөх гэсэн боолчлолын бүх дөрвөн шинжийг бүрэн хангаж байгаа тул унаач хүүхдийн хөдөлмөр нь боолчлолын хэлбэрийг агуулж байгаа гэж үзэх бүрэн үндэслэлтэй байгааг анхаарч эрх зүйн зохицуулалт, нийгэм, эдийн засгийн нөхцөл зэрэг бүх талаас нь бүрэн зохицуулах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны ерөнхий дүгнэлт

Монгол Улсад ажил хийдэг, ялангуяа тэвчишгүй болон аюултай хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд цөөнгүй байгаа боловч тэдний эрхийг хамгаалах, хөдөлмөрөөс хөндийрүүлж нийгэмд эргэн нэгтгэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалт, тогтолцоо төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байна. Жишээлбэл Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулсан ч хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зохицуулалт агуулаагүй байна. Хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх боломж багатай гэж үзэж болох хэдий ч цаашид хүүхдийг хамгаалахын тулд хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг илрүүлэх шаардлагатай байгаа тул тоон мэдээллийн санг илүү бодит, цогц судалгаанд үндэслэн зохион байгуулж, үр дүнтэй байдлаар хяналт тавих нь зүйтэй байна.

Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцод гишүүн улс бүр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн тэргүүнд устгахад чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр заасан. Энэ дагуу Засгийн газраас 2011 оны 303 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”-ийг батлан, 2012-2016 онд хэрэгжүүлсэн боловч дараагийн шатны бодлого, хөтөлбөрийг батлаагүй байна. Монгол Улс хэд хэдэн бодлого, хөтөлбөртөө хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгахтай холбоотой зүйл заалтуудыг оруулсан боловч одоогоор хүүхдийн хөдөлмөрийг хориглох, устгахад тусгайлан чиглэсэн хүчин төгөлдөр хөтөлбөр, нэгдсэн бодлогогүй байгаа нь энэ чиглэлийн үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, үүний дотор боолчлолын хэлбэрүүд, хүн худалдах, хамжлага болгох, албадан хөдөлмөрлүүлэх, хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглах, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, биеэ үнэлэлт, садар самуунд болон бусад гэмт хэрэг, зөрчилд ашиглах, хохироох асуудлаар манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжууд хүчин төгөлдөр үйлчилж үр дүнгээ үзүүлж байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд Зөрчлийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Эрүүгийн хууль зэрэг хууль тогтоомжид

нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог ханган сайжруулах шаардлагатай байна.

Ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх буюу хүүхдийн хөдөлмөрийн аюултай хэлбэрийг эрх зүйн хэм хэмжээгээр төдийлөн тохиромжтой зохицуулаагүй, холбогдох шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж шинэчилдэггүйгээс шалтгаалан хүүхдийн хөдөлмөрийн аюултай хэлбэрүүдийг тодорхойлох, таниулах, хориглох ажил төдийлөн үр дүнтэй байж чадсангүй өнөөг хүрсэн байна. Зарим аймаг, орон нутагт хүүхдээр ажил хийлгэж огт болохгүй гэсэн хэт өрөөсгөл үзэл, хандлагаас болж ажил олгогч, хүүхэд, эцэг эхийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж байгаа тохиолдол ч гарсаар байна. Иймд хүүхдийн хөдөлмөрийн аюултай хэлбэрийг хориглох эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн тодорхой болгож, нийгэмд хүртээмжтэй, үр дүнтэй арга замаар тайлбарлан таниулах нь зүйтэй байна. Хүүхдийн эрхэлж болох хөнгөн ажлын хэлбэрүүдийг зохимжтой байдлаар тодорхойлох нь ажлын үр дүнд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм.

Хөдөлмөрийн насны доод хязгаарын талаарх үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенцод нийцсэн байх боловч Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дурдсан 13 нас хүрсэн хүний ажиллаж болох хөнгөн ажил, түүнийг гүйцэтгэх нөхцөлийг жагсаалтаар яаралтай гаргах, энэхүү жагсаалтыг практикт хэрэгжүүлэхдээ хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, боловсролын үйлчилгээ болон нийгмийн амьдралд оролцох боломжийг нь бодитоор хангах асуудлыг маш оновчтой зохицуулах, хэрэгжүүлэх эрх зүйн болон нийгмийн суурь нөхцөлийг урьдчилан бүрдүүлсэн байх шаардлагатай байна.

Дээр дурдсаны дагуу хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй, аюултай хэлбэрүүдийг үр дүнтэй хориглох, улмаар устгах, хүүхдийн хийж болох ажлыг оновчтой тодорхойлж давуу талыг нийгэмд ашигтайгаар зохицуулахын тулд юуны өмнө хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг зөв тодорхойлох, ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг бүрэн, цогц хөгжүүлэх шаардлагатай байна.

Ялангуяа хурдан морь унаач хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлт, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн хөдөлмөрийн аюултай, цаашилбал тэвчишгүй хэлбэрийг агуулж байна. Мөн 7 нас хүрсэн хүүхэд хурдан морь унах боломжтой байгаа нь Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлж байгаа эсэхэд эргэлзэх үндэслэл болж байна. Иймд хурдан морь унаач хүүхдийн асуудлаар

сонирхогч талууд зөвшилцөн нэгдсэн байр суурьд хүрч, тусгайлсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай тулгараад байна.

Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг авч үзвэл хөдөлмөрт өртөх эрсдэлтэй хүүхдүүд үндсэндээ ядуу амьдралтай айлын хүүхдүүд байх бөгөөд ядуурлаас шалтгаалсан архидалт, салалт, орон гэргүй тэнүүчлэл зэргээс шалтгаалж хөдөлмөр эрхлэх нь нийтлэг байгаа бол нөгөө талаас ядуу биш амьдралтай боловч эцэг, эх, харгалзан дэмжигчийн анхаарал, хяналт дутуу тавих, орхиж явах, өрх толгойлуулж амьдруулах зэрэг үл хайхралтаас болж голчлон гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирох, хар тамхи, мансууруулах бодист донтох, архи, тамхи зэрэг хорт зуршилд авах, биеэ үнэлэлт, садар самуунд уруу татагдах байдлаар хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөж байна.

Хүүхэд нь эрх зүйн этгээд мөн боловч хөдөлмөрийн харилцаанд оролцохдоо эрх зүйн бүрэн чадамжгүй буюу бие даан гэрээ, хэлцэл байгуулах эрхгүй учир ихэвчлэн албан ёсны гэрээ, хэлцэлгүйгээр ажилд орж, хөдөлмөрийн харилцаанд эрхээ хамгаалж чадахгүй болдог нөхцөл байдал нийтлэг байна. Ялангуяа өмнө нь ажил, хөдөлмөр эрхэлж байсан туршлагагүйн улмаас гэрээ, хэлцэл байгуулсан ч учирч болох эрсдэлийг тооцоолон өөрт ашигтай байдлаар тохиролцох, учирсан хохирол, гэм хорыг нөхөн төлүүлэхээр шаардах чадваргүйн улмаас ажил олгогчийн хууль, гэрээ зөрчсөн үйлдлийг эсэргүүцэхгүйгээр хүнд, хортой, аюултай нөхцөлд дуулгавартайгаар ажиллаж эрхээ зөрчүүлэх, санхүүгээр хохирох, биеийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, гэмтэж бэртэх, ёс зүйн доройтолд орох, цаашилбал боолчлол, гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох тохиолдол гарч байна.

Түүнчлэн хэт олон цагаар эсвэл олон өдрөөр ажиллах, ажлын байранд хийх ажил болон гүйцэтгэх нөхцөл тодорхойгүй байх, цалингүй эсвэл бага цалинтай ажиллах, цалингаа үндэслэлгүй хасуулах, цалин хөлсөө эцэг, эх, асран хамгаалагч болон зуучлагч зэрэг бусад этгээдэд суутгуулах эсвэл шууд өгөх, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй байх, боловсролын үйлчилгээнд хамрагдахгүй, нийгмийн амьдралаас тусгаарлагдсан нөхцөлд ажил, хөдөлмөр эрхлэх зэрэг боолчлолын шинжтэй нөхцөлүүд хүүхдийн хөдөлмөрийн харилцаанд тулгарах нь элбэг байна. Хэдийгээр маш нийтлэг гэж үзэхээргүй боловч охид садар самуун, биеэ үнэлэлтэд уруу татагдах, бэлгийн мөлжлөгт өртөх, эрт жирэмслэх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь хангагдахгүй байх, бэлгийн хүчирхийлэлд өртөх, гэмт хэрэгт хохирох тохиолдол цөөнгүй, хөвгүүдийн хувьд архидалт, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, яллагдах, шийтгүүлэх, ажил, хөдөлмөр хийх явцдаа гэмтэж бэртэх, хүнд гэмтэл авах, хүнд, хортой нөхцөлд ажиллаж эрүүл мэнд, ёс суртахуунаараа

хохирох нь тулгамдсан асуудал болоод байна.

Олон улсын байгууллагаас гаргасан хэм хэмжээ, жишиг болон шалгуур үзүүлэлтүүдээр хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэх болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцох цагийн хязгаарыг тогтоосон байдаг. Гэвч хүүхэд ажил, хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ гэрийн ажилд багагүй цагийг зарцуулж, өөрийн гэрээс гадна бусад айлд гэрийн ажил хийх, түүнчлэн насанд хүрсэн хүний ажил, хөдөлмөрт цалин хөлсгүйгээр тусалцаа үзүүлэх байдлаар өдөр хоногийг завгүй өнгөрөөж сурч боловсрох, амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, насныхаа онцлогт тохирсон тоглоом болон наадамд оролцох, соёлын амьдрал, урлан бүтээх үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох эрхээ эдэлж чадахгүй байдалтай байна.

Хурдан морь унаач хүүхдүүдийн хийдэг ажилд мориноос унан бэртэж гэмтдэг, загнуулах, зодуулах, бусад байдлаар шийтгүүлэх зэргээр бие бялдар, сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг, архи, тамхи зэрэг хот зуршилд автах эрсдэлтэй, хараалын үг хэлэх, нийгмээс тусгаарлагдан найз нөхөдгүй болох зэргээр ёс суртахууны доголдолтой болдог зэрэг хүүхдийн хөдөлмөрийн аюултай бүх шинж илэрч байна. Цаашилбал унаач хүүхдүүд насандаа тохирохгүй хэт олон цагаар ажилладаг, ямар ч зав чөлөөгүй морины ажил хийдэг боловч уяачид цалин хөлсийг нь эцэг, эх, асран хамгаалагчид шууд өгдөг, цалингаа өөрөө авсан ч гэрийнхэндээ зарцуулдаг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй цалингаар ажилладаг, нийгмийн хамгаалал, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжгүй болдог.

Судалгааны санал, зөвлөмж

Монгол Улс олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн хүүхдийн хөдөлмөрийг хориглох, устгах үүрэг, амлалтуудаа бүрэн биелүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэхүү судалгааны үр дүнг үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар:

1. Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний 82 дахь хэсэгт “2012-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнд тулгуурлан шинэчлэн батлах” гэсний дагуу хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан боловсруулж, батлах;
2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, хориглох чиглэлээр батлан мөрдүүлж буй бодлогын баримт бичиг, хөтөлбөр, арга хэмжээг боловсруулахдаа хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээг тодорхой тусгах;
3. Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичигт хүүхдийг тэвчишгүй хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн хөдөлмөрөөс хүүхдийг хөндийрүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээ маш бага тусгагдаж байгаа нь урьд баталж хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээнээс харагдаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хүүхдийг тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлсэн этгээдэд оногдуулах ял, шийтгэлийн зохицуулалтыг тодорхой хэмжээнд тусгасан боловч энэ төрлийн гэмт хэргийг бууруулах, зогсооход шаардлагатай хамгийн том нөлөөлөл бол урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажиллагаа юм. Иймд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цаашид хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
4. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэх нэр томъёонд “тэвчишгүй хөдөлмөрт өртсөн хүүхэд” гэж нэмж тусгах;
5. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 84 дүгээр зүйлд “13-15 насны хүүхдийн ажиллах цагийн хязгаар”-ын талаар нэмж тусгах;
6. Циркийн үзүүлбэр, уран нугаралт, акробат зэрэг урлаг, спортын үзүүлбэрийг хүүхдээр хийлгэхэд хөдөлмөр, хамгаалал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажлын байрны нөхцөл, шаардлагыг тодорхойлох;

7. Эрүүгийн хуульд “өрийн төлөөс, хамжлагын албат” болгох үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулахаар нэмж тусгах;
8. Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд “Насанд хүрээгүй хүнийг албадан хөдөлмөрлүүлсэн” үйлдлийг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулж, оногдуулах ял, шийтгэлийг чангатгах;
9. Дайны байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлд “Дайны байдлын үед цэргийн дайчилгаанд 18 нас хүрээгүй хүүхдийг оролцуулахгүй байх” талаар нэмж тусгах;
10. Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн...” гэсний дараа “, биеэ үнэлэхэд зуучилсан” гэж нэмж тусгах;
11. Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд “энэ гэмт хэргийг үйлдэхдээ насанд хүрээгүй хүүхдийг ашигласан, татан оролцуулсан” гэж нэмж тусгах;
12. Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол...” гэсний “зориуд” гэснийг хасах;
13. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил олгогчийн байранд хашигдан хийх ажил”-ыг хориглох заалтыг нэмж тусгах;
14. Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд хүүхдийг хуульд зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмж тусгах;
15. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад техник, технологийн дэвшил, хурдацтай хөгжиж буй өнөө үетэй нийцүүлэн “хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил болон хүүхдийн сэтгэхүй, ёс суртахуунд нөлөөлөхүйц ажлыг нэмж тусгах;
16. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр оршиж байгаа газрыг тогтоох, олон нийтийн болон төрийн захиргааны байгууллагын хяналт, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сайжруулах;

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй, аюултай хэлбэрийг хориглох,

устгах талаар:

1. ГБХЗХГ-ын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн сангийн мэдээлэл цуглуулах аргачлалыг аймаг, орон нутаг бүрд нэг ижил мөрдүүлж, судалгаанд үндэслэлтэй, бодит мэдээллээр хангах;
2. ГБХЗХГ-ын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн санд хуулиар зөвшөөрсөн хэлбэрийн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тухай мэдээллийг оруулдаг болох;
3. Хөдөлмөрт өртөх эрсдэлтэй хүүхдийн тухай мэдээллийн санг хөтлөх чиг үүргийг холбогдох байгууллагуудад хуулиар хүлээлгэх;
4. Техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллагад хүүхдүүдийг дадлага хийлгэх нэрээр хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлж байх магадлалтай байгаа тул энэ асуудлыг хянах, шалгах чиглэлээр судалгаа хийж холбогдох байгууллагууд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
5. Ажил, хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ гэрийн ажил, өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй ажиллаж байгаа хүүхдийн хувьд эдгээрт зарцуулах нийт цаг тухайн хүүхдийн настай харьцуулахад хэт их байгаа тохиолдлыг хянаж, шалгах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж хэвшүүлэх;
6. Эцэг, эхийнхээ өрийг төлөх, орон гэрийн түрээсийг төлөхийн тулд цалин хөлсөө зарцуулж эсвэл цалин хөлсгүйгээр хамжлагын хэлбэрээр ажил, хөдөлмөр хийж байгаа хүүхдийг тусгайлан илрүүлж зохицуулах арга хэмжээ авах;
7. Хүүхэд ажиллаж байгаа газраа орхиж явах эрхгүй, боломжгүй болох, бусдын дарамт, шахалтаас болж хүсээгүй байхдаа ажил, хөдөлмөр эрхлэх нөхцөлд хүрсэн тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гэж үзэж хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хууль тогтоомжид нэмж тусган, хүүхэд бусадтай харилцах, холбогдох боломж хязгаарлагдмал ажилладаг байгууллага, ажлын байранд тогтмол хяналт, шалгалт хийж хэвшүүлэх;
8. ОУХБ-аас гаргасан хөдөлмөрийн мөлжлөгийн 9 шалгуур үзүүлэлтийн дагуу ажил эрхэлж байгаа хүүхдийн ажиллах нөхцөл, ажил гүйцэтгэх үйл явцад хөдөлмөрийн мөлжлөгийн шинж чанар байгаа эсэхийг шалгаж шийдвэрлэх талаар удирдамж, зааврыг хүүхдийн эрхийн улсын байцаагч, хөдөлмөрийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагын холбогдох алба хаагчдад хэвлүүлэн өгч, шаардлагатай сургалтыг тогтмол зохион байгуулж байх;
9. Ажил, хөдөлмөр эрхлэлтэд өртөх эрсдэлтэй хүүхдүүдэд ажлын байрны дарамт, хүчирхийлэл болон ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан

- сэргийлэхтэй холбоотой заавар, зөвлөмжийг тогтмол хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
10. Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд нь ажил, хөдөлмөр эрхлэлтэд өртөх, ёс суртахууны доголдолтой болох, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирох, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодист донтох өндөр эрсдэлтэй болохыг анхаарч хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;
 11. Хүүхэд ажил, хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд гадаа ажилладаг, хүнд ачаа өргөж, зөөдөг, уртасгасан, шөнийн цагаар ажиллуулах зөрчил бүх төрлийн ажилд нийтлэг байгааг анхаарч төрийн алба хаагч, эцэг, эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгчид, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагууд зэрэг бүх талын оролцоотойгоор хяналтыг сайжруулах;
 12. Хориглосон ажлын байр, хориглосон хөдөлмөрийн нөхцөлд насанд хүрээгүй хүнийг ажиллуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах;
 13. Ажил, хөдөлмөр эрхэлтэд өртсөн хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээний талаар холбогдох байгууллагуудад сургалт, мэдээллийн ажлыг тогтмол зохион байгуулах;
 14. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан “урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаа” гэснийг хэрхэн ойлгох талаар хуулийн тайлбар хийж хууль хэрэглээнд нэг мөр ойлголтыг бий болгох;
 15. Ажил, хөдөлмөр эрхэлж цалин хөлс авч байгаа хүүхдийг нийгмийн даатгалд хамруулах эрх зүйн болон төрийн үйлчилгээний тогтолцоог нарийвчлан тодорхойлж ач холбогдлыг нийтэд таниулан сурталчлах;

Хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй, аюултай хэлбэрийг хориглох, устгах талаар:

1. Уяач нь хурдан морь унаач хүүхэд, түүний эцэг эхтэй 3 талт гэрээг заавал байгуулдаг байхаар зохицуулах;
2. Хууль тогтоомж болон дээр дурдсан гэрээгээр унаач хүүхдийн хөдөлмөрийн нөхцөлийг нарийвчлан тодорхойлох;
3. Унаач хүүхдийн жишиг цалинг насны ангиллаар тодорхойлж тогтоох;
4. Унаач хүүхдийн цалингийн зарцуулалтыг хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
5. Боловсролын үйлчилгээнд хамрагдах талаар уяач болон эцэг, эх, асран

хамгаалагчид тодорхой үүрэг хүлээлгэх, энэ үүргээ зөрчсөн тохиолдолд эрүүгийн болон зөрчлийн хуулиар шийтгэл хүлээлгэх зохицуулалт тусгах;

6. Унаач хүүхдийн хамгаалах хэрэгслийн чанарыг сайжруулах, холбогдох стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах. Тухайлбал өвлийн улиралд каскны дотор өвлийн малгай өмсөх боломжтой байх, каскны оосор хүүхдийн хоолойгоор боохгүй, татахгүй байх, түүнчлэн каскаа авч, морь үргээхэд ашиглах боломжгүй болгох, комбинзоны чанарыг тодорхойлох, гутлын шаардлагыг тусгайлан тогтоох, стандартчилах;
7. Бүрэн хамгаалах хэрэгсэлтэйгээ барианд ирсэн эсэхэд шалгуур тавьж Үндэсний их баяр наадмын морин уралдааны дүрэм, Монголын хурдан морины уралдааны дүрэмд тодорхойлж заах;
8. Үсэргээ, сунгаа, морины ажлыг өвөл хүүхдээр хийлгүүлж байгаа асуудлыг нарийвчлан судалж, эрх зүйд зохицуулалтыг бий болгох;
9. Унаач хүүхдээс гадна “Уяачийн туслах” гэх ажил, хөдөлмөр эрхэлж байгаа 18 нас хүрээгүй хүний эрхэлж байгаа ажлын онцлог, аюул занал, хөдөлмөрийн нөхцөлийн талаар тусад нь судалгаа хийж, дүгнэлт хийх.



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг
хориглосон ажлын байрны жагсаалт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 142 дугаар зүйлийн 142.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Уг тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

151201581

D: 2022 on 05 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2022 оны 16-дугаар сарын 12-ны өдрийн
1/122 дугаар тушаалын зааврал



Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт

Нэг.Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон хөдөлмөрийн нөхцөл

1.1.“Хөдөлмөрийн нөхцөл” Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг хэлэх бөгөөд хүүхдийн бие, физиологийн хүчин чадлаас хэтэрсэн хүчин чармайлт шаардах, эсхүл хүүхдийн амь нас, бие махбодид аюул учруулах, эсхүл хүүхдийн бие махбод, оюун ухаан, сэтгэлзүйн хөгжилд саад учруулахуйц ажлын хэлбэр, тухайн ажлыг гүйцэтгэх байршил багтана.

1.2.Хүүхдийн хөдөлмөрт албадлага, хүч хэрэглээнд тооцох нөхцөл:

- 1.2.1.ажил олгогчийн мэдлийн байранд хорих;
- 1.2.2.эцэг, эхээсээ хол байрлаж, хоноглож ажиллах нөхцөл үүсгэх;
- 1.2.3.ажлын байрнаас гадуур бусадтай харилцах боломжгүй байх эсхүл хориглох;
- 1.2.4.ажил олгогч нь хүүхдийн баримт бичгийг барьцаалж, ажилтанд өгөхгүй байх;
- 1.2.5.эцэг, эх, харгалзан дэмжигч болон бусад хүмүүсийн өрийн барьцаа, төлөөсөнд ажил олгогчид ажиллах;
- 1.2.6.ямар нэгэн хариуцлага хүлээлгэхээр айлган сүрдүүлэх;
- 1.2.7.залилан эсхүл хуурч мэхлэх замаар ажиллуулах.
- 1.3.Хүүхдийн ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх ажил:
 - 1.3.1.бооцоот уралдаан, интернет мөрийтэй тоглоом зэрэг мөрийцэх, бооцоо тавих бүх төрлийн ажил;
 - 1.3.2.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдах зэрэг бүх төрлийн хууль бус ажил, үйл ажиллагаа;
 - 1.3.3.эротик үзүүлбэртэй холбоотой ажил эсхүл эротик үзүүлбэр үзүүлдэг газар ажиллах;
 - 1.3.4.согтууруулах ундаа бэлтгэдэг, худалдаалдаг, түүгээр үйлчилдэг ажил;
 - 1.3.5.хууль ёсоор болон хууль бусаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд (үүнд янжуур тамхи багтана) бодис тариалах, хураах, бэлтгэх, худалдаалах, түгээхтэй холбоотой ажил.

1.4.Хүүхдийг хүчирхийлэлд өртүүлэх магадлалтай ажил:

- 1.4.1.гэр бүл, хамт амьдардаг хүмүүсээс нь тусгаарлан, хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаа эсэхийг хянах боломжгүй ажил;
- 1.4.2.харуул хамгаалалт зэрэг зэвсэг хэрэглэх, зөөх, хүч хэрэглэх шаардлага гарах ажил.

1.5.Хорт бодист хүүхэд хордох эрсдэлтэй ажил:

1.5.1.хавдар үүсгэгч, үр удамд сөрөг нөлөөтэй, нөхөн үржихүйн эрхтэнг хордуулах эрсдэлтэй ажил;

1.5.2.барилга зэрэг асбест агуулсан материалтай харьцах ажил;

1.5.3.химийн уусгагч, будагч бодис хэрэглэдэг ажил;

1.5.4.удаан задардаг органик (POPs), тогтвортой органик бохирдуулагч (POPs), тодорхой төрлийн песцитит ашиглах ажил;

1.5.5.хар тугалга, мөнгөн ус, хүнцэл, никель, берилли, бусад хортой металл ашиглах ажил;

1.5.6.ажлын байрны химийн сөрөг хүчин зүйлс, хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний 50 хувиас илүү өртөлт бүхий ажил.

1.6.Хүүхдийн аюулгүй байдалд аюул учруулах ажил:

1.6.1.газрын түвшнээс 2 метрээс илүү өндөрт дээвэр, тавцан, тагт, цонх, мод зэрэг дээр ажиллах;

1.6.2.цахилгаан, хийгээр ажиллах машин тоног төхөөрөмж (цахилгаан хөрөө, өрөм гэх мэт)-тэй харьцаж ажиллах;

1.6.3.галд шатах, дэлбэрэх аюултай бодистой харьцаж ажиллах;

1.6.4.хязгаарлагдмал орчинд ажиллах (үйлдвэрлэлийн зориулалттай хөргүүр гэх мэт);

1.6.5.цахилгаан үүсгүүр, цахилгаан утастай ажиллах, цахилгаанд цохиулах эрсдэлтэй ажил.

1.7.Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй физикийн хүчин зүйлсэд өртөх эрсдэлтэй ажил:

1.7.1.өндөр хурдтайгаар эргэлдэх болон тууш, долгионт хөдөлгөөн бүхий тоног төхөөрөмж, тухайлбал туузан дамжлага, өрмийн машин дээр гүйцэтгэх зэрэг ажил;

1.7.2.ажлын зааварчилгаа сонсох боломжгүй их дуу чимээтэй ажил;

1.7.3.радиацтай холбоотой ажил;

1.7.4.хэт халуун, хүйтэн цаг агаарын нөхцөлд олон цагаар ажиллах;

1.7.5.ажлын байрны физикийн сөрөг хүчин зүйлс хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний 50 хувиас илүү өртөлт бүхий ажил.

1.8.Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй биологийн аюулд өртөх эрсдэлтэй ажил:

1.8.1.мал амьтны дайралтад өртөх магадлалтай (мал үржүүлгийн үйл ажиллагааны явцад);

1.8.2.өвчтэй мал, шумуул зэрэг амьтдаас зоонозын гаралтай вирус, бактери, паразитын халдвар авах магадлалтай;

1.8.3.үхсэн малын сэг, зэмтэй харьцаж ажиллах;

1.8.4.эмгэг төрүүлэх нөлөөтэй бактери, вирус зэрэг биологийн аюултай хүчин зүйлсийн нөлөөлөлд өртөх эрсдэлтэй.

1.9.Хүүхдэд эргономикийн аюул үүсгэх ажил:

1.9.1. Өргөх зөөх ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ:

гараар - 16 нас хүртэлх /эрэгтэй хүүхэд 8 кг, эмэгтэй 5 кг/;

1.9.2.олон давтагдах эсхүл хүчилсэн хөдөлгөөн шаардах ажил.

Хоёр.Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажил мэргэжил

Салбар, дэд салбар	Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажил мэргэжил	Аюул	Тайлбар
2.1.Хөдөө аж ахуй			
2.1.1.Хөдөө ахуйн үйлдвэрлэл	2.1.1.1.тариалах, газар хагалах, ургац хураах ажлыг механикжсан өөрөө явагч тоног төхөөрөмжөөр гүйцэтгэх 2.1.1.2.химийн бордоо, пестицит ашиглах, химийн хорт болон аюулт бодис, тэдгээртэй харьцах бүх төрлийн ажил 2.1.1.3.мод мөчирлөх, талбайгаас жимс хураах	-хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжүүд (хадагч, комбайн гэх мэт)-ийн хурдан хөдөлгөөнт эд ангиудад гар, бие хавчуулагдах аюултай. -трактор болон бусад хөдөлгүүрт төхөөрөмжүүд эгц, хэвгий газар онхолдох магадлалтай. -химийн бордоо, пестицитийг ургацын хэмжээг нэмэгдүүлэх өргөн ашигладаг. -жимсний өндөр модноос ургэц хураах, мод мөчирлөх үед өндрөөс унах эрсдэлтэй. -хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хураах үед хүнд ачаа өргөж, зөөдөг. (биеийн жингийн 20 ба түүнээс илүү) -насанд хүрээгүй хүн зохих сургалтанд хамрагдаагүй, хяналт сул байдгаас осол, гэмтэлд өртдөг. -улирлын шинжтэй түр ажил хүүхэд эрхлэх үед цалин хөлс бага, эрүүл мэндийн үйлчилгээ авч чаддаггүй.	Насанд хүрээгүй ажилтанд хүнд машин механизм ажиллуулах талаар мэдлэг, дадлага туршлага байхгүйгээс гэмтэх, хурц хордлогод өртөх эрсдэлтэй.

2.1.2.Мал аж ахуйн үйлдвэрлэл	2.1.2.1.том хэмжээний хязгаарлагдмал орчинд ажиллах (амбаар, пин, малын тэжээлийн талбай гэх мэт) 2.1.2.2.амьтан сургах, эмнэг сургах 2.1.2.3.өвчтэй эсхүл үхсэн мал, амьтантай харьцах 2.1.2.4.мал үржүүлэг, хөнгөлөх, мал хээлтүүлгийн ажил 2.1.2.5.мал нядлах, мал нядлахад бэлтгэх ажил 2.1.2.6.өөс хадах, боох 2.1.2.7.мал эмнэлгийн төрөл бүрийн ажил үйлчилгээ 2.1.2.8.техник, тоног төхөөрөмжтэй ажиллах 2.1.2.9.зөгий үржүүлэгч 2.1.2.10.шувуун аж ахуйн ажилтан 2.1.2.11.Цаг уурын тохиромжгүй, онц аюултай үзэгдэл бүхий нөхцөлд мал хариулах, оторлох, тууварлах	-амьсгал боогдох, гацах, живэх, малын тэжээлийн тоног төхөөрөмжид (өрөм, тэжээлийн худаг, хоолойд) хавчуулагдах, хог хаягдал зайлуулах (малын өтөг, бууц хадгалах худаг) худагт унах -бэлчээрийн бус маллагаатай мал, амьтны өвчнөөс сэргийлэх, хянах зорилгоор хэрэглэж байгаа хортой бодисын хордлогод өртөх -мал амьтнаас хүнд халдах үүсгэгчээс халдвар авах -малд өшиглүүлэх, мөргүүлэх зэрэг шалтгаанаар гэмтэх -гэр бүлээсээ хол, тусдаа ажиллаж амьдарснаас сэтгэлзүйн стресс үүсэх -ажлын талбайд бүтэн болон бүтэн бус цагаар ажиллаж, бие, сэтгэл зүйн хүчирхийлэл, үл хайхрах байдлаас үүсэх эрсдэл	Мал аж ахуйг үйлдвэрлэлийн зориулалтаар өсгөх орчин үеийн мал маллагааны хэлбэр нь олон тооны мал сүргийг хязгаарлагдмал орчинд амбаар, пин, малын тэжээлийн талбайг ашиглаж байна. Уламжлалт мал маллагааны хэлбэр нь ажиглалт, шууд зааварчилгааны үндсэн дээр ур чадвараа хуваалцах байдалд тулгуурладаг бол орчин үеийн мал аж ахуйн үйлдвэрлэлд бүрэн дадлагажсан, насанд хүрсэн хүн ажиллах шаардлагатай.
2.1.3.Ан агнуур	2.1.3.1.буу зэвсэг ашиглах 2.1.3.2.галт зэвсэг, сум хадгалах, зөөвөрлөх 2.1.3.3.насанд хүрсэн анчинд тусалж тор, урхи тавих, өгөөш бэлтгэх 2.1.3.4.Хортон шавьж устгагч 2.1.3.5.Сүхээр мод мөчирлөгч	-буу зэвсэгтэй шууд эсхүл тэдгээртэй ойр ажиллах нь санамсаргүй байдлаар сум алдаж гэмтэх эрсдэлтэй. -насанд хүрсэн хүмүүсээс буруу үлгэр дуурайлал авах эрсдэл (архи уух гэх мэт) - олон цаг, удаан хугацаагаар цаг агаар, халуун хүйтэнд тасралтгүй ажиллах шаардлагын улмаас бие физиологийн ачаалал үүсэх эрсдэл	Ан агнуур нь уламжлалт ажил мэргэжил боловч орчин үед хүчин чадал өндөртэй галт зэвсэг хэрэглэдэг тул насанд хүрсэн хүн, албан ёсны сургалтанд хамрагдсанаар ажиллах шаардлагатай.
2.1.4.Ойн бүх төрлийн үйл ажиллагаа	2.1.4.1.цахилгаан хөрөөгөөр мод бэлтгэх 2.1.4.2.мод, мөчир тээвэрлэх, зөөх 2.1.4.3.мод боловсруулах үйлдвэрт ажиллах 2.1.4.4.ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх, ойн дагалт баялаг бэлтгэх үйл ажиллагаа	-унаж байгаа модонд дарагдах, машин хөмрөх, ачаа гулгах, мод мөчир өнхрөхөөс үүсэх эрсдэл -цахилгаан хөрөөтэй ажиллах үед үүсэх зүсэгдэх, гэмтэх эрсдэл -алс бөглүү нөхцөлд ажиллаж байгаагаас гэмтэж бэртсэн нөхцөлд хүндрэх эрсдэл	Ойн аж ахуйн үйл ажиллагаанд трактор, өндөр хүчин чадалтай цахилгаан хөрөө, өргүүр зэрэг хүнд машин механизм хэрэглэдэг тул ажилтны хувьд аюултай мэргэжилд тооцогддог.
2.1.5.Загас агнуур	2.1.5.1.гүн усанд загас агнуур хийх 2.1.5.2.загас спорт агнуурын хөтөч, туслах	-загасчлах үед гүн усанд живэх эрсдэл (аж ахуйн болон спорт загасчлал)	Арилжааны шинж чанартай загасчлах үйл ажиллагаа нь

	2.1.5.3.завь засах, цэвэрлэх 2.1.5.4.завь, усан онгоцны хөдөлгүүр, ус нэвтрүүлдэггүй хэсэг зэрэг хязгаарлагдмал орчинд ажиллах	-хөтөчийн ажил нь хүүхэд ажиллах боломжгүй хариуцлага өндөртэй ажил мэргэжил -агааржуулалт муутай байх, хөдөлгүүрээс гарах утаанд өртөх -шатамхай, дэлбэрэх аюултай бодисын эрсдэл (шатахуун, моторын тосолгооны материал) -цэвэрлэгээний хортой материалтай харьцаж ажилласнаас үүсэх арьсны гэмтэл (цайруулагч, ариутгалын бодис) -цаг агаарын тааламжгүй нөхцөл, наранд цохиулах эрсдэл	хөдөлмөрийн хортой нөхцөлд, уртасгасан цагаар тасралтгүй, цаг агаарын тааламжгүй нөхцөлд явагддаг тул насанд хүрсэн хүн ажиллах боломжтой.
2.1.6.Уул уурхай, олборлолт			
	2.1.6.1.нүүрс, эрдэс, төмөрлөгийн хүдэр, уран, алт болон үнэт металл олборлох гүний уурхай 2.1.6.2.нүүрс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн гадаргаас олборлох 2.1.6.3.чулуу, элс, давс малтах, олборлох 2.1.6.4.олборлосон уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх 2.1.6.5.газрын тос, байгалийн хий, түүхий тос олборлох 2.1.6.6.бүх төрлийн үнэт металл гар аргаар олборлох үйл ажиллагаа	-уул уурхайн талбай эсхүл гар аргаар олборлолтын үед хөрс гулгах, газар цөмрөлтөөс шалтгаалан уурхайн болон уурхайн үйл ажиллагаанд шууд оролцоогүй ажил мэргэжлийн ажилтнууд ч гэмтэх, нас барах аюултай. - уурхайн тээсэлгээнээс шалтгаалан сонсгол буурах эрсдэлтэй. -түүхий эд материалыг ачиж буулгах, зөөх ажил нь яс булчингийн ачаалал үүсгэж, гэмтэл үүсэх эрсдэлтэй. -хүйтэн ус, цаг уурын хүйтэн нөхцөлд биеийн дулаан буурах эрсдэлтэй. -гар, хөл дээр чулуу унаж, физик гэмтэл үүсэх эрсдэл - хүдэр ялгахад хэрэглэдэг мөнгөн ус болон бусад бодисууд мэдрэлд хортой нөлөө үзүүлдэг.	Уул уурхайн талбай эсхүл гар аргаар олборлолтын үед малтлага, өрөмдлөг хийх зэрэг ажилд хүч их гаргах шаардлагатай болно. Овор ихтэй, хүнд жинтэй материалтай харьцахад биеийн хүч шаардлагатай тул хүүхдэд хүндрэлтэй.
2.1.7.Барилга			

	2.1.7.1.барилга буулгах, нураах бүх төрлийн үйл ажиллагаа 2.1.7.2.барилга барих, засварлах 2.1.7.3.цахилгааны ажил 2.1.7.4.өнгөлөх, зүлгэх багаж хэрэгсэл ашиглах ажил 2.1.7.5.өрлөг 2.1.7.6.чулуун хавтан зүсэх, бутлах 2.1.7.7.цемент зуурах, холих, өнгөлөх 2.1.7.8.гагнах, давтах, металл боловсруулах 2.1.7.9.барилгын материал тээвэрлэх 2.1.7.10.дээвэрлэх 2.1.7.11.будачин, барилгын бүтээц цэвэрлэгч, түүнтэй адилтгах бусад ажил 2.1.7.12.барилга угсрах үйлдвэрт зуурмаг бэлтгэх, үйлдвэрлэлийн бус орчинд цемент задгайгаар савлах ажил	-барилгын шат, гишгүүрээс унах, түр хамгаалалт хийсэн үед хана, тавцан, дээвэрээс унах, бэртэх -өндөрөөс унаж, нурж байгаа биет, кран, эд зүйлд цохиулах байнгын эрсдэл үүсдэг. -дадлага, туршлагагүйгээс цахилгаанд цохиулах, гагнуур хийх, сантехникийн ажлын үед нүд гэмтэх, түлэгдэх эрсдэл -цахилгаан, хийгээр ажилладаг хөрөө, өрөм зэрэг мужааны тоног төхөөрөмж ашиглах үед цахилгаанд цохиулах, зүсэгдэх эрсдэлтэй. -хүнд материалыг өргөх, түлхэх, зөөхөд яс булчингийн гэмтэл үүсэх эрсдэлтэй.	Барилга барих, засварлах ажилд өндөр үр чадвартай ажилтан нарийн тоног төхөөрөмжтэй харьцах шаардлагатай. Техник тоног төхөөрөмж, аюултай ажлын нөхцөлөөс шалтгаалан ажлын байран дээрээ дадлагажин, "туслах" нэрээр албан мэргэжлийн боловсрол, сургалтгүйгээр ажиллах боломжгүй.
	2.1.8.Боловсруулах үйлдвэрлэл 2.1.8.1.20 ба түүнээс дээш ажилтантай үйлдвэрийн дамжлагын ажил 2.1.8.2.тоосго цохих 2.1.8.3.арьс, шир идээлэх, хатаах 2.1.8.4.тамхины үйлдвэрлэл 2.1.8.5.архи, пиво, ундааны үйлдвэрлэл 2.1.8.6.резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1.8.7.машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ 2.1.8.8.бүх төрлийн суурилагдсан болон механикжсан тоног төхөөрөмжүүд, технологийн зориулалттай болон ердийн машин механизмууд, байнгын гар ажиллагаатай тоног	-тасралтгүй, хурдан ажиллах дамжлагын ажилд физиологийн хувьд стресс үүсэх, нэг төрлийн байнга давтагдах ажилд оюун санааны хувьд залхах зэргээр хүүхдүүдэд өвөрмөц эрсдэл үүсдэг. -овдлын үйлдвэрлэлийн өндөр тоосжилттой нөхцөлд удаан ажилласнаас шалтгаалан амьсгалын замын өвчлөл үүснэ. -арьс идээлэх, хатаахад ашигладаг химийн хорт бодист хордох эрсдэл үүснэ. -чулуу зүсэх бутлах, тоосго цохих зэрэг тоосжилттой орчноос шалтгаалан уушиг тоосжих эрсдэл үүснэ. -босоо байдлаар олон цагаар ажилласнаар яс булчингийн гэмтэл үүсдэг.	Үйлдвэрлэлийн процесст ашигладаг багаж тоног төхөөрөмж, түүхий эд материалаас шалтгаалан эрсдэл үүснэ.

төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн дамжлагын бүх төрлийн ажил: 2.1.8.9.Нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл 2.1.8.10.арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2.1.8.11.цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1.8.12.хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа 2.1.8.13.кокс болон газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1.8.14.хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1.8.15.эм, эм бэлдмэл, химийн болон ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1.8.16.төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 2.1.8.17.металл үйлдвэрлэл 2.1.8.18.машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1.8.19.компьютер, электроник болон хараа зүйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1.8.20.цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 2.1.8.21.дээрх дэд салбарт ороогүй бусад машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 2.1.8.22.моторт авто тээврийн хэрэгсэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл		
---	--	--

	2.1.8.23.тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл 2.1.8.24.машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ		
2.1.9.Ус хангамж, хог хаягдлын менежменттэй холбоотой үйл ажиллагаа			
	2.1.9.1.хот доторх хог хаягдал цуглуулах 2.1.9.2.хог хаягдал цуглуулах, боловсруулах, ангилах, цэвэрлэх, дахин боловсруулах 2.1.9.3.хог хаягдал шатаах, булшлах, устгах үйл ажиллагаа 2.1.9.4.бохир ус хуримтлуулах, цэвэрлэх, ариутгах 2.1.9.5.өрх, ахуйн хэрэглээний ус тээвэрлэх	-хэрэглэсэн тариур зэрэг эмнэлгийн аюултай хог хаягдлаас өвчин үүсгэгчээр дамжуулан халдварлах -хурц ирмэгтэй металл зүйлс, хагарсан шил зэрэгт зүсэгдэх өндөр эрсдэлтэй -гэмтлийн үед авсан шархаар дамжин татран зэрэг халдварт өвчин тусах эрсдэл өндөр -хог хаягдал цуглуулах үед хүнд машин механизмд мөргүүлэх аюултай. -бохир ус ариутгах, цэвэрлэхэд ашигладаг химийн хорт бодист хордож амьсгалын замын болон арьсны өвчлөл үүсэх -хүнд хог хаягдал өргөх зөөх үед яс булчинд ачаалал үүсэх эрсдэлтэй. -хог хаягдалтай ажиллахад нийгэм сэтгэлзүйн хувьд дорд үзэгддэг.	
2.1.10.Гэр ахуйн болон эрүүл мэндийн сувилгаа, үйлчилгээ			
	2.1.10.1.асрах газар, эмнэлэг зэрэгт өвчтөнтэй шууд харилцах ажил 2.1.10.2.гэрт нь байрлах гэрийн үйлчилгээний ажилтан, үйлчлэгч, хүүхэд асрагч 2.1.10.3.массаж болон түүнтэй адилтгах хувь хүнд үзүүлэх бусад үйлчилгээ /бэлгийн мөлжлөгт өртөх магадлалтай/	-өвчлөл, нас баралтыг бодитоор харсанаар хүүхдүүдэд дараа нь даван туулахад төвөгтэй сэтгэлзүйн дарамт үүсгэдэг. -өвчтэй хүн асрах үед агаар дуслын замаар, биеийн шингэн, сувилгааны хэрэгслээр дамжин халдварт өвчин тусах эрсдэлтэй. -эмчилгээний байгууллагад үйлчилгээний ажилтнууд хүчирхийлэлд өртөх, мансууруулах бодисыг хэрэглэх зэрэг магадлалтай. -сувилгаа, асаргааны үед хүнд ачаа зөөх, шөнө ажиллах, олон цагаар ажиллах шаардлага гардаг. -олон нийтийн анхаарлаас хол асаргааны ажил эрхлэх нь нийгмээс тусгаарлагдах, хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртөх, зодуулах, сүрдүүлэгт өртөх эрсдэлтэй.	
2.1.11.Цэвэрлэгээ үйлчилгээ			
	2.1.11.1.хими цэвэрлэгээ 2.1.11.2.эмнэлгийн цэвэрлэгээ 2.1.11.3.үйлдвэрлэлийн байгууламжийн цэвэрлэгээ (рал,	-цэвэрлэгээний материал ихэнхидээ хурц ирмэгтэй байх нь гэмтэх өндөр эрсдэлтэй. -цэвэрлэгээнд ялангуяа хими цэвэрлэгээний газруудад	

	дэлбэрэлт, хорт бодис асгарсан) 2.1.11.4.барилгын талбайн цэвэрлэгээ 2.1.11.5.шарил хадгалах, оршуулгын газар	ашигладаг химийн бодисууд арьс, нүдийг гэмтээх магадлалтай, -мэргэжлийн цэвэрлэгээний газруудад хүнд, овор ихтэй, хурц ирмэгтэй, нойтон материал цуглуулах, зөөхтэй холбоотойгоор яс булчингийн системд ачаалал өгч, өвчлөл үүсгэдэг, -цэвэрлэгээний ажилтнууд бусдад дорд үзэгдэх хандлагатай, -цэвэрлэгээний ажлыг ихэвчлэн шөнийн цагаар хийдэг тул хүчирхийлэл, бэлгийн дарамтын эрсдлийг нэмэгдүүлдэг.	
2.1.12.Борлуулалт, худалдаа			
	2.1.12.1.бөөний худалдааны үйл ажиллагаа 2.1.12.2.гудамжинд бараа худалдаалах 2.1.12.3.а-худалдаа 2.1.12.4.гуйлга гуйх 2.1.12.5.авто зам дээрх худалдаа, үйлчилгээний ажил 2.1.12.6.цэнэглэгч хий болон шингэн, хийм түлшний худалдаа, үйлчилгээ 2.1.12.7.шатах, тослох материал түгээх ажил 2.1.12.8.ачаа өргөж зөөх, буулгах ажил 2.1.12.9.зах дээр тэрэг түрэх	-бөөний худалдааны төвүүдэд том тоног төхөөрөмжтэй ажиллахад үүсэх аюул -онлайн худалдааны ажил мэхлэх, аймтгай болох зэргээр хүүхдийн зан төлөвт сөргөөр нөлөөлөх боломжтой. -мөнгөтэй харилцах худалдааны ажлууд нь айлгах, хүчирхийлэл, луйвардуулах эрсдэлийг бий болгоно. -зохион байгуулалттайгаар гуйлга гуйх үйл ажиллагаанд хүүхэд оролцох нь хүчирхийлэл, дорд үзэгдэх гэх мэт зан төлөвт нь үзүүлэх эрсдэлтэй.	Бөөний худалдааны үйл ажиллагаа дэлгүүр, бөөний төв, гудамжид хийгддэг. Интернэтэд суурилсан байдлаар худалдаа хийх хэлбэр бий болж байна. Бараа, бүтээгдэхүүн худалдах нь аюултай ажил биш боловч худалдаа хаана хийж байгаагаас шалтгаалан эрсдэл үүснэ. Ажлын цаг, өргөж зөөх ачааны зөвшөөрөгдөх хэмжээ зөрчигддөг.
2.1.13. Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа			
	2.1.13.1.тээврийн туслах үйл ажиллагаа 2.1.13.2.төмөр замын ачиж буулгах ажил 2.1.13.3.нийтийн тээврийн хэрэгслийн кондуктор		

2.1.14.Энтертаймэнт			
	2.1.14.1.мэргэжлийн морин уралдаан 2.1.14.2.жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд хурдан морь унуулах 2.1.14.3.порнографийн болон биеэр үзүүлэх мэргэжлийн урлагийн үзүүлбэрт ашиглах 2.1.14.4.зочид буудал, дэн буудлын бүх төрлийн ажил 2.1.14.5.тайчих үзүүлбэр, массажийн үйлчилгээ 2.1.14.6.баар, цэнгээний газар, шөнийн клуб, сауны газарт ажиллах бүх төрлийн ажил 2.1.14.7.нохой зодооны үзүүлбэр	-дарамтаас үүсэх сэтгэл зүйн эрсдэл эдгээр үйл ажиллагааг эрхлэхэд маш их. -насанд хүрэгчдийн муу үлгэр дуурайлал хүүхдийн ёс суртахуунд нөлөөлнө (архи, мансууруулах бодис хэрэглэх, мөрийтэй тоглох). -байнга, тогтмол сургуульд хамрагдах боломжгүйгээс хүүхдийн оюун ухаанд сөрөг нөлөөтэй. -хүүхэд ажил олгогчтой сургалт, үзүүлбэрийн үед хамт амьдардагаас гэр бүлийн халамж, анхаарал суларна. -уналтаас (циркийн үзүүлбэр) болон биеийн зөгүй байрлалаас (уран нугараач) үүсэх бие махбодийн гэмтэл -биеийн жинг хянаж, хязгаарласнаас үүсэх хоол тэжээл, шингэний дутагдал, эрүүл бус хэв маяг -олон давтсан, хүнд дасгал сургуулиалтаас үүсэх гэмтэл, бэртэл -хэт хурдан давхилтаас хүнд гэмтэл үүсэх маш их эрсдэлтэй. -цаг агаарын тааламжгүй нөхцлийн нөлөөлөл (хэт халуун, хүйтэн)	Энтертеймэнтний үйл ажиллагаа нь театр, хөгжим, уран сайхны болон спортын гэх мэт олон хэв шинжтэй. Арилжааны (цалинтай хөдөлмөр эрхлэлт) болон сонирхогчийн буюу мэргэжлийн бус үйл ажиллагааг ялгаатай авч үзэх шаардлагатай. Арилжааны шинж чанартай үйл ажиллагаа нь мансууруулах бодис, мөрийтэй тоглоом, биеэ үнэлэх зэрэг хууль бус үйл ажиллагаатай холбогдсон тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн тэвшишгүй хэлбэр болно.



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

13 нас хүрсэн хүний эрхэлж болох
хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр
эрхлэлтийн нөхцөлийг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 142 дугаар зүйлийн 142.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хавсралтаар баталсугай.

2. Уг тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д даалгасугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

151201580

D: 2022 on 05 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2022 оны 10-р дугаар сарын 12-ны
өдрийн 2022/10/12 дугаар тушаалын хэвсрэлт

**13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл,
хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл**

Хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх болон хууль тогтоомж, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад зааснаас бусад төрлийн ажилд 13-15 насны хүнээр хөнгөн ажил эрхлүүлж болно.

13-15 насны хүнээр хөнгөн ажил эрхлүүлэхдээ дараах хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хангана:

1. Ажлын цаг:

1.1. Хичээлийн үед долоо хоногт 15 цагаас илүүгүй хугацаагаар буюу долоо хоногт өдөрт 2 цаг, нийтдээ 10 цаг; гэр ахуйн ажилд өдөрт 1 цаг, долоо хоногт нийтдээ 5 цаг хүртэл ажиллуулж болно.

1.2. Хичээлийн улирлын амралтын үед долоо хоногт 20 цагаас илүүгүй хугацаагаар буюу даваагаас баасан гарагт өдөрт 2 цаг эсхүл долоо хоногийн амралтын өдөр 2 цаг; гэр ахуйн ажилд долоо хоногт 8 цаг хүртэл ажиллуулж болно.

2. Хичээлийн болон хичээлийн улирлын амралтаас үл хамааран 13-15 насны хүнийг оройн 18 цагаас өглөөний 06 цагийн хооронд ажиллуулахгүй.

3. Хөнгөн ажил хийх тасралтгүй ажлын цагийн үргэлжлэлийн явцад тогтмол хугацаанд завсарлуулна. Завсарлагын хугацаанд 13-15 насны хүнийг түр амрах, ус уух, бие засах зэрэг нөхцөлөөр хангана.

4. 13-15 насны хүнийг долоо хоногт 5 хүртэл өдөр ажиллуулж болно.

5. 13-15 насны хүнийг хөнгөн ажил эрхлүүлэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан, насны онцлогт тохирсон хөдөлмөрийн нөхцөлөөр хангасан байна.

6. 13-15 насны хүнийг дараах нөхцөлд ажиллуулахгүй:

- 6.1. насанд хүрсэн хүний байнгын, шууд хяналтгүйгээр ажиллуулах;
- 6.2. тухайн ажил, үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай зохих сургалтад хамруулаагүй;
- 6.3. гэр бүлээсээ гадуур, нэг өдрөөс дээш удаан хугацаагаар хол байлгах;
- 6.4. ганцаараа эсхүл олон цагаар тусгаарлагдан ажиллуулах;
- 6.5. хүүхдийн хүсэл сонирхлыг харгалзан үзээгүй, хүүхэд өөрөө зөвшөөрөөгүй.

Эх сурвалжийн жагсаалт

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019 он.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он.
- Дайны байдлын тухай хууль, 1998 он.
- Дотоодын цэргийн тухай хууль, 2017 он.
- Зөрчлийн тухай хууль, 2017 он.
- Зэвсэгт хүчний тухай хууль, 2016 он.
- Иргэний хууль, 2002 он.
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2002 он.
- Нийгмийн даатгалын тухай хууль, 1994 он.
- Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998 он.
- Үндэсний их баяр наадмын тухай хууль, 2003 он.
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2006 он.
- Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он.
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2021 он.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012 он.
- Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он.
- Цэргийн албаны тухай хууль, 2016 он.
- Эрүүгийн хууль, 2015 он.

Олон улсын гэрээ, конвенц

- Аж үйлдвэрийн бус салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын конвенц, 1932 он..
- Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын конвенц, 1919 он.
- Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 59 дүгээр конвенц, 1937 он
- Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29 дүгээр конвенц, 1930 он.

- Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай НҮБ-ын нэмэлт конвенц, 1956 он.
- Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай ОУХБ-ын конвенц, 1965 он.
- Далайн тээвэр хийх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын конвенц, 1920 он.
- Далайн тээвэр хийх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын конвенц, 1936 он.
- Загас агнуурын салбарт хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын конвенц, 1959 он.
- Мансууруулах эм ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 87 дугаар конвенц, 1988 он.
- Мансууруулах эмийн тухай НҮБ-ын 84 дүгээр конвенц, 1961 он.
- Сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын конвенц, 1971 он.
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, 2000 он.
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенц, 1973 он.
- Хөдөө аж ахуйн салбарт ажиллах насны доод хязгаарын тухай конвенц, 1921 он.
- Хөлөг онгоцонд нүүрс ачих, галч хийх насны доод хязгаарын тухай конвенц, 1921 он.
- Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Палермогийн протокол, 2000 он.
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, 1999 он.
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, 1989 он.

Хэвлэмэл бүтээл

- ХЭҮК, Эрх зүйн судалгааны төв, ОУХБ, НҮБХС, Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх судалгааны тайлан, 2015 он.

- Хүүхдийн төлөө үндэсний газар, ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Барилгын салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тодорхойлох судалгаа, 2013 он.
- ҮСХ, ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2011-2012, 2013 он.
- ХЭҮК, Үндэсний цөөнх (цаатан) хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан, 2010 он.
- ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Казах, Тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал, 2010 он.
- Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төв, Гэрийн үйлчлэгч хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, 2010 он.
- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл суурь судалгаа, 2009 он.
- ЮНИСЕФ, Монгол Улсын хүүхдийн хөдөлмөр ба залуучуудын ажил эрхлэлтийг ойлгохуй, судалгааны тайлан, тойм, зөвлөмж, 2009 он.
- ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хөндийрүүлэх, нөхөн сэргээх орон нутгийн үйл ажиллагааны аргачлал (Орон нутагт суурилсан хөтөлбөрийн мониторинг), 2009 он.
- Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээлэл ба хүүхдийн хөдөлмөр, 2009 он.
- ҮСХ, Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2006-2007, 2008 он.
- ХЭҮК, Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, 2008 он.
- ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Хүүхдүүдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад хэвлэл мэдээллийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь, 2008 он.
- ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Улаанбаатар хот болон сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөрийн суурь судалгаа, 2008 он.
- ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хөндийрүүлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааны аргачлал /Орон нутагт суурилсан хүүхдийн хөдөлмөрийн мониторинг/, 2006 он.
- Хүн ам зүйн сургалт судалгааны төв, Албан бусаар алт, жонш олборлож буй хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа, 2005 он.
- Хүн амын сургалт судалгааны төв, ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн суурь судалгаа, 2005 он.
- МУИС-ын Хүн амын сургалт, судалгааны төв, ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн суурь судалгаа, 2005 он.
- ҮСХ, Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, 2004 он.
- Монголын хүүхдийн эрхийн төв, Хурдан морь унаж уралддаг хүүхдүүдийн эрх ашгийн тухай социологийн судалгаа, 2003 он.
- Хүн ам зүйн сургалт судалгааны төв, Алтны уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийн байдлын талаарх судалгаа, 2002 он.
- МУИС, Хүн ам зүйн сургалт судалгааны төв, Улаанбаатар хотын захууд дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн нөхцөл байдал, 2002 он.
- ОУХБ-ын АЙПЕК Хүүхдийн хөдөлмөрийг устгах хөтөлбөр, Хүүхдийн хөдөлмөр судалгааны үр дүнгийн цомог, 2001 он.
- Монголын хүүхдийн эрхийн төв, Норвегийн Хүүхдийг ивээх сан, Зах зээлийн үеийн

хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, 2000 он

- Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2021 он
- ҮСХ, “Коронавирус ба эдийн засаг”, 2021 оны 10 дугаар сар.
- Азийн хөгжлийн банк, “Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв” УБ, 2020 он.
- Монгол банк, Судалгааны тайлан №5, 2020 он.
- Дэлхийн зөн Монгол ОУБ, Тогтвортой хөгжлийн санаачилга ТББ, “Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал” судалгааны тайлан, 2021 он.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө, 2016 он.
- Нээлттэй нийгэм Форум, Залуучуудын дундах хүчирхийлэл хотын захын дүүрэгт хийсэн кэйс судалгааны тайлан, 2015 он.
- Бүх нийт боловсролын төлөө Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо, Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний сүлжээ, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах сүлжээ, ЭКПАТ Монгол сүлжээ, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, Дэлхийн Зөн Монгол ОУБ, НҮБ-ын Хүүхдийн эрхийн

тухай конвенцын хэрэгжилтийн талаар Монгол улсын тавдугаар тайлан илтгэлтэй холбогдуулан төрийн бус байгууллагын сүлжээдээс НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд илгээх илтгэл, 2015 он.

- ОУХБ, Тоглоомын дүрэм, 2014 он.
- Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөл, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, химийн хорт болон аюултай бодис, 2010 он.
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Монгол Улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ISCO-08), 2010 он.
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр 2008-2012.
- Албадан хөдөлмөрийг тодорхойлох ОУХБ-ын шалгуур үзүүлэлтүүд.

Гадаад хэвлэмэл бүтээл

- Committee on the Rights of the Child, Concluding observations on the fifth periodic report of Mongolia, 2017.
- International Labour Organization, Accelerating the 2030 Sustainable Development Goals through decent work: SDG monitoring and country profile for Mongolia, 2019.
- International Labour Organization, Child Labour Statistics, Manual on methodologies for data collection through surveys, SIMPOC, 2004.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар
Цахим шуудан: info@nhrcm.gov.mn
Цахим хуудас: nhrcm.gov.mn
Утас: 7000-0222